

МОНГОЛ УЛСЫН
БОРСЫН ФОНД



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 3

- Өмгөөллийн тухай Монгол Улсын хууль
- Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай Монгол Улсын Хууль
- Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай Монгол Улсын Хууль
- Төрийн албаны тухай Монгол Улсын Хууль
- Хүнсний тухай Монгол Улсын Хууль
- Гэр бүлийн хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Хууль
- Хөдөлмөрийн хуульд зарим өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Хууль



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ, ШИЙДВЭР,
ХУУЛИЙН ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

1995 оны 3 сар

№3/34/

ГАРЧИГ

I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Өмгөөллийн хууль	151
Стандартчилаал, чанарын баталгаажуулалтын тухай	178
Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай	175
Хууль хүчингүй болсонд тооцох тухай	187
Төрийн албаны тухай	188
Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	412
Хэлэлцээр соёрхон батлах тухай	413
Хүнсний тухай	414
Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	427
Гэр бүлийн хуульд өөрчлөлт оруулах тухай	428
Цахилгаан, дуулиан эрчим хүч, нүүрсний төлбөрийн тухай	428
Хууль хүчингүй болсонд тооцох тухай	429
Хөдөлмөрийн хуульд зарим өөрчлөлт оруулах тухай	429
Хот, тосгонн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	430
Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай	430

2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | |
|-----|--|-----|
| 16. | Хүнсний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 09 | 431 |
| 17. | Санал хураах комисс байгуулах тухай № 12 | 432 |
| 18. | Улсын Их Хурлын Байнгын хороодын дарга нарыг сонгох тухай № 13 | 433 |
| 19. | Цалинг тогтоох тухай № 14 | 434 |
| 20. | Улсын Их Хурлын Байнгын хороодын тусгай чиг үүргийг хуваарилах тухай № 15 | 434 |
| 21. | Зарим дүүргийг татан буулгах тухай № 16 | 435 |
| 22. | Д. Давасамбууг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай № 17 | 436 |
| 23. | Э. Бямбажавыг Сангийн сайдаар томилох тухай № 18 | 436 |
| 24. | Монгол Улсын Их Хурлын 1995 оны хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын тухай № 19 | 437 |

3. МОНГОЛ УЛСЫН БРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | |
|-----|--|-----|
| 25. | Доржийн Дашбалданг Ходолморийн гавъяаны улаан тугийн одонгоор шагнах тухай № 164 | 438 |
| 26. | Дамбийн Машлайг Ходолморийн гавъяаны улаан тугийн одонгоор шагнах № 165 | 438 |
| 27. | Намчингийн Энхмааг "Шударга журам" медалиар шагнах тухай № 166 | 439 |
| 28. | Д. Чулуундоржийг Элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай № 167 | 439 |
| 29. | Т. Чимэддоржийг Элчин сайдаар томилох тухай № 168 | 440 |
| 30. | Д. Чулуундоржийг Элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай № 169 | 440 |
| 31. | Т. Чимэддоржийг Элчин сайдаар томилох тухай | 441 |

4. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

- | | | |
|-----|--|-----|
| 32. | Цэцийн тухай хууль Үндсэн хууль зөрчсөн тухай маргааны талзар № 02 | 442 |
|-----|--|-----|

5. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | |
|-----|---|-----|
| 33. | Комисс байгуулах тухай № 222 | 446 |
| 34. | Эрүүл мэндийн даатгалын хураамж, даатгалтай аргэний эмчилгээний зардлын хувь, хэмжээг тогтоох тухай № 223 | 450 |
| 35. | Хувьчлалын санг байгуулах, зарцуулах журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай № 225 | 451 |
| 36. | Тогтоолын зарим заалтад өөрчлөлт оруулах тухай № 226 | 452 |
| 37. | "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч" шалгаруулж байх тухай № 228 | 453 |

6. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- | | | |
|-----|--|-----|
| 38. | Дээд шүүхийн бүгд хурлын 1993 оны 25 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай № 21 | 471 |
|-----|--|-----|

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 12 дугаар
сарын 9-ний өдөр

Улаанбаатар
хот

ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг онирхлыг хамгаалах, нийгмийн шударга ёсыг төлөвшүүлэхэд чиг-эсэн өмгөөлөл, хууль зүйн тусламцаа үзүүлэх үйл ажиллагаа цашид "өмгөөллийн үйл ажиллагаа" гэх /-ны зарчим, зохион бай-уулалт, өмгөөлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх баталгаатай олбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Өмгөөллийн тухай хууль тогтоомж

1. Өмгөөллийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ ууль, өмгөөлүүлэх эрхийг хангахтай холбогдсон хууль тогтоом-ийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр тасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Өмгөөллийн үйл ажиллагааны
нийтлэг зарчим

Өмгөөллийн үйл ажиллагаанд дараахь зарчим баримтална:

- 1/ хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг хангах, хууль дээдлэх;
- 2/ өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох;
- 3/ өмгөөллийн үйл ажиллагаа төрийн ивээлд байх, алиана бай-ууллага, албан тушаалтан өмгөөлөгчийн үйл ажиллагаанд хөнд-лөгөөс үл оролцох;
- 4/ өмгөөлөгч нь хуулийн хүрээнд өмгөөлүүлэгчийнхээ эрх, ашиг онирхлыг бүрэн, тууштай хамгаалах.

4 дүгээр зүйл. Өмгөөллийн үйл ажиллагааны төрөл

Өмгөөлөгч нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хууль зүйн тусламцаа үзүүлдэг:

- 1/ хууль зүйн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл, лавлагаа өгөх;
- 2/ эрх зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх зохиож тус-гах;

3/ иргэний хэрэг, захиргааны зөрчлийн талаар шүүх болон тө захиргааны байгууллагад төлөөлөх;

4/ хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа болон эрүүгий хэргийг шүүхээр шийдвэрлэхэд өмгөөлөгчөөр оролдох;

5/ иргэд, байгууллагын хүсэлтээр хууль тогтоомжид заас хууль зүйн бусад тусламцаа үзүүлэх.

5 дугаар зүйл. Өмгөөллийн үйл ажиллагааг
хэрэгжүүлэх

1. Хууль зүйн тусламцаа хүсэгч нь өмгөөлөгчид шууд ханда хэлцэл хийх буюу өмгөөлөгчдийн байгууллагад хүсэлт гарган Өмгөөлөгчдийн байгууллага мэргэжлийн өмгөөлөгчдийн нэр, хв гийн лавлагаа огч, хүссэн өмгөөлөгчийг нь томилно.

2. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага өмгөөлдүүлэх, хууль зүй тусламцаа авах эрхээ эдлэхэд туслахыг хүссэн тохиолдолд хэр бүртгэх, мөрдөн байцаах, шүүх, прокурорын байгууллага нь мэ гэжлийн өмгөөлөгчдийн болон өмгөөлөл эрхэлдэг байгууллага нэр, хавгийн лавлагааг өгөх үүрэгтэй.

3. Хууль зүйн тусламцаа хүсэгч нь эрүүл мэнд, гөлбөрийн чөдн болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар өмгөөлдүүлэх эрхээ оор хэрэгжүүлэх боломжгүй, түүнчлэн өмгөөлөгчөө сонгон авч чада гүй тохиолдолд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх, прокурорь байгууллага энэ тухай өмгөөлөгчдийн байгууллагад мэдэгдэн ө гөөлөгч томилуулах арга хэмжээ авах үүрэгтэй.

6 дугаар зүйл. Өмгөөллийн үйл ажиллагааны зохион
байгуулалт

1. Өмгөөлөгчдийн байгууллага нь өмгөөлөгчдийг эгнээнд нэгтгэсэн, ангийн төлөө бус олон нийтийн байгууллага бөгөөд д рвахь бүтэцтэй байна:

1/ Монголын өмгөөлөгчдийн холбоо;

2/ аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл.

2. Өмгөөлөгч нь товчоо байгуулан ажиллаж болно.

3. Өмгөөлөгчдийн холбоо, зөвлөл, товчоо нь хуулийн этгээдий эрх эдлэх бөгөөд өөрийгөө санхүүжүүлэх үндсэн дээр үйл ажилл гаагаа явуулна.

4. Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан Монг Улсын иргэн өмгөөлөл явууаж буй хэлбэрээс үл хамааран өмгө лөгчдийн олон нийтийн байгууллагад нэгдэнэ.

5. Монголын өмгөөлөгчдийн холбоо нь өмгөөлөгчдийг мэргэжл арга зүйн нэгдмэл удирдлагаар хангах, өмгөөлөгч бэлтгэх, сурга

звтан сургах, тэдгээрийн эрх, ашиг сонирхлыг төр, захиргаа, олон
ийтийн байгууллагад төлөөлөх, нийгмийн асуудлыг шийдвэрлэ-
эд туслахаа үзүүлнэ.

6. Холбооны зохион байгуулалт, үйл ажиллагааг дүрмээр зохи-
уулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Өмгөөлөгч, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, өмгөөлөгчийг бүртгэх

7 дугаар зүйл. Өмгөөлөгч

1. Хуульч мэргэжилтэй, ял шийтгэлгүй, өмгөөлөгчийн мэргэш-
ийн шаардлага хангасан, тогтоосон журмын дагуу сонгон шалга-
уулалтад орж өмгөөллийн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл авсан
онгол Улсын иргэн өмгөөлөгчөөр ажиллаж болно. Шүүгч, проку-
р, мордон байцаагч нь уул албан тушаалаасаа чөлөөлөгдсөнөөс
ойш 1 жилийн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг
риглано.

2. Иргэн өөрийгөө өмгөөлөх, энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан
шаардлага хангаагүй боловч итгэл бүхий, ял шийтгэлгүй этгээ-
эр өөрийгөө өмгөөлүүлэх эрхтэй.

3. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол өмгөөлөл эрхлэх эрх
хий гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг
всгэрт тогтоосон журмын дагуу өмгөөллийн үйл ажиллагааг эр-
аж болно.

8 дугаар зүйл. Мэргэжлийн хороо

1. Өмгөөлөгчөөр ажиллах хүнийг сонгон шалгаруулах орон тоо-
бус мэргэжлийн хороог хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн
эргий гишүүний шийдвэрээр байгуулна.

2. Мэргэжлийн хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд
үний дүрмийг Монголын Өмгөөлөгчдийн холбооны саналыг үн-
слэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батал-

9 дүгээр зүйл. Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох, өмгөөлөгчийг
бүртгэх

1. Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан, сонгон
лгаруулалтад тэнцсэн Монгол Улсын иргэнд өмгөөллийн үйл

ажиллагаа эрхлэх төвшөөрлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төвшөөрөл авсан иргэн Монголын өмгөөлөгчдийн холбоонд бүртгүүлж үйл ажиллагаа явуулна.

10 дугаар зүйл. Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхээс
чөлөөлөх, түдгэлзүүлэх

1. Өмгөөлөгч нь эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд өөрийнх нь хүсэлт буюу Монголын өмгөөлөгчдийн холбооны санаачлагаар өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхээс чөлөөлж, бүртгэлээс хасна.

2. Өмгөөлөгч эрүүгийн харууцлагад татагдсан тохиолдолд эцсийн шийдвэр гарах хүртэл эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг нь түдгэлзүүлж болно.

3. Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхээс чөлөөлөх, түдгэлзүүлэх шийдвэрийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу чөлөөлөгдсөн этгээд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт дахин гаргавал шинээр бүртгүүлнэ.

11 дүгээр зүйл. Өмгөөлөл эрхлэх эрхийг хасах

1. Өмгөөлөгч гэмт хэрэг үйлдсэн тухай шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон бол хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн өмгөөлөл эрхлэх эрхийг нь хасна.

2. Өмгөөлөгчийн болон хуульчийн ёс зүйн хэм хэмжээг удав дараа зөрчсөн бол Өмгөөлөгчийн сахиагын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн өмгөөлөл эрхлэх эрхийг нь 3 жил хүртэл хугацаагаар хасч болно.

3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу эрхээ хасуулсан өмгөөлөгч гомдлоо шүүхэд гаргаж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Өмгөөлөгчийн бүрэн эрх, үйл ажиллагааны баталгаа

12 дугаар зүйл. Өмгөөлөгчийн эрх

Өмгөөлөгч нь өмгөөлөл, төлөөллийн үйл ажиллагаа гүйцэтгэхдээ дараахь эрх үдэлнэ:

1/ хууль зүйн туслалцаа хүсэгчийн эрх, хууль зүйн ёсны ашиг сонирхлыг аль ч байгууллагад төлөөлөх;

2/ өмгөөлж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдолтой тэдгээрийн байгаа газарт чөлөөтэй нэвтрэн орж ганцаарчлан уулзах;

3/ эрүү, иргэний хэргийн нотлох баримттай танилцах, тэмдэглэл хийх, шаардлагатай материалыг өөрийн зардлаар хувилж хуулбарлан авах;

4/ нотлох баримт гаргаж өгөх, шинэ нотлох баримт шаардах буюу хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг шалгуулах, шинжээчийн дүгнэлт гаргуулах санал хүсэлт тавих;

5/ хэрэг бүртгэгч, байцаагч, шүүгч, прокурор, шүүх хурлын нарийн бичгийн дарга, иргэдийн төлөөлөгч, шинжээч, хэлмэрчийг хуульд заасан үндэслэл байвал татгалзах;

6/ хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, прокурорын үйл ажиллагаа, тэдгээрийн шийдвэрт гомдол гаргах;

7/ хууль зүйн туслалцаа үзүүлэхэд ач холбогдол бүхий баримт бичгийг байгууллага, аж ахуйн нэгжээс гаргуулах буюу хувилж хуулбарлан авах, тэмдэглэл хийх, баримт сэлтийг бэхжүүлэх зорилгоор дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглах;

8/ тусгай мэдлэг шаардагдах асуудлаар мэргэжлийн байгууллага, хүмүүсээс зөвлөгөө авах;

9/ хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон шүүхээр хэргийг хинан шийдвэрлэх ажиллагаанд байлцаж, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүнчлэн нэхэмжлэгч, хариуцагч болон бусад оролцогчдод асуулт тавих, өмгөөлүүдэгч, төлөөлүүдэгчийнхээ гаргаж буй мэтгүүлэг, тодорхойлолтод тайлбар, залруулга хийх;

10/ өөрийн байлцсан хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон шүүхээр хэргийг хинан шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэлтэй танилцаж санал хүсэлтээ бичгээр гаргах;

11/ давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд өөрийн санаачлагаар буюу шүүгдэгчийн хүсэлтээр оролцож санал, дүгнэлт гаргах;

12/ хууль тогтоомжид заасан бусад эрх

13 дугаар зүйл. Өмгөөлөгчийн үүрэг

1. Өмгөөлөгч нь дарвахь үүрэг биелүүлнэ:

1/ Үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон өмгөөлөгч, хуульчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих;

2/ өмгөөлүүлж, төлөөлүүлж байгаа этгээдийн эрх, хууль ёсны

ашиг сонирхлыг хуульд үл харшлах бүх арга, хэрэгслийг ашиглах бүрэн, тууштай хамгаалах;

3/ өмгөөлөл, төлөөллийн үүрэг гүйцэтгэх явцад олж мэдсэн төр, байгууллага, хувь хүн болон өмгөөлүүдэгч, төлөөлүүдэгчийн нууцыг задруулахгүй байх;

4/ өмгөөлөл байгууллагаас өгсөн томилолтыг биедүүлэх.

2. Өмгөөлөгч нь хууль зүйн туслалцаа авахыг хүсэгчийн эд хөрөнгө буюу эрхийг өөрийн болон бусад этгээдийн нэрээр худалдан авах, эсхүл өөр бусад аргаар олж авах, эзэмшихийг хориглоно.

14 дүгээр зүйл. Өмгөөлөгчийн үйл ажиллагааны баталгаа

1. Өмгөөлөгч мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахад түүнд хэн ч шахаат, дарамт үзүүлэх буюу хөндлөнгөөс оролцох, саад учруулах, ямар нэг баталгаа шаардах, заналхийлэхийг хориглоно.

2. Өмгөөлөгчөөс мэргэжлийн үүргээ биедүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, мэдээ сээтийг холбогдох байгууллага, албан тушаалтан саадгүй гаргаж өгөх үүрэгтэй.

3. Өмгөөлөл үйл ажиллагааны явцад олж мэдсэн зүйлтэй нь холбогдуулан өмгөөлөгчийг гэрчээр байцаах, холбогдох мэдээллийг өмгөөлөгч болон өмгөөлөл эрхэлдэг байгууллагын ажилтнаас гаргуулж авахаар шаардаж үл болно.

4. Өмгөөллийн үйл ажиллагаанд холбогдох мэргэжлийн нууцыг хуулиар хамгаална.

5. Төр, захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага өмгөөлөгч, өмгөөлөгчдийн байгууллага үйл ажиллагаагаа явуулах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

15 дугаар зүйл. Өмгөөллийн нууц

1. Өмгөөлөгчөөс туслалцаа хүссэн тодорхой асуудал, үйл баримт, өмгөөлөгчийн өгсөн зөвлөгөө, тайлбар, түүнчлэн өмгөөлөгч, туслалцаа авагч хоёрын хоорондын амничилсан ярианд холбогдох мэдээ болон бусад баримт сэлт нь өмгөөллийн нууцад хамаарна.

2. Өмгөөлөгч, өмгөөлөгчдийн байгууллагын ажилтан өмгөөллийн нууцыг задлах, эсхүл амиа хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд ашиглахыг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

16 дугаар зүйл. Өмгөөлөгчийн хөдөлмөрийн хөлс

1. Өмгөөлөл, хууль зүйн бусад туслалцааг төлбөртэй үзүүлэх бөгөөд энэ нь өмгөөлөгчийн хөдөлмөрийн хөлсний эх сурвалжийг бүрдүүлнэ.

2. Хууль зүйн туслалцаа үзүүлэхэд төлөх хөлсний жишгийг Монголын өмгөөлөгчдийн холбооны саналыг үндэслэн хууль зүйн болон хүн амын бодлого, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран тогтооно.

3. Өмгөөллийн хөлсний хэмжээг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу тогтоосон жишигт багтаан хууль зүйн туслалцаа авагч, өмгөөлөгч нар харилцан тохиролцож тогтооно. Талууд тохиролцвол хөлсний хэмжээг жишигт зааснаас ихэсгэх буюу багасгаж болно.

4. Өмгөөлөгчийн хөдөлмөрийн хөлсний 6 хувийг Монголын өмгөөлөгчдийн холбоонд, 4 хувийг өмгөөлөгчийн хариуцлагын даатгаад төвлөрүүлнэ.

17 дугаар зүйл. Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардал

Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Энэхүү зардлыг санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл, монголын өмгөөлөгчийн холбооны саналыг үндэслэн хууль зүй, хүн амын бодлого, хөдөлмөрийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран тогтооно.

18 дугаар зүйл. Өмгөөлөгчийн хариуцлага

1. Өмгөөлөгчийн хариуцлагагүй ажиллагааны улмаас хууль зүйн туслалцаа авагчид эд хөрөнгийн хохирол учирсан бол уул хохирлыг нөхөн төлүүлнэ.

2. Өмгөөлөгч гэрээнд заасан туслалцаа үзүүлээгүй бол хөлсийг уцааж төлнө.

3. Хууль тогтоомж, өмгөөлөгчийн болон хуульчийн ёс зүйн хэмжээг зөрчсөн өмгөөлөгчид сахилгын дараахь шийтгэл ногдуулна:

1/ сануулах;

2/ өмгөөлөл эрхлэх эрхийг нь хасах тухай урьдчилан сануулах;

3/ өмгөөлөл эрхлэх эрхийг хасах.

4. Өмгөөлөгч сахилгын зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

5. Өмгөөлөгчид сахилгын шийтгэл ногдуулах журам, сахилгын зөвлөлийн дүрмийг Монголын өмгөөлөгчдийн холбооны саналыг үндэслэн Хууль зүйн сайд батална.

19 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 12 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

СТАНДАРТЧИЛАЛ, ЧАНАРЫН БАТАЛГАА ЖУУЛАЛТЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь стандартчилал, чанарын баталгаажуулалт, стандарт, чанарын хяналтын эрх зүйн үндсийг тодорхойлж тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хууль тогтоомж

1. Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

СТАНДАРТЧИЛАЛ

3 дугаар зүйл. Стандартчилал, түүний зарчим

1. Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ /цаашид "бүтээгдэхүүн" гэх/-ний харилцан орлолт, аюулгүй байдал, мэдээлэл, техник, хэмжил, сорилтын нийцтэй, нэгдмэл байдлыг хангах зорилгоор нийтлэг бөгөөд дахин давтан хэрэглэх журам тогтоох үйл ажиллагааг стандартчилал гэнэ.

2. Стандартчиллын объектын үзүүлэлт, шаардлагын хэм хэмжээг сонирхогч талууд харилцан тохиролцон боловсруулж, эрх бүхий байгууллага зохих журмын дагуу баталсан норматив-техникийн баримт бичгийг стандарт гэнэ.

3. Стандартчилалд дараах зарчмыг баримтлана:

1/ төр, үйлдвэрлэгч, хэрэглэгч тэгш эрхтэйгээр оролцох;

2/ нийгмийн эрх ашигт нийцэх;

3/ бие даасан, хараат бус байх;

4/ стандарт нь шинжлэх ухаан, технологийн сүүлийн үеийн түүний, практикийн ололтод тулгуурласан, төвч тодорхой агуулгатай байх.

4 дүгээр зүйл. Стандартын ангилал

1. Стандартыг хэрэглэх хүрээгээр нь Монгол Улсын /цаашид "улсын" гэх/ болон аж ахуйн нэгж, байгууллага /цаашид "байгууллагын" гэх/-ийн гэж ангилна.

2. Улсын стандартыг албан журмын шинжтэй зөвлөмжийн стандарт гэж тус тус ялгана.

5 дугаар зүйл. Улсын стандарт

1. Заавал мөрдөх улсын стандарт, улсын зохих стандартын заавал мөрдөх үзүүлэлт, шаардлагыг дараахь объектод тогтооно:

1/ хүний эрүүл мэнд, байгаль орчин, маа, амьтанд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүний үзүүлэлт, шаардлага;

2/ хөдөлмөрийн болон бусад нөхцөлд тавих шаардлага, хөдөлгөөр хамгаалал, аюулгүй байдлын арга ажиллагаа;

3/ эдийн засаг, нийгмийн чухал ач холбогдол бүхий бүтээгдэхүүний үзүүлэлт, шаардлага;

4/ техник, технологийн хүрээнд бүтээгдэхүүний харилцан орлолт, хэмжлийн болон мэдээллийн нэгдмэл, үнэн зөв байдлыг хан

гах үзүүлэлт, хэм хэмжээ, зохион байгуулалт-арга зүйн нийтлэг шаардлага;

5/ байгаль орчим төлөв байдлыг болон бүтээгдэхүүн, хөдөлмөрийн нөхцөлийг шалгах, сорих, шинжлэх, хэмжих арга.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан объектын дэлгэрэнгүй жагсаалтыг Засгийн газар батална.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан жагсаалтад ороогүй объектод хэрэглэх улсын стандарт нь сайн дурин шинжтэй зөвлөмжийн байх бөгөөд уг стандартын үзүүлэлт, шаардлага нь олон улс, бүс нутаг, гадаад улсын дэвшилттэй стандартын түвшинд хүрсэн байвал зохино.

4. Улсын стандарт нь зохиогчийн эрхэд хамварах бүтээл болохгүй.

5. Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллага улсын стандарт боловсруулах, шинэчлэх талаар сонирхогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын саналыг хянаж стандартчиллын хөтөлбөрт тусгана.

6. Улсын стандартыг стандартчиллын хөтөлбөрт заасан байгууллага сонирхогч талуудтай зөвшилцөн боловсруулж, Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллагын зөвлөл батлан улсын бүртгэлд бүртгэнэ.

7. Улсын стандарт нь товчилсон тэмдэглэгээ болон улсын бүртгэлийн дугаартай байх бөгөөд түүнийг баталсан шийдвэрт өөрөөр заагаагүй бол бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

8. Аж ахуйн нэгж, байгууллага нь гэрээ, холбогдох баримт бичигт заавал мөрдөх улсын стандартыг хэрэглэх тухай заалтыг тусгана.

6 дугаар зүйл. Байгууллагын стандарт

1. Байгууллагын стандартыг дараахь объектод тогтоож болно:

1/ энэ хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан жагсаалтад ороогүй объект;

2/ улсын стандартын үзүүлэлт, шаардлагыг өндөржүүлсэн буюу дэлгэрүүлсэн хэм хэмжээ.

2. Байгууллагын стандарт нь заавал мөрдөх улсын стандартын үзүүлэлт, шаардлагад харшлахгүй байна.

3. Байгууллагын стандартыг боловсруулах, батлах, түүний үзүүлэлт, шаардлагыг заавал мөрдөх улсын стандартад нийцүүлэх аймаг, нийслэлийн стандартчилал, баталгаажуулалтын байгууллагад бүртгүүлэх ажилг аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

4. Байгууллагын стандарт нь товчилсон тэмдэглэгээ болон нутаг дэвсгэрийн бүртгэлийн дугаартай байх бөгөөд түүнийг баталсан шийдвэрт өөрөөр заагаагүй бол бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

7 дугаар зүйл. Стандарт хэрэглэх.

1. Аж ахуйн нэгж, байгууллага нь бүтээгдэхүүнийг улсын буюу байгууллагын хүчин төгөлдөр стандартын дагуу үйлдвэрлэнэ.

2. Аж ахуйн нэгж, байгууллага нь хууль тогтоомж, үйлдвэрлэгчийн болон хэрэглэгчийн эрх ашигт харшлахваргүй, хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд сөрөг нөлөө үзүүлдэхээргүй олон улс, бүс нутаг, гадаад улсын дэвшилттэй стандартыг зохих журмын дагуу бүртгүүлэн хэрэглэж болно.

3. Шинэ технологи, бүтээгдэхүүн эзэмшиж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад Монгол Улсад хэрэглэхээр зааснаас өөр стандартыг түр хэрэглэх зөвшөөрлийг Стандартчилаа, баталгаажуулалтын төв болон аймаг, нийслэлийн байгууллагаас олгож болно.

4. Аж ахуйн нэгж, байгууллага улсын буюу байгууллагын стандартгүйгээр бүтээгдэхүүнийг бөөнөөр үйлдвэрлэх, эсхүл хүчин төгөлдөр бус стандарт хэрэглэх, стандартын шаардлага хангаагүй бүтээгдэхүүнд стандартын тэмдэглэгээ тавихыг тус тус хориглоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

8 дугаар зүйл. Бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалт, түүний хэлбэр, хүрээ

1. Тухайн бүтээгдэхүүн нь холбогдох стандарт, бусад норматив-техникийн баримт бичигт тогтоосон үзүүлэлт, шаардлагад тохирч байгааг эрх бүхий байгууллагаас баримт бичгээр нотлох ажиллагааг чанарын баталгаажуулалт гэнэ.

2. Аж ахуйн нэгж, байгууллага нь хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй болон энэ хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүтээгдэхүүнийг чанарын баталгаажуулалтад заавал хамруулна.

3. Аж ахуйн нэгж, байгууллага энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад бүтээгдэхүүнийг сайн дураар чанарын баталгаажуулалтад хамруулж болно.

4. Зохих гэрээнд өөрөөр заагаагүй бол чанарын баталгаажуулалтыг улсын стандарт, холбогдох норматив-техникийн баримт бичигт үндэслэн явуулна.

5. Тухайн бүтээгдэхүүнд хэрэглэх улсын стандартгүй тохиолдолд Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллагаас зөвшөөрсөн олон улс, бүс нутаг, гадаад улсын стандартад үндэслэн чанарын баталгаажуулалт явуулж болно.

6. Бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалтыг Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллага, эсхүл түүнээс чанарын баталгаажуулалт хийх эрх авсан байгууллага явуулна.

9 дүгээр зүйл. Лаборатори итгэмжлэх

1. Эрх бүхий байгууллагаас тухайн лаборатори бүтээгдэхүүний нэг буюу хэд хэдэн үзүүлэлтийг холбогдох стандарт, аргачлалын дагуу үнэн зөв, зохих магадлалтайгаар тодорхойлох сорилт, туршилт, шинжилгээ /цаашид "сорилт" гэх/ хийх чадвартайг нь тогтоож, уг сорилтыг хийх эрх олгох үйл ажиллагааг лаборатори итгэмжлэх гэнэ.

2. Дараахь шаардлагыг хангасан лабораторид Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллага итгэмжлэл олгоно:

1/ тухайн бүтээгдэхүүний сорилтын дүнг үйлдвэрлэгч, борлууллагчаас хараат бусаар гаргах нөхцөл бүрдүүлсэн байх;

2/ сорилтыг улсын стандарт, эрх бүхий байгууллагаас баталсан аргачлалын дагуу явуулах зориулалтын, өндөр нарийвчлал бүхий баталгаатай багаж, төхөөрөмж тэй байх;

3/ ажиллагсад нь зохих мэргэшил, туршлагатай байх;

4/ сорилт явуулахад шаардагдах улсын стандарт, аргачилал, стандартчилсан загвар, холбогдох бусад материалыг хүрээлэхүйц хэмжээгээр бүрдүүлсэн байх;

5/ сорилт явуулах нөхцөл, орчинг улсын холбогдох стандартын дагуу хангасан байх.

3. Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн лабораторийг итгэмжлүүдэх тухай хүсэлтээ энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан тухай танилцуулгын хамт Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллагад гаргана.

4. Сорилтын дүнгийн талаарх итгэмжлэгдсэн лаборатори хоорондын маргааныг Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллага шийдвэрлэнэ.

5. Лаборатори итгэмжлэх журмыг Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллага тогтооно.

10 дугаар зүйл. Итгэмжлэгдсэн лабораторийн
эрх, үүрэг

Итгэмжлэгдсэн лаборатори нь дараахь эрх, үүрэгтэй байна:

1/ сорилтыг Стандартчилал, баталгаажуулалттай төв байгууллагаас тогтоосон төрөл, чиглэлийн хүрээнд улсын стандартын дагуу явуулж зохих дүгнэлт гаргах;

2/ сорилтын дүнгийн талаар итгэмжлэгдээгүй лаборатори хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх;

3/ чанарын гэрчилгээ, тохирлын тэмдэгтэй бүтээгдэхүүнд сорилт хийж стандартчилал, баталгаажуулалтын холбогдох байгууллагад мэдээлэх;

4/ сорилтын дүнгийн үнэн зөв, магадгүй байдлыг бүрэн хариуцах;

5/ сорилтын ажилд шаардагдах стандарт, норматив-техникийн баримт бичгийг боловсруулах;

6/ энэ зүйлийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан өөрийнх нь үйл ажиллагааны нөхцөл, шаардлага өөрчлөгдсөн тохиолдолд итгэмжлэл хүлээлгэсэн байгууллагад мэдээлэх.

11 дүгээр зүйл. Чанарын баталгаажуулалт
явуулах журам

1. Аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи тогтворжиж, чанарын удирдлага, дотоод хяналтын тогтолцоо бүрдэж хэмжсэн, улсын зохих стандарт, бусад норматив-техникийн баримт бичгээр тогтоосон үзүүлэлт, шаардлагыг хангасан тухай танилцуулга болон бүтээгдэхүүнийхээ чанарыг баталгаажуулах тухай хүсэлтээ итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн, дүгнэлтийн хамт энэ хуулийн 8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан байгууллагад огноо.

2. Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан танилцуулга, хүсэлт, сорилтын дүн, дүгнэлтийг үндэслэн чанарын баталгаажуулалтын шалгалт явуулна.

3. Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан байгууллага чанарын баталгаажуулалтын шалгалтад бүтээгдэхүүн нь гэнцсэн аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан уг бүтээгдэхүүндээ зохих стандартад тохирсоныг илэрхийлэх чанарын гэрчилгээ, тохирлын тэмдэг хэрэглэх эрх олгоно.

4. Чанарын гэрчилгээ, тохирлын тэмдэг хэрэглэх эрх олгосон нь үүний эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагад чанар муутай

бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулснаас хэрэглэгчид хөхирол учруулсан тохиолдолд түүнд зохих хариуцаага хүлээлгэхээс чөлөөлөхгүй.

5. Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн бүтээгдэхүүний чанарыг удирдлагын иж бүрэн тогтолцоог энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1 дахь хэсэгт заасан байгууллагаар үнэлүүлж гэрчилгээ авч болно.

12 дугаар зүйл. Импорт, экспортын бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах

1. Аж ахуйн нэгж, байгууллага импорт, экспортоор бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулахдаа түүний чанар, ажуулгүй байдлын талаарх Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх тухай заалтыг тусгана.

2. Чанарын баталгаажуулалтад заавал хамрагдах импорт, экспортын бүтээгдэхүүний жагсаалт, тэдгээрийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, шалгах журмыг Засгийн газар батална.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан импортын бүтээгдэхүүн нь холбогдох стандартад тохирсныг гэрчилж тухайн гадаад улсын эрх бүхий байгууллагаас олгосон чанарын гэрчилгээ, тохиромж тэмдэг буюу сорилтын дүнтэй байна.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан чанарын гэрчилгээ болон тохиромж тэмдгийн загвар, сорилтын дүнг тэмдэглэх маягтыг Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн байна.

5. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүтээгдэхүүнд зохих сорилт шалгалт хийсний үндсэн дээр экспортын бүтээгдэхүүнд чанарын гэрчилгээ, импортын бүтээгдэхүүнд борлуулах зөвшөөрлийг зөвхөн Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллага буюу түүнээс чанарын баталгаажуулалт хийх эрх авсан байгууллага олгоно.

6. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан журмыг зөрчиж бүтээгдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮДЭГ

СТАНДАРТ, ЧАНАРЫН ХЯНАЛТ

13 дугаар зүйл. Стандарт, чанарын төрийн хяналт, түүний хүрээ

1. Стандарт, чанарын төрийн хяналт нь стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн

аргасан эрх бүхий байгууллагын шийдвэр, заавал мөрдөх улсын стандартын мөрдөлтөд бүтээгдэхүүний зураг төслийг зохион боловсруулах, түүнийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, борлуулах, эрэглэх болон хягдал ашиглах шатанд хяналт тавьж, илэрсэн орчлийг таслан зогсооход чиглэгдэнэ.

2. Стандарт, чанарын төрийн хяналтад дараахь зүйлийг хамруулна.

1/ заавал мөрдөх улсын стандарт, улсын стандартын заавал мөрдөх үзүүлэлт, шаардлагын мөрдөлт;

2/ энэ хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүтээгдэхүүн чанарын баталгаажуулалтад хамрагдсан байдал;

3/ импорт, экспортын бүтээгдэхүүний чанар;

4/ бүтээгдэхүүний чанарын ангилал, тэрэглэл, сорилт, чанарын баталгаажуулалтын үнэн зөв байдал;

5/ чанарын тэрчилгээ, бооцоор үйлдвэрлэх зөвшөөрөлтэй бүтээгдэхүүний чанар, ажуулгүй байдал;

6/ стандартчилал, чанарын баталгаажуулалт, хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаарх хууль тогтоомжийн биелэлт.

14 дүгээр зүйл. Стандарт, чанарын төрийн хяналтын зохион байгуулалт.

1. Стандарт, чанарын төрийн хяналтыг улсын хэмжээнд Стандартчилал, баталгаажуулалтын төв болон түүнээс стандартчилал, баталгаажуулалтыг хэрэгжүүлэх эрх авсан орон нутгийн байгууллага зохицуулан зохион байгуулна.

2. Стандарт, чанарын төрийн хяналтыг улсын байцаагчид хэрэгүүдэх бөгөөд тэдгээр нь тогтоосон журмын дагуу олгосон зэрэг, итгэй байна.

3. Стандарт, чанарын төрийн хяналтын улсын байцаагчийг даахь байдлаар томилж, чөлөөлнө:

1/ улсын Ерөнхий байцаагчийг стандартчиллын асуудал эрхэлн Монгол Улсын сайд;

2/ Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллагын улсын ахлах болон улсын байцаагчийг Улсын Ерөнхий байцаагчийн иалыг үндэслэн стандартчиллын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд;

3/ аймаг, нийслэлийн стандартчилал, баталгаажуулалтын байгууллагын улсын ахлах болон улсын байцаагчийг улсын Ерөнхий байцаагчийн саналыг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга;

4/ Энэ зүйлийн 3 дахь хэсгийн 1, 2, 3-т зааснаас бусад улсын бай-

цвагчийг улсын Ерөнхий байцаагчийн саналыг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга.

4. Стандарт, чанарын төрийн хяналтыг хэрэгжүүлэхэд хөдөлмөрийн нөхцөл, хүн, малын эмнэлэг, эм, био бэлдмэл, эрүүд ахуй байгаль орчин, мал, амьтны үржил, үр, ургамал хамгаалал, эрчим хүч, уул уурхай, барилга, тээвэр, холбоо, худалдааны зэрэг мэргэжлийн хяналтын албад оролцох бөгөөд энэ талаарх үйл ажиллагааг стандарт, чанарын төрийн хяналтын улсын Ерөнхий байцаагч зохицуулна.

5. Стандарт, чанарын төрийн хяналтын алба хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд сорог нодоо үзүүлж болзошгүй бүтээгдэхүүний талаар иргэний мэдээллийн дагуу шалгаат явуулж болох бөгөөд үнэн зөв, чухал мэдээлэл өгсөн иргэнийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу урамшуулах буюу мэдээллийг худалдан авч болно.

6. Стандарт, чанарын төрийн хяналтын улсын байцаагч төрийн хяналт хэрэгжүүлэхэд шаардагдах бүтээгдэхүүний дээж, сорьцыг зохих стандартын дагуу авч протокол үйлдэнэ. Эдгээрдээж, сорьцны үнэ, дээж авах, бэлтгэх, тээвэрлэх, шинжлэх зэрэг зардлыг уг аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

15 дугаар зүйл. Стандарт, чанарын төрийн хяналтын улсын байцаагч

1. Стандарт, чанарын төрийн хяналтын улсын байцаагч дараахь бүрэн эрхтэй:

1/ энэ хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан заалтын хэрэгжилтэд хяналт тавих;

2/ хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, борлуулах, импорттоор нийлүүлэх, улсын стандартад тохироогүй хөдөлмөрийн нөхцөлд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахыг зогсоох, уг бүтээгдэхүүнийг зохих журмын дагуу устгуулах;

3/ стандартгүй бөөнөөр үйлдвэрлэл явуулах эсхүд, заавал мөрдөх улсын стандарт зөрчиж буюу хүчин төгөлдөр бус стандарт хэрэглэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, улсын хилээр нэвтрүүлэхийг тус тус хориглох;

4/ стандарт, чанарын төрийн хяналтыг хэрэгжүүлэхдээ аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, мэдээ баримтыг авч танилцах, шаардлагатай багаж төхөөрөмж хэрэглэх;

5/ илэрсэн зөрчлийг арилгуулах талаар хэлбөгдөх аж ахуйн нэгж, байгууллагад шаардлага тавих, хугацаатай үүрэг өгч, гүйцэтгэлийн хариуг товлосон хугацаанд авах;

6/ стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд зохих хариуцлага хүлээлгэх.

2. Стандарт, чанарын төрийн хяналтын улсын байцаагчгаас дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1/ аливаа аж ахуйн нэгж, байгууллагын болон иргэний хувийн ашиг сонирхлыг төлөөлөх, эдгээрт ашигтай давуу тал бий болгосон шийдвэр гаргах;

2/ шалгалтын дүн болон хэлбөгдөх аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны нууцыг задруулах;

3/ стандарт, чанарын төрийн хяналт хэрэгжүүлэхэд олгосон бүрэн эрх, хөрөнгө, техник, хэргслээ зориулалт бусаар ашиглах.

16 дугаар зүйл. Стандарт, чанарын олон нийтийн хяналт

1. Стандартчилал, чанарын баталгаажуулалт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн байгууллага, түүний төлөөлөгч хяналт тавьж зохих үзлэг хийж болно.

2. Олон нийтийн байгууллага хяналтын талаарх санал, мэдээллийг стандарт, чанарын төрийн хяналтыг эрхэлсэн болон эрх бүхий бусад байгууллагад өгч болно.

3. Иргэн, олон нийтийн байгууллага, түүний төлөөлөгч нь стандарт, чанарын төрийн хяналтын ажилд хамтран оролцож болно.

4. Олон нийтийн байгууллага нь зохих хууль тогтоомжийн хүрээнд шалгуулагч аж ахуйн нэгж, байгууллагаас стандартчилал, чанарын баталгаажуулалтын талбарх мэдээ, баримтыг авч танилдах, дутагдлыг арилгуулах талаар шаардлага тавих эрхтэй.

ТАВДУГААР БҮЛЭГ

СТАНДАРТЧИЛАЛ, ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА

17 дугаар зүйл. Стандартчилал, баталгаажуулалтын байгууллагын тогтолцоо

Стандартчилал, баталгаажуулалтын байгууллагын тогтолцоо нь Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллага болон гүүнээс стандартчилал, баталгаажуулалтыг хэрэгжүүлэх эрх

авсан орон нутгийн стандартчилал, баталгаажуулалтын байгууллагаас бүрдэнэ.

18 дугаар зүйл. Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллага

1. Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллага нь улсын хэмжээнд стандартчилал, чанарын баталгаажуулалт, сорилт, стандарт, чанарын төрийн хиналтын ажил эрхлэх төрийн захиргааны байгууллага мөн.

2. Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллага нь дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1/ стандартчилал, сорилт, чанарын баталгаажуулалтын талаарх төрийн бодлого, стандарт, чанарын төрийн хиналтыг хэрэгжүүлэх;

2/ стандартчилал, чанарын удирдлага, баталгаажуулалт, сорилтын асуудлаар шинжлэх ухаан техникийн төслийн ажил хийх;

3/ эрхэлсэн асуудлаар мэдээлэл-арга зүйн туслалцаа үзүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах.

3. Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллага нь дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1/ улсын хэмжээнд стандартчилал, чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлэх, улсын стандартын улсын бүртгэлд бүртгэж, албан ёсоор мэдээлэх;

2/ энэ хууль болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн зохих заалтын биелэлт, улсын стандартын мөрдөлт, импорт, экспортын бүтээгдэхүүний чанарт төрийн хиналт тавих;

3/ улсын хэмжээнд стандартчилал, чанарын баталгаажуулалт, сорилт, стандарт, чанарын төрийн хиналтыг нэгдсэн арга зүйн удирдлагаар хангах, холбогдох заавар, маягтыг батлан мөрдүүлэх;

4/ салбар дундын болон ерөнхий техник, зохион байгуулалт, арга зүйн улсын стандарт, шаардлагатай тохиолдолд заавал мөрдөх улсын стандартыг боловсруулах;

5/ бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалт явуулах, сорилт хийх;

6/ монголын болон олон улс, бүс нутаг, гадаад улсын стандарт, норматив-техникийн бусад баримт бичгээр төв санг бүрдүүлэн төрөлжсөн архивын хэлбэрээр ажиллуулах;

7/ зохих стандартад тохироогүй, чанар муутай буюу сайн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, борлуулагчийн талаар болон итгэмжлэгдсэн лаборатори, чанарын гэрчилгээ, тохирлын тэмдэгтэй бүтээгдэхүүний тухай олон нийтэд мэдээлэх.

8/ стандартчиллын техникийн хороодыг байгуулах, тэдгээрийн дүрмийг баталж үйл ажиллагааг нь зохицуулах;

9/ лаборатори итгэмжлэх, мэргэжлийн байгууллагад чанарын баталгаажуулалт хийх эрх олгох;

10/ эрхэлсэн асуудлаараа судалгаа, шинжилгээний ажил хийх;

11/ аж ахуйн нэгж, байгууллагын захиалга, гэрээний дагуу төлбөртэй ажил, үйлчилгээ, сургалт явуулах, улсын стандартыг хэвлэн борлуулах;

12/ эрхэлсэн асуудлаараа олон улсын байгууллагад гишүүнээр элсэх, олон улс, бүс нутаг, гадаад улсын холбогдох байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх.

4. Засгийн газар Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллагын дүрмийг батална.

19 дүгээр зүйл. Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллагын зөвлөл

1. Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллага нь төрийн бодон олон нийт, шинжлэх ухааны холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөгчдөөс бүрдсэн стандартчиллын үйл ажиллагаанд оролцогч талуудын тэгш байдлыг хангах зорилго бүхий орон тооны бус зөвлөлтэй байна.

2. Зөвлөл дараахь асуудлыг эрхэлнэ:

1/ улсын стандарт, стандартчиллын хөтөлбөр, холбогдох дүрэм, курмыг батлах, хүчингүй болгох;

2/ хууль тогтоомжид нийцүүлэн стандартчилал, чанарын баталгаажуулалтын ажлын хэтийн бодлого, чиглэлийг тодорхойлох;

3/ стандартчилал, чанарын баталгаажуулалт, сорилт, стандарт, чанарын төрийн хяналтын талаарх нэгдсэн дүнг хэлэлцэж зохих шийдвэр гаргах.

3. Зөвлөлийн гишүүдийг Засгийн газар томилно.

4. Зөвлөлийг Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллагын Ерөнхий захирал толгойлно.

20 дугаар зүйл. Орон нутгийн стандартчилал, баталгаажуулалтын байгууллага

1. Аймаг, нийслэлийн Засаг дарга аймаг, нийслэлийн стандартчилал, баталгаажуулалтын байгууллагыг байгуулан ажиллуулж, Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллага түүнд стандартчилал, баталгаажуулалтыг хэрэгжүүлэх эрх олгоно.

2. Аймаг, нийслэлийн стандартчилал, баталгаажуулалтын байгууллагын удирдлагыг Стандартчилал, баталгаажуулалтын төв

байгууллагын саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга томилж чөлөөлнө.

3. Аймаг, нийслэлийн Стандартчилал, баталгаажуулалтын байгууллага дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1/ нутаг дэвсгэртээ энэ хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 3-т заасан үндсэн чиг үүрэг, мөн зүйлийн 3 дахь хэсгийн 2, 5, 7, 11-д заасан үйл ажиллагааг тус тус хэрэгжүүлэх;

2/ тухайн нутаг дэвсгэрт хэрэглэх улсын болон байгууллагын стандарт боловсруулах ажлыг зохицуулах, байгууллагын стандартын нутаг дэвсгэрийн бүртгэл хөтлөх;

3/ стандартын салбар сан ажиллуулах.

4. Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллага нь хилийн боомт, гүний гааль зэрэг шаардлагатай газарт стандарт, чанарын төрийн хяналтын албыг байгуулна.

21 дүгээр зүйл. Стандартчилал, чанарын баталгаажуулалтад оролцогч бусад байгууллага

1. Төрийн захиргааны төв байгууллага нь:

1/ тухайн чиглэл, салбарын техникийн бодлогыг стандартчилал, чанарын баталгаажуулалтад зөв тусгаж хэрэгжүүлнэ;

2/ салбарын мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлнэ;

3/ тухайн чиглэл, салбарын стандарт боловсруулах техникийн хороог ажиллуулна;

4/ мэргэжлийн лабораториудыг бэхжүүлэх, тэдгээрийн техникийн түвшинг дээшлүүлэх арга хэмжээ авна.

2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь:

1/ нутаг дэвсгэртээ орон нутгийн стандартчилал, чанарын баталгаажуулалтын байгууллагыг санхүүжүүлж, шаардагдах техник хэрэгслээр хангана;

2/ нутаг дэвсгэртээ стандартчилал, чанарын баталгаажуулалт, хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулна.

3. Стандартчиллын техникийн хороо нь:

1/ сонирхогч иргэн, өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгч, мэргэжилтнээс бүрдсэн Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллагын бодлого, чиглэлийн дагуу орон тооны бус хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулна;

2/ тодорхой чиглэлээр олон улс, бүс нутаг, улсын стандарт бодом стандартчиллын хөтөлбөр боловсруулж батлуулна;

3/ эрхэлсэн асуудлаараа зөвлөмж гаргана.

4. Олон нийтийн байгууллага нь:

1/ өөрийн төлөөлөгчийг техникийн хорооны үйл ажиллагаанд оролцуулах;

2/ стандарт боловсруулах, хэрэглэх талаарх саналыг стандартчилал, баталгаажуулалтын холбогдох байгууллагад танилцуулах;

3/ стандартчилал, чанарын баталгаажуулалт, хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлаар төрийн болон бусад байгууллага, аж ахуйн нэгжид санал тавьж хэрэглэгчдэд мэдээлэх;

4/ стандартчиллын төв байгууллагатай гэрээ байгуулсаны дагуу стандартчилал, чанарын баталгаажуулалтын тодорхой чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхтэй.

5. Аж ахуйн нэгж, байгууллага нь:

1/ заавал мөрдөх улсын стандарт, бусад норматив-техникийн баримт бичиг, гэрээнд заасан үзүүлэлт, шаардлагыг биелүүлэх;

2/ өөрийн бүтээгдэхүүнд холбогдолтой улсын стандартыг боловсруулах ажлыг санхүүжүүлэх;

3/ өөрийн бүтээгдэхүүнийг чанарын баталгаажуулалтад хамруулахтай холбогдсон зарлагыг хариуцах;

4/ бүтээгдэхүүнийхээ чанар, аюулгүй байдлыг хангаж тэдгээрийг хэрэглэгч болон стандарт, чанарын төрийн хяналтын өмнө бүрэн хариуцах;

5/ энэ хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүтээгдэхүүнээ чанарын баталгаажуулалтад зохих хугацаанд хамруулах;

6/ өөрийн бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх талаархи чанарын удирдлагын нийтлэг, дэвшилттэй аргыг нэвтрүүлэх;

7/ шаардлагатай тохиолдолд стандартчиллын техникийн хорооны ажилд оролцох;

8/ бүтээгдэхүүндээ сорилт хийлгэх буюу өөрөө гүйцэтгэх лабораторитай байж, түүнийхээ техникийн түвшинг байнга дээшлүүлж, хэмжих, шалгах ажиллагаанд шаардагдах бүх нөхцөлийг бүрдүүлж ажиллуулах;

9/ энэ хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан жагсаалтад хамаарах бүтээгдэхүүнийг бөөнөөр үйлдвэрлэхдээ зөвшөөрөл авах;

10/ шинэ бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгоход холбогдох стандарт, арга зүйг ажиллагсаддаа эзэмшүүлэх;

11/ стандарт, чанарын төрийн хяналтын улсын байцаагчид ажлаа саадгүй явуулахад нь дэмжлэг тусалцаа үзүүлж шаардагдах

нөхцөл, техник хэрэгслээр хангах үүрэгтэй.

6. Борлуулах зориулалтаар бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа иргэн нь энэ зүйлийн 5 дахь хэсгийн 1, 4, 9-д заасныг баримтална.

7. Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллага нь зохих нөхцөлийг бүрдүүлсэн аж ахуйн нэгж, олон нийтийн болон бусад байгууллагад стандартчилал, чанарын баталгаажуулалт, сорилт зэрэг гүйцэтгэх эрх өгч болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

22 дугаар зүйл. Стандартчилал, чанарын баталгаажуулалтын санхүүжилт

1. Стандартчилал, баталгаажуулалтын төв болон орон нутгийн байгууллагаас энэ хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасан үндсэн чиг үүрэг, мөн зүйлийн 3 дахь хэсгийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 12-г заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс, мөн зүйлийн 3 дахь хэсгийн 10-г заасан үйл ажиллагааны зардлыг шинжлэх ухааны сангаас, бусад зардлыг тухайн байгууллагын төлбөрт үйлчилгээний болон бусад орлогоос тус тус санхүүжүүлнэ.

2. Техникийн хөрөөн үйл ажиллагааг түүнд оролцогч, сонирхогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага санхүүжүүлнэ.

3. Стандартчилал, чанарын баталгаажуулалт, сорилтын олон улсын байгууллагын гишүүний татварыг улсын төвлөрсөн төсвөөс төлнө.

4. Стандартчилал, баталгаажуулалтын төв болон орон нутгийн байгууллагаас үзүүлэх ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг стандартчилалын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд тогтооно.

5. Стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллага нь гадаад улс, олон улсын болон сонирхогч бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хандив, тусламж, орлогын бусад эх үүсвэрээс бүрдсэн Стандартчилал, баталгаажуулалтын хөгжлийн сантай байна.

23 дугаар зүйл. Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хууль

эгтоомжийг зөрчсөн этгээдэд түүнийгэм буруу, зөрчлийн шинж шинж байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан хуульд заасан эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

2. Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч буюу стандарт, чанарын төрийн хяналтын улсын байцаагч дор дурдсан шийтгэл ногдуулна:

1/ стандартчилал, баталгаажуулалтын төв болон түүнээс чанарын баталгаажуулалт хийх эрх авсан байгууллагын холбогдох албан тушаалтан стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хууль тогтоомж зөрчиж үйл ажиллагаагаа явуулсан, шийдвэр гаргасан бол 5000-15000 төгрөгөөр торгох;

2/ стандарт, чанарын төрийн хяналт хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээ, мэдүүлгийг хуурамчаар гаргасан, стандарт, чанарын улсын байцаагчаас өгсөн үүргийг хугацаанд нь биелүүлээгүй бол 50000 хүртэл төгрөгөөр торгох;

3/ итгэмжлэгдсэн лаборатори нь сорилтын дүн, дүгнэлтийг зориуд буруу гаргасан, энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлээгүй, эрхээ хэтрүүлсэн, эсхүл холбогдох стандарт, норматив-техникийн баримт бичгийг зөрчиж үйл ажиллагаагаа явуулсан бол 50000-100000 төгрөгөөр торгох;

4/ энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 5-д заасан объектод тогтоосон заавал мөрдөх улсын стандартыг зөрчсөн, энэ хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүтээгдэхүүнийг чанарын баталгаажуулалтад хугацаанд нь хамруулаагүй бол зөрчил гаргасан иргэнийг 5000-15000, аж ахуйн нэгж, байгууллагыг 10000-100000 төгрөгөөр торгох;

5/ энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан объектод тогтоосон заавал мөрдөх улсын стандартын үзүүлэлт шаардлагыг зөрчсөн, эсхүл 7 дугаар зүйлийн 4 дэхь хэсэгт заасныг зөрчсөн, эсхүл бүтээгдэхүүний чанарын ангилал, зэрэглэлийг зориуд өсгөсөн буюу улсын стандартын тэмдэглэгээ, чанарын гэрчилгээ, тохирлын тэмдгийг хууль бусаар ашигласан бол хуульусаар өлсөн орлогыг хурааж зөрчил гаргасан иргэнийг 5000-25000, аж ахуйн нэгж байгууллагыг 50000-150000 төгрөгөөр торгох,

6/ энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-т заасан объектод тогтоосон заавал мөрдөх улсын стандартын үзүүлэлт, шаардлагыг зөрчсөн бол уг бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг хурааж,

зөрчил гаргасан иргэнийг 25000-50000, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох.

3. Стандарт, чанарын төрийн хяналтын улсын байцаагч эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашигласан, төрийн хяналтыг хэрэгжүүлэхэд зориулан олгосон эд хөрөнгийг өөр зориулалтаар ашигласан бол түүнд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

4. Улсын байцаагчид албан үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулсан, эсэргүүцэл үзүүлсэн, заналхийлсэн, үйл ажиллагаатай нь холбогдуулан мөрдөн хавчсан, эрүүл мэндэд нь хохирол учруулсан гэм буруутай этгээдэд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5. Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хууль тогтоомжийг зөрчсөнөөс бусдад учруулсан материалын хохирлыг гэм буруутай этгээдээр зохих хууль тогтоомжийн дагуу нохон төлүүлэхийг сонирхогч этгээд нэхэмжлэх эрхтэй.

6. Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд зохих хариуцлага хүлээлгэх тухай стандарт, чанарын төрийн хяналтын улсын байцаагчийн шийдвэрийн талаар гарсан маргааныг шүүх шийдвэрлэнэ.

24 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН

ДАРГА

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 12 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

ХЭМЖЛИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, түүнд аяналт тавих эрх зүйн үндсийг тогтоож, хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, тасварлах, худалдах, ашиглахад төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах
тухай хууль тогтоомж

1. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль болон хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бод олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө.

ХОЙРДУГААР БҮЛЭГ

ХЭМЖЛИЙН НЭГЖ, ХЭМЖИХ ХЭРЭГСЭЛ, ХЭМЖИЛ ГҮЙЦЭТГЭХ АРГАЧЛАЛ

3 дугаар зүйл. Хэмжлийн нэгж

1. Хэмжил гүйцэтгэхэд жишиг болгон сонгож авсан нэгж хэмжигдэхүүнийг хэмжлийн нэгж гэнэ.

2. Монгол Улсад Олон улсын жиц хэмжүүрийн Ерөнхий бага хурлаас тогтоосон олон улсын системийн хэмжлийн нэгжийг хэрэглэнэ.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан системд үл хамаарах хэмжлийн нэгжүүдийг Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр олон улсын системийн хэмжлийн нэгжтэй нэгэн адил хэрэглэж болно.

4. Хэмжлийн нэгжийн нэр, тэмдэглэгээ болон тэдгээрийг бичих, хэрэглэх журмыг Засгийн газар тогтооно.

5. Экспортод нийлүүлж байгаа бүтээгдэхүүний чанар, техникийн үзүүлэлтийг захиалагчаас хүссэн хэмжлийн нэгжээр илэрхийлж болно.

4 дүгээр зүйл. Хэмжлийн нэгжийн эталон

1. Хэмжлийн нэгж буюу түүний тодорхой утгыг тогтоох, бий болгох, түүнийгээ хадгалах, хуулбарлах, харьцуулах замаар бусад хэмжих хэрэгсэлд дамжуулах зориудалттай хэмжих хэрэгслийг хэмжлийн нэгжийн эталон /цаашид "эталон" гэх/ гэнэ.

2. Улсын эталоныг Засгийн газар тогтооно.

3. Улсын болон анхдагч эталон нь төрийн өмч байна.

4. Улсын болон анхдагч эталоныг олон улсын байгууллага буюу гадаад орны албан ёсны зохих эталонтой харьцуулан дүйлгэж баталгаажуулна.

5. Хэмжлийн нэгжийг зөвхөн улсын болон анхдагч эталонноос батлагдсан аргачлалын дагуу холбогдох хэмжих хэрэгсэлд дамжуулна.

5 дугаар зүйл. Хэмжих хэрэгсэл

1. Хэмжил гүйцэтгэхэд ашиглаж байгаа хэмжил зүйн тогтоосон үзүүлэлт бүхий техник хэрэгслийг хэмжих хэрэгсэл гэнэ.

2. Хэмжих хэрэгсэл нь баталсан загвар, улсын стандарт, техникийн болон ашиглалтын швардлагыг хангасан байна.

6 дугаар зүйл. Хэмжил гүйцэтгэх аргачлал

1. Хэмжил гүйцэтгэх үндэслэл болгосон физикийн зарчим, тухайн хэмжих хэрэгслийг ашиглах нөхцөл арга зүйг тогтоосон журмыг хэмжил гүйцэтгэх аргачлал гэнэ.

2. Хэмжлийг хүчин төгөлдөр улсын стандарт, аргачлалын дагуу гүйцэтгэнэ.

3. Хэмжил гүйцэтгэх аргачлалыг боловсруулах, хянан батлах журмыг Хэмжилзүйн төв байгууллага тогтооно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХЭМЖИЛЗҮЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

7 дугаар зүйл. Хэмжилзүйн төрийн хяналт шалгалт,
түүний хүрээ, хэлбэр

1. Хэмжилзүйн төрийн хяналт шалгалтыг улсын хэмжээнд Хэм-

жилзүйн төв байгууллага, орон нутгийн хэмжээнд аймаг, нийслэлийн Хэмжилзүйн байгууллага тус тус зохицуулан зохион байгуулна.

2. Дараахь үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгсэл, хэмжил гүйцэтгэх аргачлалыг хэмжилзүйн төрийн хяналт шалгалтад хамруулна:

- 1/ байгалийн нөөцийн олборлолт, ашиглалт;
- 2/ худалдаа, үйлчилгээний тооцоо;
- 3/ хүн, мал эмнэлгийн шинжилгээ, эмчилгээ, оношлогоо;
- 4/ хөдөлмөр хамгаалал;
- 5/ байгаль орчим төрийн хяналт;
- 6/ улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон үйл ажиллагаа;
- 7/ геодези болон ус, цагууртай холбогдсон үйл ажиллагаа;
- 8/ тодорхой төрлийн эрдэм шинжилгээний ажил;
- 9/ бүтээгдэхүүний чанарын сорилт, туршилт чанарын баталгаажуулалт;
- 10/ шүүх эмнэлэг, криминалистикийн шинжилгээ;
- 11/ үндэсний болон олон улсын спортын дээдамжлалтыг бүртгэх;
- 12/ хэмжих хэрэгслийг засвар, шалгалт тохироулга, баталгаажуулалт.

3. Хэмжилзүйн төрийн хяналт шалгалтыг дараахь хэлбэрээр гүйцэтгэнэ:

- 1/ хэмжих хэрэгслийн загварыг турших;
- 2/ хэмжих хэрэгслийг баталгаажуулах;
- 3/ хэмжих хэрэгслийн үйлдвэрлэл, засвар, худалдаа эрхлэх, бусдад хэрэглүүлэх зөвшөөрөл олгох;
- 4/ савласан бүтээгдэхүүний тоон хэмжээг хянах;
- 5/ хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих.

8 дугаар зүйл. Хэмжих хэрэгслийн загварын туршилт

1. Хэмжих хэрэгслийн загварын туршилтыг Хэмжилзүйн төв байгууллага буюу түүнээс эрх олгосон мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

2. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх буюу импортоор нийлүүлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн хэмжих хэрэгслийн загварыг зохих норматив-техникийн болон ашиглалтын баримт бичгийн хамт Хэмжилзүйн төв байгууллагад ирүүлэн

туршилт хайлгэж баталгаажуулна.

3. Хэмжилзүйн төв байгууллага туршилтад тэнцсэн хэмжих хэрэгсэлд загварын гэрчилгээ олгож, улсын бүртгэлд бүртгэнэ.

4. Импортоор нийлүүж байгаа хэмжих хэрэгслийн загварын туршилтын үр дүнг одон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн бол загварын туршилтыг давтан хийхгүйгээр улсын бүртгэлд бүртгэнэ.

5. Хэмжих хэрэгслийн үйлдвэрлэгч нь баталсан загварын хэмжих хэрэгсэл тус бүрдээр болон түүнийг дагалдах ашиглалтын баримт бичиг бүрд загварын баталгааны тэмдэг дарна.

6. Хэмжих хэрэгслийн загварын туршилт хийх журмыг Хэмжилзүйн төв байгууллага тогтооно.

9 дүгээр зүйл. Хэмжих хэрэгслийн баталгаажуулалт

1. Хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, тохируулгын ажлыг Хэмжилзүйн төв болон аймаг, нийслэлийн хэмжилзүйн байгууллага эрхлэнэ. Хэмжилзүйн төв байгууллагаас тогтоосон журмын дагуу төвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага баталгаажуулалт, тохируулгыг гүйцэтгэж болно.

2. Иргэн, аж ахуйн хэгж, байгууллага энэ хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зөвшөөрсөн үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг импортоор нийлүүлсэн, үйлдвэрлэл, засвараас гарсны дараа, мөн тэдгээрийг ашиглах, хадгалах явцад баталгаажуулалтад заавал хамруулна.

3. Хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, тохируулгын ажлыг Хэмжилзүйн төв байгууллагаас хэмжүүрийн улсын шалгагчийн эрх олгосон ажилтан шалгах аргын улсын стандарт, аргачлалын дагуу гүйцэтгэнэ.

4. Баталгаажуулалтад тэнцсэн хэмжих хэрэгсэлд Хэмжилзүйн төв байгууллагаас баталсан тэмдэг дарах буюу лацдаж, гэрчилгээ олгоно.

5. Лац, тэмдэг нь хөндөгдсөн буюу арилсан, гэрчилгээг үрэгдүүлсэн, хуурамчаар үйлдсэн, баталгааны хугацаа нь дууссан, эсхүл эвдэрсэн буюу буруу заалттай хэмжих хэрэгслийг баталгаагүйд тооцно.

6. Баталгаагүй хэмжих хэрэгслийг худалдах, ашиглах, бусдад хэрэглүүлэхийг хориглоно.

7. Ахуйн зориулалттай хэмжих хэрэгслийг баталгаажуулалтад хамруулахгүй бөгөөд түүнийг худалдаа, үйлчилгээний тооцоонд хэрэглэхийг хориглоно.

8. Баталгаажуулалтад тавил хямруулах хэмжих хэрэгслийн жагсаалт, баталгаажуулалтын хугацааг Хэмжилзүйн төв байгууллага тогтооно.

10 дугаар зүйл. Хэмжих хэрэгслийн үйлдвэрлэл, засвар худалдаа эрхлэх, бусдад хэрэглүүлэх зөвшөөрөл

Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийн үйлдвэрлэл, засвар, худалдаа болон бусдад хэрэглүүлэх ажил, үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага Хэмжилзүйн төв байгууллагаас баталсан журмын дагуу зөвшөөрөл авна.

11 дүгээр зүйл. Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний хяналт

1. Савласан бүтээгдэхүүн нь дараахь шаардлагыг хангасан байна:

1/ сав, боодлыг задлах буюу эвдэхгүйгээр түүний доторхи бариа, бүтээгдэхүүний тоон хэмжээг өөрчлөх боломжгүй савласан, боосон байх;

2/ тухайн бүтээгдэхүүний хүнд, эзэлхүүн тэрэг бусад тоон үзүүлэлтийг сав, боодол дээр нь тэмдэглэсэн байх.

2. Савласан, боосон, түүнчлэн шархэгээр худалдах бүтээгдэхүүний тоон хэмжээний дундаж утга нь түүний хэлбэгдох стандарт болон сав, боодол дээр буюу дагалдах баримт бичигт тэмдэглэсэн тоон хэмжээний хэвийн утгатай, тодорхой нэг савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний утга нь хэвийн утгын зөвшөөрөгдох хэлбэлзлийн хязгаартай тус тус тохирч байна.

12 дугаар зүйл. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт

Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг Хэмжилзүйн улсын байцаагч хэмжлийн нэгжийн хэргэлгээ, хэмжил гүйцэтгэх аргачлалын мөрдөлт, хэмжих хэрэгслийн загварын туршилт, баталгаажуулалт, техникийн бэлэн байдал, ашиглалт, хадгалалт болон хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, засварлах, худалдах, импортоор нийлүүлэх үйл ажиллагаанд хэрэгжүүлнэ.

13 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын хэмжилзүйн дотоод хяналт

Аж ахуйн нэгж, байгууллага, түүний хэмжилзүйн алба нь хэмжилзүйн дотоод хяналтыг дараахь байдлаар хэрэгжүүлнэ:

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1994 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 168

Улаанбаатар
хот

**Т. Чимэддоржийг элчин сайдаар
томилох тухай**

Монгол Улсаас Бүгд Найрамдах Бангладеш Ард Улсад суух
Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Тэрбишийн Чимэддоржийг
томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1994 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 169

Улаанбаатар
хот

**Д. Чулуундоржийг элчин сайдын
үүрэгт ажлаас чөлөөлөх тухай**

Д. Чулуундоржийг Монгол Улсаас Валбын Вант Улсад суугаа
Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1994 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 170

Улаанбаатар
хот

**Т. Чимэддоржийг элчин сайдаар
томилдох тухай**

Монгол Улсаас Балбын Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн
рхт элчин сайдаар Тэрбишийн Чимэддоржийг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П. ОЧИРБАТ

4. Засгийн газар Хэмжилзүйн төв байгууллагын дүрмийг баталж, зөвлөлийн гишүүдийг томилно.

17 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн хэмжилзүйн байгууллага

1. Аймаг, нийслэлийн хэмжилзүйн байгууллага нутаг дэвсгэртээ хэмжлийн үнэн зөв, нэгдмэл байдлыг хангаж, хэмжилзүйн төрийн хиनाлт шалгалтыг хэрэгжүүлнэ.

2. Аймаг, нийслэлийн хэмжилзүйн байгууллагыг Хэмжилзүйн төв байгууллагын бодлого, чиглэлийн дагуу тухайн шатны Засаг дарга байгуулж ажиллуулна.

3. Аймаг, нийслэлийн хэмжилзүйн байгууллагын удирдлагыг Хэмжилзүйн төв байгууллагын удирдлагын саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга томилж чөлөөлнө.

4. Аймаг, нийслэлийн хэмжилзүйн байгууллага дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1/ нутаг дэвсгэртээ хэмжлийн нэгдмэл байдлыг хангах;

2/ анхдагч болон ажлын эталойг хадгалах, ашиглах, тэдгээрийг улсын эталонтой харьцуулан дүйлгэж баталгаажуулах;

3/ хэмжих хэрэгсэлд засвар, төхируулга, баталгаажуулалт хийх;

4/ хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль тогтоомжийн биелэлтэд хиनाлт тавих;

5/ нутаг дэвсгэртээ аж ахуйн нэгж, байгууллагын хэмжилзүйн ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах, мэдээлэл, аргазүйн туслалцаа үзүүлэх.

18 дугаар зүйл. Хэмжилзүйн улсын байцаагч, түүний бүрэн эрх

1. Хэмжилзүйн төрийн хиनाлт шалгалтыг хэмжилзүйн улсын байцаагч хэрэгжүүлнэ. Улсын байцаагчийн эрх бүхий хэмжүүрийн улсын шалгагч хэмжилзүйн төрийн хиनाлт шалгалтыг хэрэгжүүлж болно.

2. Бүх шатны хэмжилзүйн улсын байцаагчийг дараахь байдлаар томилж, чөлөөлнө:

1/ хэмжилзүйн улсын Ерөнхий байцаагчийг хэмжилзүйн асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд;

2/ Хэмжилзүйн төв байгууллагын хэмжилзүйн улсын Ерөнхий байцаагчийн саналыг үндэслэн хэмжилзүйн асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд;

3/ аймаг, нийслэлийн хэмжилзүйн улсын ахлах байцаагч, ул-

сын байцаагчийг улсын Ерөнхий байцаагчийн саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга;

4/ энэ хэсгийн 1, 2, 3-т зааснаас бусад хэмжилтгүйн улсын байцаагчийн саналыг үндэслэн хэмжилтгүйн асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд.

3. Хэмжилтгүйн улсын байцаагч нь тогтоосон журмын дагуу олгосон зэрэг, дэвтэй байна.

4. Хэмжилтгүйн төв байгууллагаас хэмжүүрийн улсын шалгагчийн эрх авсан улсын байцаагч хэмжих хэрэгслийн баталгаа жуулалтыг гүйцэтгэж болно.

5. Хэмжилтгүйн улсын байцаагч нь дараахь хивалт шалгалтыг хэрэгжүүлнэ:

1/ хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль тогтоомж, хэмжилтгүйн дүрэм, журам, хэмжил гүйцэтгэх аргачлалын мөрдөлт;

2/ хэмжлийн нэгж нь хэрэглэхийг зөвшөөрсөн нэгжтэй тохирч байгаа эсэх;

3/ хэмжих хэрэгслийн баталгаа жуулалт, техникийн бэлэн байдлыг болон тухайн хэмжих хэрэгслийн ашиглалтын нөхцөл, баталсан загварын шаардлагад тохирч байгаа эсэх;

4/ хэмжих хэрэгслийг баталгаа жуулахад ашиглаж байгаа эталоны техникийн бэлэн байдал;

5/ савласан бүтээгдэхүүний тооц хэмжээ.

6. Хэмжилтгүйн улсын байцаагч нь хэмжлийн нэгдмэл байдлыг хангахтай холбогдсон дараахь бүрэн эрхтэй:

1/ баталгаагүй эсхүл загвар нь батлагдаагүй буюу баталсан загвартаа тохирохгүй байгаа хэмжих хэрэгсэл ашиглах, худалдахыг бусдад хэрэглүүлэхийг хориглох;

2/ баталгаа жуулалтын хугацаа дууссан буюу буруу звалттай хэмжих хэрэгслийн баталгаа жуулалтын лац, тэмдгийг хүчингүй болгох, гэрчилгээг хураах;

3/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, засварлах, худалдах, бусдад хэрэглүүлэхдээ зохих журмыг зөрчсөн бол эдгээр ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгосон байгууллага, албан тушаалтанд уг зөвшөөрлийг хүчингүй болгохыг шаардах;

4/ хэмжилтгүйн төрийн хивалт, шалгалтыг хэрэгжүүлэхээр аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, хэмжлийн нэгдмэл байд-

лыг хангах тухай хууль тогтоомжийн зөрчлийг эрилгэх талаар заавал биелүүлэх хугацаатай үүрэг өгөх;

5/ хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль тогтоомж, хэмжилзүйн дүрэм, журмыг төрчсөн этгээдэд энэ хуульд заасан хариуцлага хүлээлгэх.

19 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын
хэмжилзүйн үйл ажиллагаа

1. Аж ахуйн нэгж, байгууллага, түүний удирдлага нь эрхэлсэн ажил, үйлчилгээнийхээ хүрээнд хэмжлийн үнрлэв, нэгдмэл байдлыг хариуцах бөгөөд энэ талаар дараахь үүрэг хүлээнэ:

1/ хэмжилзүйн ажлыг тодорхой нэгж, албан тушаалтанд хариуцуулах, шаардлагатай бол хэмжилзүйн албыг байгуулан ажиллуулах;

2/ хэмжигдэх үзүүлэлтүүдийн оногчтой нэр төрөл, хэмжлийн шаардагдах нарийвчлалыг тогтоох;

3/ шаардагдах нарийвчлал, хэмжлийн хязгаарт тохирсон хэмжих хэрэгслийг ашиглах;

4/ үйлдвэрлэл, байгалийн нөөцийн олборлолт, ашиггаалт, худалдаа, үйлчилгээний тооцоог зөвхөн улсын баталгаатай хэмжих хэрэгслээр гүйцэтгэх;

5/ хэмжилзүйн дотоод хяналтыг хэрэгжүүлэх;

6/ энэ хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг загварын туршилт, улсын баталгаа жуулалтад хамруулах, тэдгээрийн үйлдвэрлэл, засвар, худалдаа болон бусад хэрэглүүлэх ажил, үйлчилгээ эрхлэхэд зөвшөөрөл авах;

7/ савласан, боосон бүтээгдэхүүний тоон хэмжээ, хэлбэлзэх улгьг сав, боодол дээр буюу дагалдах баримт бичигт тэмдэглэх;

8/ хэмжих хэрэгслийн баталгаа жуулалт, засвар, шалгалт тохируулга гүйцэтгэсний болон бусад ажил, үйлчилгээний зардлыг хариуцах.

2. Олон нийтийн байгууллага нь хэмжлийн нэгдмэл байдлыг хангах талаар дараахь эрх эдэлнэ:

1/ энэ хуулийн биелэлтэд хяналт тавих, хэмжилзүйн төрийн хяналт шалгалтад оролцох;

2/ хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль тогтоомж, хэмжилзүйн дүрэм, журмын зөрчлийн тухай холбогдох байгууллагад мэдээлэх, зөрчлийг таслаж зогсоохыг холбогдох албан тушаалтнаас шаардах;

3/ баталгаажуулалтад тэмдэг хамрагдах хэмжих хэрэгслийг тогтоосон хугацаанд баталгаажуулалтад хамруулсан эсэхийг хянах;

4/ хэмжих хэрэгслийн загварыг туршилтад хийж, хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, засварлах, худалдах, бусдад хэрэглүүлэх зөвшөөрөл олгох журам, хэмжил гүйцэтгэх аргачлал боловсруулахад өөрийн саналаа Хэмжилзүйн төв байгууллагад танилцуулах;

5/ Хэмжилзүйн төв байгууллагын зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрийн төлөөлөгчөө оролцуулах.

ТАВДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

20 дугаар зүйл. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах

ажлын санхүүжилт

1. Хэмжилзүйн төв болон аймаг, нийслэлийн хэмжилзүйн байгууллагаас энэ хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1,2,3,-5,9,10,11 дэх заалт, 17 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1,2,4,5-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон тэдгээрийг хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, туршилтад зориулалттай эталон, тоног төхөөрөмжөөр тоноглоход швардагдах зардлыг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7-д заасан ажилыг шинжлэх ухааны сангаас, бусад үйл ажиллагааны зардлыг өөрийн төлбөрт ажил, үйлчилгээний орлогоос тус тус санхүүжүүлнэ.

2. Хэмжилзүйн олон улсын байгууллагын гишүүний татварыг улсын төвлөрсөн төсвөөс тална.

3. Хэмжилзүйн төв болон аймаг, нийслэлийн хэмжилзүйн байгууллагаас үзүүлэх хэмжилзүйн ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг хэмжилзүйн асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд тогтооно.

21 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчсөндөд

хүлээлгэх хариуцаагч

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль тогтоомж зөрчсөн нь гэмт хэргийн шинжгүй бол дараахь шийтгэлийг шүүгч буюу хэмжил-зүйн улсын байцаагч ногдуулан:

1/ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил, үйлчилгээ эрхлэхдээ Мон-

гол Улсад хэрэглэхийг зөвшөөрснөөс өөр хэмжлийн нэгжийг хэрэглэсэн, хэмжлийн нэгжийн нэр, тэмдэглэгээ болон тэдгээрийг бичих, хэрэглэх журмыг зөрчсөн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, зөрчил гаргасанаж ажуйн нэгж, байгууллагыг 50000 хүртэл төгрөгөөр торгох;

2/ хэмжилзүйн улсын байцаагч, хэмжүүрийн улсын шалгагчаас хиналт шалгалт явуулахад шаардагдах мэдээ материалыг буруу гаргаж өгсөн, хэмжилзүйн улсын байцаагчаас тавьсан шаардлага, хугацаатай үүргийг биелүүлээгүй бол холбогдох аж ажуйн нэгж, байгууллагыг 100000 хүртэл төгрөгөөр торгох;

3/ баталсан загвар, стандарт, техникийн болон ашиглалтын шаардлага хангаагүй хэмжих хэрэгсэл ашигласан, хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга хийхдээ баталгаагүй эталоныг ашигласан бол хууль бусаар, олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан иргэнийг 5000-15000 төгрөгөөр, аж ажуйн нэгж, байгууллагыг 50000-150000 төгрөгөөр торгох;

4/ энэ хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3,4-т заасныг зөрчиж хэмжих хэрэгслийн сонголт, холболт буюу хэмжлийг буруу хийсэн, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 2,6,7 дахь хэсэгт заасныг зөрчсөн бол хууль бусаар олсон орлогыг хурааж зөрчил гаргасан иргэнийг 10000-20000 төгрөгөөр, аж ажуйн нэгж, байгууллагыг 100000-200000 төгрөгөөр торгох;

5/ энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг зөрчиж бүтээгдэхүүнийг савласан, боосон, мөн ширхэгээр худалдах болон савласан боосон бүтээгдэхүүний тоон хэмжээ, хэлбэлзэх утгыг тэмдэглээгүй буюу буруу тэмдэглэсэн эсхүл буруу савласан, боосон бол хууль бусаар олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан иргэнийг 10000-20000 төгрөгөөр, аж ажуйн нэгж, байгууллагыг 100000-200000 төгрөгөөр торгох;

6/ энэ хуулийн 10 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ажил, үйлчилгээг зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан аж ажуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгох.

2. Хэмжилзүйн улсын байцаагч, хэмжүүрийн улсын шалгагч, хэмжүүрийн техникийн ажилтнаас албан үүргээ гүйцэтгэхэд нь эсэргүүцэл үзүүлсэн, үйл ажиллагаатай нь холбогдуулан мөрдөн хявчсан, гүтгэсэн, эрүүл мэндэд нь хохирол учруулсан этгээдэд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

3. Хэмжилзүйн улсын байцаагч, хэмжүүрийн улсын шалгагч эрх мэдэл, албан тушаалаа урвуудан ашигласан, албан үүргээ гүйцэтгэхэд зориулан олгосон хөрөнгө, техник хэрэгслийг өөр зориулалтаар ашигласан бол түүнд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

22 дугаар зүйл. Маргааныг шийдвэрлэх

Хэмжлийн нэгдмэл байдалыг хангах тухай хууль тогтоомжийг зөрчсөн иргэн аж ахуйн нэгж, байгууллагад зохих хариуцлага хүлээлгэх тухай бүх шатны хэмжилзүйн улсын байцаагчийн шийдвэрийн талаар гарсан маргааныг шүүх шийдвэрлэнэ.

23 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН

ДАРГА

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 12 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1944 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Хэмжүүр ба хэмжих багаж хэрэгслийн тухай хуулийг 1995 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН

ДАРГА

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төрийн алба /цаашид "төрийн алба" гэх/-ны ангилал, зарчим, төрийн албан тушаал, түүнд тавих шаардлага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, түүнээс төрийн алба хаах болзол, журам, баталгааг тогтоон зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Төрийн албаны тухай хууль тогтоомж

Төрийн албаны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Төрийн алба, түүний ангилал

1. Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн алба гэнэ.

2. Төрийн албаны мөн чанар нь ард түмнийхээ тусмы тулд төрд чин үнэнчээр зүтгэхэд оршино.

3. Төрийн албыг дор дурдсанаар ангилна:

- 1/ улс төрийн алба;
- 2/ захиргааны алба;
- 3/ тусгай алба;
- 4/ үйлчилгээний алба.

4 дүгээр зүйл. Төрийн албаны зарчим

1. Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ёсоор ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн албаны үндсэн зарчим мөн.

2. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албанд дараахь зарчмыг баримтална:

- 1/ захирах, захирагдах ёс;

2/ ил тод байх;

3/ төрийн алба нь ард түмэнд үйлчлэх;

4/ иргэд хуульд заасан болтол, журмын дагуу төрийн албанд орох адилаар тэгш боломжтой байх;

5/ төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх;

6/ төрийн албан хаагчаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, баталгааг төр хангах;

7/ хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр хариуцах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Төрийн албан тушаал

5 дугаар зүйл. Төрийн албан тушаалын ангилал, төрөл

1. Төрийн албан тушаалыг дөр дурдсанаар ангилна:

1/ Улс төрийн албан тушаал;

2/ захиргааны албан тушаал;

3/ тусгай албан тушаал;

4/ үйлчилгээний албан тушаал.

2. Төрийн албан тушаал нь удирдах, гүйцэтгэх, туслах гэсэн төрөлтэй байна.

3. Төрийн өндөр албан тушаалтны зэрэг дээд хамаарах төрийн албан тушаалын зэрэг энэдаг Улсын Их хурал тогтооно.

6 дугаар зүйл. Төрийн улс төрийн албан тушаал

1. Төрийн улс төрийн албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон болтол, журам, шалгуурын дагуу сонгуулийн болон уг сонгуулийн үр дүнд томилолтын журмаар ажиллах, мөн тэдгээрийн бүрэн эрхийнх нь хугацаанд өөрт нь үйлчлэх орон тооны ажилтны дараахь албан тушаал хамаарна:

1/ Монгол Улсын Ерөнхийдөгч;

2/ Монгол Улсын Их Хурлын дарга;

3/ Монгол Улсын Ерөнхий сайд;

4/ Монгол Улсын Их Хурлын дэд дарга, гишүүн;

5/ Монгол Улсын Засгийн газрын гишүүн;

6/ Дэд сайд, Засгийн газрын үндсэн бүтцэд ордог тусгай газрын дарга;

7/ Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, зөвлөх;

8/ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга;

9/ Бүх шатны Засаг дарга;

10/ Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллаагад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүн;

11/ улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийнх нь хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны ажилтны албан тушаал;

12/ хуульд заасан бусад албан тушаал.

2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, хот, тосгоны захирагч тэрэг нутгийн өөрөө удирдах байгууллагын ажилтны албан тушаалыг төрийн улс төрийн албан тушаалтай хууднаар адилтган үзэж болно.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 11-д заасан албан тушаал эрхэлдэг ажилтан нь улс төрийн тухайн албан тушаалтанд захирагдах боловч төрийн албан хаагчийн хувьд холбогдох төрийн байгууллагын ажлын албанд харьяалагдана.

4. Улс төрийн албан тушаалтан хуульд заасан үндэслэлээр уг албан тушаалаас өөрчлөгдвөл түүнд үйлчилж байсан орон тооны ажилтан нь чөлөөлөгдөнө. Гэхдээ шинээр сонгогдсон буюу томилогдсон төрийн албан тушаалтан хүсвэл уг ажилтныг өөрт нь үйлчлэх орон тооны ажилтнаар үргэлжлүүлэн ажиллуулж болно.

7 дугаар зүйл. Төрийн захиргааны албан тушаал, түүний ангилал

1. Төрийн захиргааны албан тушаалд дараахь албан тушаал хамаарна:

1/ Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, шүүх, прокурорын байгууллагын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

2/ Үндсэн хуулийн цэц, Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны албан тушаал;

3/ энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т зааснаас бусад Монголбанкны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

4/ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны гүйцэтгэх албан тушаал;

5/ Монгол Улсын хамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын үндсэн болон дэд бүтцэд ордог байгууллагын удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

6/ Төрийн захиргааны албаны зөвлөлийн орон тооны гишүүн;

7/Засгийн газрын үндсэн болон дэд бүтцэд ордог байгууллагын шууд харьяа төрийн захиргааны байгууллагын удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

8/ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг даргын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

9/ төрийн байгууллагын дэргэдэх төрийн зохицуулалт, хэвлэл мэдээлэл, сургаалт, эрдэм шинжилгээний зэрэг чиг үүргийг төрөөс хэрэгжүүлэхэд туслах үүрэг бүхий байгууллагын удирдах албан тушаал;

10/ хуульд заасан бусад албан тушаал.

2. Төрийн захиргааны албан тушаалыг төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын гэж бүлэглэнэ.

3. Төрийн захиргааны албан тушаалыг дор дурдсанаар ангилна:

1/ тэргүүн түшмэл;

2/ эрхэлсэн түшмэл;

3/ ахлах түшмэл;

4/ дэс түшмэл;

5/ туслах түшмэл;

4. Тэргүүн түшмэлийн албан тушаалд яамны Төрийн нарийн бичгийн дарга, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

5. Эрхэлсэн түшмэлийн албан тушаалд яамны газрын дарга, түүний орлогч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

6. Ахлах түшмэлийн албан тушаалд яамны хэлтэс, засгийн дарга, ахлах байцаагч, ахлах мэргэжилтэн, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

7. Дэс түшмэлийн албан тушаалд яамны байцаагч, мэргэжилтэн, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

8. Туслах түшмэлийн албан тушаалд яамны туслах байцаагч, туслах мэргэжилтэн, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

9. Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Үндсэн хуулийн цэцийн ажлын албаны удирдах албан тушаалын ангилал, зэрэглэлийг Улсын Их Хурал тогтооно.

10. Хуульд өөрөөр заагаагүй бол яам, төрийн бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг Засгийн газар тогтооно.

8 дугаар зүйл. Төрийн тусгай албан тушаал

1. Төрийн тусгай албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй даргахь албан тушаал хамаарна:

1/ бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, гишүүн;

2/ зөвсэгт хүчин, бусад цэрэг, тагнуул, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, хорих байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч;

3/ Монголбанкны Ерөнхийлөгч, гэргүүн дэд, дэд Ерөнхийлөгч, Үнэт цаасны хорооны дарга, гишүүн;

4/ хуульд заасан бусад албан тушаал.

2. Төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэвийг хууль тогтоомжид заасны дагуу тогтооно.

9 дүгээр зүйл. Төрийн үйлчилгээний албан тушаал

1. Төрийн үйлчилгээний албан тушаалд төрийн байгууллагын ториалт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслахаар хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллуулах даргахь албан тушаал хамаарна:

1/ төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаал;

2/ төрийн байгууллагын дэргэдэх төрийн зохицуулалт, хэвлэл, мэдээлэл, сургалт, эрдэм шинжилгээний зэрэг чиг үүргийг төрөөс хэрэгжүүлэхэд туслах үүрэг бүхий байгууллагын гүйцэтгэх ба туслах албан тушаал;

3/ боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг зэрэг төрийн байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаал;

4/ төрийн өмчийн үйлдвэрийн газрын захиргааны албан тушаал.

2. Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг Засгийн газар тогтооно.

10 дугаар зүйл. Төрийн албан тушаалд тавих шаардлага

1. Төрийн албан тушаалд тавих ерөнхий шаардлага нь хуульд өөрөөр заагаагүй бол тухайн албан тушаалыг эрхлэх ур чадвар, боловсрол, мэргэшлийн бэлтгэл, туршлагатай байх явдал мөн.

2. Төрийн улс төрийн болон тусгай албан тушаалд тавих тусгай шаардлага болон ёс зүйн хэм хэмжээг хуулиар тогтооно.

3. Засгийн газар шаардлагатай гэж үзвэл төрийн захиргааны албан тушаалд тавих тусгай шаардлага болон ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн тогтоож болно.

4. Төрийн үйлчилгээний албан тушаалд тавих тусгай шаардлага

болон ёс зүйн хэм хэмжээг албан тушаалын тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээгээр тодорхойлно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Төрийн албан хаагч

11 дүгээр зүйл. Төрийн албан хаагч

1. Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхтэй хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллаж нохцол, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэнэ.

2. Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2,3-т заасан албан тушаалын ангиллын хүрээнд төрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалыг мэргэшлийн үндсэн дээр байнга эрхэлж байгаа Монгол Улсын иргэнийг төрийн жинхэнэ албан хаагч гэнэ.

3. Улс төрийн болон тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг хуулиар тогтоох бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн холбогдох заалтыг мөрдөнө.

4. Төрийн захиргааны албан хаагчийн эрх зүйн байдлыг энэ хуулиар тогтооно.

5. Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Хөдөлмөрийн хууль, энэ хууль болон хууль тогтоомжийн бусад ахтаар тогтооно.

6. Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн хуулиар зохицуулна.

12 дугаар зүйл. Төрийн захиргааны албан
хаагчийн тангараг

1. Монгол Улсын иргэн төрийн захиргааны албанд анх орохдоо: "Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориудж, төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглаа. Тангарагаа няцавал хуулийн хариуцаага хүлээнэ" хэмээн тангараг өргөнө.

2. Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч тогтооно.

13 дугаар зүйл. Төрийн захиргааны албан хаагчийн нийтлэг
үүрэг

Төрийн захиргааны албан хаагч нь даравхь нийтлэг үүрэг хүлээнэ.

1/ Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;

2/ өргөсөн тангарагтаа үнэнч байх;

3/ эх орон, ард түмнийхээ тусмы тулд иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажиллах;

4/ харьяа дээд шатны албан тушаалтны хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх;

5/ албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахих, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;

6/ албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх шаардлагад нийцүүлэн мэргэшлээ дээшлүүлэх;

7/ албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон тухайн албан тушаалыг эрхлэхээ зогсоосноос хойшхи хугацаанд төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хадгалах;

8/ албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахих;

9/ албан тушаалтны хууль бус, шударга бус явдалтай эвлэршгүй байх;

10/ төрийн албан тушаалд томилогдмогц өөрийн өмчийн байдлын талаар мэдэгдэж, өмчийн байдалд орсон өөрчлөлт, орлогын талаар зохих байгууллагад мэдээ өгч байх;

11/ хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

14 дүгээр зүйл. Төрийн захиргааны албан хаагчийн нийтлэг эрх

Төрийн захиргааны албан хаагч нь дараахь нийтлэг эрх эдэлнэ:

1/ төрийн тухайн албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг албан ёсоор тогтоож түүнийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийг шаардах;

2/ цалин хөлсөө нэмэгдүүлэх, албан тушаалын зэрэглэл дэвших, ажиллах нөхцөл, баталгаагаа сайжруулахтай холбогдсон саналыг дээд шатныхаа албан тушаалтанд амаар буюу бичгээр тавих;

3/ өөрийн хувийн хэрэг болон түүнд оруулах ажил байдлын тодорхойлолт зэрэг материалтай танилцах, шаардлагатай гэж үзвэл хувийн хэрэгтээ нэмэлт тайлбар хийх;

4/ өөрийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг шүүх болон холбогдох бусад байгууллагаар хамгаалуулах;

5/ хууль тогтоомжид зааснаар төрийн албан тушаал хавсран эрхлэх;

6/ хууль тогтоомжоор хориглоогүй, тушаалынхаа ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуйгаа гардан эрхлэх, аж ахуйн нэгжийнхээ үйл ажиллагааг оорайн итгэмжлэгдсэн хүнээр хөтлүүлэх зэргээр орлого олох;

7/ төрийн албанаас чөлөөлөгдөх;

8/ хууль тогтоомжид заасан бусад эрх.

15 дугаар зүйл. Төрийн захиргааны албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл

Төрийн захиргааны албан хаагч дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1/ албан үүрэгтэйгээ холбоогүй асуудлаар нам, олон нийтийн болон шашны байгууллагын үйл ажиллагаанд төрийн албан хаагчийн хувьд оролцох;

2/ ажил хаялт болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох;

3/ албан тушаалын бүрэн эрхээ шашны, эсхүл шашингүйн үзлийн ухуулга, сурталчилгаа хийхэд ашиглах;

4/ Монгол Улсын Ерөнхийлөгчийн төвшөөрөлгүйгээр гадаад орны төрийн дээд цол, одон, медаль, төрийн бусад шагнаал авах;

5/ Монгол Улсын олон улсын гэрээнд заасан болон Монгол Улс, гадаад улсын төрийн байгууллагын хооронд харилцан тохиролцсон албан төмилөлт болон ажиллаж байгаа төрийн байгууллагынхаа эрх бүхий албан тушаалтны төвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргээ гүйцэтгэхдээ аж ахуйн нэгж, иргэн, түүний дотор гадаадын байгууллага, иргэний зардлаар гадаад, дотоодод зорчих;

6/ албан тушаалынхаа бүрэн эрхийг хэрэгжүүлсний төлөө бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс бэлэг, мөнгөн шагнаал, шан харамж, зээл авах, төлбөргүй буюу хөнгөлөлттэйгээр үйлчлүүлэх зэрэг хууль бус бусад хангамж эдлэх;

7/ албаны бус зорилгод төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглан занших;

8/ хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, нам, олон нийтийн бусад байгууллагад орон тооны албан тушаал хавсран гүйцэтгэх;

9/ аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг гардан эрхлэх, бусдад

зуучлан хөтлөх;

10/ хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хувь нийлүүдсэн аж ахуйн нэгжийг гардан удирдах, тэдгээрийн нэгдлийн удирдах зөвлөлийн болон захиргааны гишүүн байх;

11/ Албан тушаал эрхэлдэг төрийн байгууллагад эсхүл удирдлага, хяналтад нь ажилладаг байгууллагад гурав дахь этгээдийн төлөөлөгч буюу итгэмжлэгдсэн этгээд байх;

12/ хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн албаны төв байгууллага зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргээ гүйцэтгэхийг зогсоосон өдрөөс хойш 2 жилийн дотор сүүлийн 5 жилийн хугацаанд эрхэлж байсан ажил, албан тушаалинхаа дагуу шууд холбоотой ажилладаг байсан хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид албан тушаал эрхлэх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Төрийн захиргааны албан тушаал эрхлэх болзол, журам

16 дугаар зүйл. Төрийн захиргааны албан тушаал эрхлэх болзол

1. Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн захиргааны албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, машин шүтлэг, үзэл бодол болон нам, олон нийтийн бусад байгууллагын харьяалал зэргээр ялгаварлаж үл болно.

2. Төрийн захиргааны албан тушаалд дараахь тохиолдолд авч ажиллуулахыг хориглоно:

1/ Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлсэн, эсхүл бусад төрлийн гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлдээд ял шийтгэлгүйд тооцогдох хугацаа нь дуусаагүй бол;

2/ төрийн захиргааны албан тушаалаас сахилгын шийтгэлээр халагдсан өдрөөс хойш 1 жилийн хугацаа өнгөрөөгүй бол;

3/ хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу шууд хяналт тавих албан тушаалтантай төрөл садамгийн хүн /эцэг, эх, эхнэр, нөхөр, төрсөн ах, дүү, үр хүүхэд, тэдгээрийн гэр бүлийн хүн/ нь тухайн ажлын албаны нэгжид хамт ажиллахаар бол;

4/ гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол;

5/ хууль тогтоомжид заасан бусад тохиолдол.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасныг зөрчиж иргэнийг төрийн захиргааны албан тушаалд төмилсөн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүчингүйд тооцно.

17 дугаар зүйл. Төрийн захиргааны албан тушаалд
авах

1. Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэгт заасан шаардлага, мөн хуулийн 16 дугаар зүйлд заасан болзлыг хангасан Монгол Улсын иргэн төрийн захиргааны албан тушаалд орох эрхтэй.

2. Иргэн төрийн захиргааны албан тушаалд анх орох тохиолдолд өрсөлдүүлэн шалгаруулах зорилго бүхий төрийн албаны мэргэшлийн шалгалт /цаашид "мэргэшлийн шалгалт" гэх/ орно.

3. Мэргэшлийн шалгалтад тэнцэж төрийн захиргааны албан тушаалд анх орох иргэний нооцийн жагсаалтыг мэргэшлийн шалгалтын онооны дэс дарааллаар үйлдэж хэмгийн их оноо авсан хүмүүсээс эхлэн төрийн захиргааны албан тушаалд анх авах ажлыг зохион байгуулна.

4. Мэргэшлийн шалгалт авах болзол, журмыг төрийн албаны төв байгууллага тогтооно.

5. Мэргэшлийн шалгаруулалтаар шалгарсан иргэнийг зохих албан тушаалд төмилсөн тухай төрийн холбогдох байгууллагын эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргаж баталгаажуулна.

18 дугаар зүйл. Төрийн захиргааны албаны туршилтын
хугацаа

1. Төрийн захиргааны албан тушаалд анх орсон албан хаагчид туршилтын хугацааг 1 жил хүртэл хугацаатаар тогтоож болно.

2. Төрийн захиргааны албан тушаалд хугацаа хэрэглэх болзол, журмыг төрийн албаны төв байгууллага тогтооно.

19 дүгээр зүйл. Төрийн захиргааны албан хаагчийн үйл
ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх

1. Төрийн захиргааны албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг эрх бүхий байгууллаагаас тогтоосон хугацаанд зохих журмын дагуу үнэлж дүгнэнэ.

2. Төрийн захиргааны албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээг үндэслэн албан тушаал дэвшүүлэх, зохих шатны сургалтад хамруулах, тэрэг дэв олгох, цалин хөлсийг өөрчлөх, албан тушаал бууруулах асуудлыг шийдвэрлэнэ.

3. Төрийн захиргааны албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журмыг төрийн албаны төв байгуул-

дага тогтооно.

20 дугаар зүйл. Төрийн захиргааны албан
тушаалын зэрэг дэв

1. Төрийн захиргааны тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэл, ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаал нь тус бүртээ тэргүүн зэрэг, дэд зэрэг, гутгаар зэрэг, дөтгөөр зэрэг гэсэн зэрэг дэвтэй байна.

2. Тэргүүн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын Ерөнхийлөгч; эрхэлсэн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын Ерөнхий сайд; ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын сайд; төрийн бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтан, аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус олгоно.

3. Зэрэг дэв олгохдоо төрийн албанд нийт ажилласан буюу тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, мэргэшлийн түвшинг харгалзана.

4. Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг Засгийн газрын өргөн мэдүүлдснээр Улсын Их Хурал тогтооно.

5. Төрийн захиргааны албаны зарим онцлог салбарын албан тушаалын зэрэг дэвийг хуулиар тогтоож болно.

21 дүгээр зүйл. Төрийн захиргааны албан тушаал хавсрах,
төрийн албан хаагчийн албан үүргийг түр
орлон гүйцэтгэх

1. Албан ажлын ашиг сонирхол, албан тушаалынх нь бүрэн эрхэд харшлахгүй бол төрийн захиргааны албан хаагч удирдлагын зөвшөөрснөөр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 8-д зааснаас бусад тохиолдолд өөрийн буюу төрийн бусад байгууллагад өөр ажил, оронгооны албан тушаал хавсран гүйцэтгэж болно.

2. Төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан төрийн захиргааны албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлж болно.

3. Төрийн захиргааны албан тушаал хавсрах, төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам, хавсран гүйцэтгэж болохгүй төрийн албан тушаалын жагсаалтыг Засгийн газар тогтооно.

**22 дугаар зүйл. Төрийн захиргааны албан хаагчийг өөр
албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах
түр томилох**

1. Албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн төрийн захиргааны албан хаагчийг түүнтэй тохиролцож төрийн нэг байгууллагаас нөгөө байгууллагад өөр албан тушаалд шилжүүлэн ажиллуулж болно.

2. Төрийн захиргааны албан хаагчийг өөрийнх нь зөвшөөрснөөр төрийн байгууллага хооронд тэдгээрийн удирдлагын харилцан тохиролцсоны дагуу ажлын тодорхой чиглэлээр 2 жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно. Хэрэв төрийн албан хаагч өөрөө буюу түүнийг сэлгэн ажиллуулж байгаа байгууллага хүсвэл анх илгээсэн төрийн байгууллага болон өөрийнх нь зөвшөөрснөөр сэлгэн ажиллуулах хугацааг 1 жил хүртэл хугацаагаар сунгаж болно.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн захиргааны албан хаагчийг сэлгэн ажиллуулах хугацаа дуусмагц түүнийг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь эргүүлэн авна.

4. Төрийн байгууллага нь албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн төрийн захиргааны албан тушаалд иргэнийг 6 сар хүртэл хугацаагаар түр томилж болно. Шаардлагатай тохиолдолд энэ хугацааг 6 сар хүртэл хугацаагаар сунгаж болно.

5. Иргэнийг төрийн захиргааны албан тушаалд түр томилоход энэ хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан журам хамаарахгүй.

6. Төрийн захиргааны албан тушаалд түр томилогдсон иргэн нь албан тушаал эрхлэх хугацаандаа тухайн албан тушаалын бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

**23 дугаар зүйл. Төрийн захиргааны албан хаагчийг захиргааны
санаачилгаар албан тушаалаас нь бууруулах,
төрийн албанаас түр халах, чөлөөлөх**

1. Төрийн захиргааны албан хаагчийг дараахь үндэслэлээр захиргааны санаачлагаар албан тушаал бууруулах, эсхүл төрийн албанаас уг албанд эргэж орох эрхтэйгээр хална:

1/ албан үүргээ хянгалтгүй биелүүсэн;

2/ мэргэшлийн түвшин нь төрийн тухайн албан тушаал эрхлэх шаардлага хангахгүй болсон;

3/ биеийн эрүүл мэндийн байдлын улмаас албан үүргээ биелүүлэх боломжгүй болсон;

4/ оршин суух газар нь өөрчлөгдсөний улмаас тухайн орон тооны

албан тушаалыг эрхлэх боломжгүй болсон.

2. Төрийн захиргааны албан хаагчийг дараахь үндэслэлээр захиргааны санаачилгаар төрийн албанаас түр чөлөөлнө:

1/ Биеийн эрүүл мэндийн байдлын улмаас 1 жилээс дээш хугацаагаар албан ажлаа хийхгүйгээр эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон;

2/ урт хугацааны сургалтаар бэлтгэгдэх болсон;

3/ цэргийн жинхэнэ алба хаах болсон.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр түр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийг нооцод байгаад тооцно.

24 дүгээр зүйл. Төрийн захиргааны албан хаагч
төрийн албанаас чөлөөлөгдөх,
төрийн захиргааны алба хаах
насны дээд хязгаар

1. Төрийн захиргааны албан хаагчийг дараахь үндэслэлээр төрийн албанаас чөлөөлнө:

1/ төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн; *

2/ тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн;

3/ өөрийн санаачилгаар төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан.

2. Төрийн захиргааны албан хаагчийн төрийн алба хаах насны дээд хязгаар нь эрэгтэй хүнд 65 нас, эмэгтэй хүнд 60 нас байна.

3. Төрийн захиргааны албан хаагч нь төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрмэгц төрийн албанаас чөлөөлөгдөх тухай хүсэлтээ гаргана. Уг хүсэлтийг тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан зохих журмын дагуу шийдвэрлэнэ.

4. Төрийн захиргааны албан хаагч нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц төрийн албанаас чөлөөлөгдөх тухай хүсэлтээ гаргана. Уг хүсэлтийг тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан хүлээн авч ёсоор болгох, эсхүл түүнийг төрийн алба хаах насны дээд хязгаарт хүртэл үргэлж лүүлэн ажиллуулахаар шийдвэрлэнэ.

25 дугаар зүйл. Төрийн захиргааны албан хаагчийг
төрийн албанаас халах

Төрийн захиргааны албан хаагчийг дараахь үндэслэлээр төрийн албанаас халив:

1/ гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

2/ Монгол Улсын харьяатаас гарсан.

26 дугаар зүйл. Төрийн захиргааны албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах

1. Энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1-11-д заасныг болон албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн тохиоодолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны албан хаагчид дараахь сахилгын шийтгэл ногдуулна:

1/ сануулах;

2/ албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

3/ төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах.

2. Төрийн захиргааны албан хаагчид түүнийг томилсон төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр сахилгын шийтгэл ногдуулна.

3. Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй.

4. Нэг төрлийн сахилгын шийтгэлийг давхардуулан ногдуулж болохгүй.

5. Төрийн захиргааны албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 нэг жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно.

6. Энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1-11-д заасныг зөрчсөн төрийн захиргааны албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах нь төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд харин түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

7. Төрийн захиргааны албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш 1 сарын дотор төрийн дээд шатны байгууллага, эсхүл шүүхэд гаргаж болно.

8. Сахилгын шийтгэл ногдуулах, түүнд төрийн дээд шатны байгууллагад гомдол гаргах журмыг Засгийн газар тогтооно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Төрийн албан хаагчийн ажиллах нохцол, баталгаа

27 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн баталгаа

1. Төрийн албан хаагч нь дараахь баталгаагаар хангагдана:

1/ төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшил, тэтгэвэр, тэтгэмж авах;

2/ албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангуулах;

3/ гүйцэтгэж байгаа албан үүргийнх нь шинж байдлыг харгалзан зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унаамы зардлын зохих хэсгийг нөхөн авах;

4/ албан үүргээ гүйцэтгэж байгатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагч, түүний гэр бүлийн гишүүн нь тухайн төрийн албан хаагчийн ажиллаж байгаа төрийн байгууллагаар хамгаалуулах;

5/ төрөөс орон байраар хангагдах;

6/ Хөдөлмөрийн хуулиар тогтоосон ээлжийн амраат эдлэх;

7/ төрийн алба хаах хугацаанд болон тэтгэвэрт гарсан үсдээ хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл, журмын дагуу эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах;

8/ Эрүүл мэндийн давтгалын хуульд заасан тухайн жилийн эмчлэгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон улсын эмнэлгийн комиссын шийдвэрээр гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зардлынх нь 60-аас доошгүй хувийг төр хариуцах;

9/ төрийн хөрөнгөөр давтан сурах, мэргэжлээ дээшлүүлэх, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалынхаа цалин хөлсийг авах;

10/ гэр бүлээс нь их, дээд, мэргэжлийн сургуульд элссэн 1 хүүхдийнх нь сургалтын зардлыг дотоодын их, дээд, мэргэжлийн сургуулийн тус тусын жишгээр тооцож төр хариуцах;

11/ хууль тогтоомжоор тогтоосон бусад баталгаа.

2. Төрийн захиргааны албан хаагч нь дараахь нэмэгдэл баталгаагаар хангагдана:

1/ энэ хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 25 дугаар зүйл, 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т зааснаас бусад тохиолдолд төрийн албанаас халагдахгүй байх;

2/ Улсын Их Хураа, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хураал, бүх шатны Засаг даргын бүрэн эрх дуусгавар болох, мөн энэ хуулийн бусад дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-5-д заасан уаст төрийн албан тушаалтантай уг албан тушаалаас өөрчлөгдөх нь төрийн захиргааны албан хаагчийг өөрчлөх үндэслэл болохгүй байх;

3/ төрийн байгууллага татан буугдсан, эсхүл өөрөөс нь үл хамарах шалтгаанаар албан тушаалын орон тоо нь хасагдсан тохиолдолд цалин хөлсөө бууруулахгүйгээр мэргэжил, мэргэшлийн дагуу өөрчил, албан тушаалд шилжих буюу төрийн хөрөнгөөр бусад хүртэл хугацаагаар дахин мэргэшиж болох бөгөөд энэ хугацаанд урьд нь эрхэлж байсан албан тушаалынхаа цалин хөлсийг авч, хууль тогтоомжид заасан журмын дагуу ажлын байраар хангуулах;

4/ төрийн байгууллагад тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах албан хаагчид аминдаа орон сууц барих болон орон сууц, амьдралын нэн тэргүүний хэрэгцээт зүйлс худалдан авах, өөрийн хүснэгтээр суралцах болон хүүхдээ сургахад нь зориулан байгууллагаас нь хөнгөлттэй зээл олгох, шаардлагатай бол зээлийн баталгаа гаргаж өгөх.

28 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн цалин хөлс

1. Төрийн албан хаагчид албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно.

2. Төрийн албан хаагчийн цалин хөлс нь:

1/ улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, эрдмийн зэргийн нэмэгдлээс;

2/ төрийн захиргааны албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн албан хаасан хугацааны, зэрэг дэвийн, эрдмийн зэргийн нэмэгдлээс;

3/ тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн албан хаасан хугацааны, зэрэг дэвийн, эрдмийн зэргийн нэмэгдлээс;

4/ үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон эрдмийн, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын нэмэгдэл, бусад нэмэгдлээс тус тус бүрдэнэ.

3. Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээ, жишгийг тогтооход дараахь шаардлагыг харгалзан үзнэ:

1/ төрийн адил албан тушаалд адил хэмжээний цалин хөлс тогтоох;

2/ төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ нь нийгмийн амьжиргааны дундаж түвшин болон хувийн хэвшилд ажиллагчдын албан тушаалын цалингийн дундаж түвшинтэй умлацсан байх; *

3/ төрийн албан хаагчийн албан тушаалын дундаж цалингийн хэмжээ нь хувийн хэвшилд ажиллагчдын адилтгах албан тушаалын цалингийн дундажаас 5,0 буюу түүнээс дээш хувиар бага болсон тохиолдолд албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээ, жишгийг өөрчлөх саналыг тухайн жилд нь боловсруулж, зохиожурмын дагуу шийдвэрлүүлэх;

4/ төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, жишгийг албан тушаалын ангилал, тэрэглэл болон төрийн тухайн албан тушаал эрхэлсэн хугацаанаас хамааралтайгаар төрийн албаны салбар, төрийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр боловсруулж мөрдүүлэх.

4. Улс төрийн болон тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.

5. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, жишгийг Засгийн газар тогтооно.

6. Улс төрийн болон энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,3-т заасан тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдлийн хэмжээ, зайлшгүй шаардлагатай бусад хангамжийг хууль тогтоомжоор тогтооно.

7. Төрийн захиргааны албан хаагчийн нэмэгдэл олгох журам хэмжээг Засгийн газар тогтооно.

8. Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдэл, бусад нэмэгдэл хөлсний доод хэмжээг Засгийн газар тогтооно.

29 дүгээр зүйл. Төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр

1. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах зорилгоор түүний цалин хөлсөөс төлбөр зохих бүх шимтгэлийн болон эрүүл мэндийн даатгалын хураамжийн 80-аас доошгүй хувийг төрийн байгууллагын төсвөөс нөхөн төлнө.

2. Төрийн албан хаагчид дараахь нөхөх төлбөр олгоно:

1/ албан томилолтын зардал;

2/ албан ажлын хэрэгцээнд батлагдсан нормативын дагуу хуний унаа албан ажилдаа хэрэглэсэн тохиолдолд хувиас гарсан зардал;

3/ гадаад улсад болон нэг аймаг, зотоос цогоо аймаг, хотод түүнчлэн аймаг, хотын дотор төрийн байгууллагад ажиллахаар томилогдсон албан хаагчид уналга, ачаатэвч, зам хөногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүмүүст уналга, ачаа тээшийн зардал;

4/ хууль тогтоомжид заасан бусад нөхөх төлбөр.

3. Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам, түүний хэмжээг төрийн албаны төв байгууллагын санхүүг үндэслэн Засгийн газар тогтооно.

30 дугаар зүйл. Төрийн албан хаагчид олгох тусламж

1. Энэ хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр төрийн албанаас халагдсан болон мөн түйлийн 2 дэх хэсэгт заасан үндэслэлээр төрийн албанаас гур чөлөөлөгдсөн тохиолдолд төрийн захиргааны албан хаагчид тусламж олгож болно.

2. Энэ хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1,2-г заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн захиргааны албан хаагчид 6 сарын албан тушаалын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцаатгүй тусламж олгоно.

3. Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан төрийн захиргааны албан хаагчийн амь насыг хохироосон тохиолдолд түүний эргэрт 3 жилийн албан тушаалын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцаатгүй тусламж олгоно.

4. Төрийн албан хаагчид нийгмийн даатгалын тэтгэмж эвс гадна дараахь тохиолдолд тусламж олгож болно:

1/ гэр бүлийг нь дэмжих;

2/ ээлжийн амралтаараа өөрийн буюу эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутаг явах болгох, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашины, төмөр замын үнээгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгох;

3/ төрөл садан /эцэг, эх, эхнэр, нөхөр, төрсөн ах, эгч, дүү, үр хүүхэд, тэдний гэр бүлийн хүү/-гийн хүү нас барах, өвчний улмаас хөдөлмөрийн чадваргүй болсон гэр бүлийн гишүүнээ тэтгэх;

4/ хууль тогтоомжид заасан бусад тусламж.

5. Төрийн албан хаагчид тусламж олгох нөхцөл, журмыг Засгийн газар тогтооно.

31 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийн шагнал, урамшил

1. Төрийн албан хаагчид албан тушаалын бүрэн эрхээ үр дүнтэй

биелүүлж өндөр амжилт гаргасан гавьяа зүтгэлийг нь үнэлж төрийн байгууллагын захиргаа түүнийг дараахь байдлаар шагнаж, урамшуулна:

1/ мөнгөн шагнал олгох;

2/ эд зүйл болон үнэ бүхий зүйл дурсгах;

3/ Засгийн газар ба төрийн дээд байгууллагаас шагнуулахаар тодорхойлох.

2. Төрийн албан хаагчид энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас гадна улирлын ажлын үр дүнгээр болон онцгой чухал буюу онц түнээтэй албан даалгавар биелүүлсний төлөө мөнгөн урамшил олгоно.

3. Төрийн албан хаагчийг энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1,2-т заасан шагналаар шагнах болон энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан мөнгөн урамшил олгох журмыг Засгийн газар, энэ зүйлийн 1 дэх хэсгийн 3-т зааснаар шагналд тодорхойлох журмыг хуулиар тус тус тогтооно.

4. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй төрийн захиргааны албан хаагчид түүний зөвшөөрснөөр 1,5 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн урамшил олгож болно.

32 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмж

Төрийн албан хаагчид тэтгэвэр, тэтгэмж олгох, тэтгэврийн сан байгуулах, зарцуулах журмыг хуулиар зохицуулна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Төрийн албаны удирдлага, зохион байгуулалт

33 дугаар зүйл. Төрийн албаны удирдлага

1. Төрийн албан хаагчийн ерөнхий удирдлагыг Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлдэг.

2. Төрийн захиргааны албан хаагчийн стандартын удирдлагыг төрийн албаны төв байгууллага хэрэгжүүлдэг.

3. Төрийн захиргааны албан хаагчийн шуурхай удирдлагыг төрийн байгууллагын ажлын албаны эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлдэг.

4. Төрийн байгууллага нь төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хангахтай холбогдсон дараахь асуудлаар хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлдэг:

- 1/ төрийн албан хаагчийн сургалт;
- 2/ төрийн албан хаагчийн аж байдал;
- 3/ төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа;
- 4/ төрийн албан хаагчийн эрүүл мэнд;
- 5/ төрийн албан хаагчийн амралт, сувилаал;
- 6/ төрийн албан хаагчийн аюулгүй байдал.

5. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хангах хөтөлбөр, тэдгээрийн талаар төрийн байгууллагуудаас хэрэгжүүлэх бодлогыг уялдуулах асуудлыг Ерөнхий сайд бүрэн эрхийнхээ хүрээнд зохицуулна.

34 дүгээр зүйл. Төрийн албаны төв байгууллага

1. Төрийн албаны төв байгууллага нь Төрийн захиргааны албаны зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ мөн.

2. Зөвлөл нь гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд бие даасан байдалтай ажиллах бөгөөд үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана.

3. Зөвлөл нь хамтын удирдлагын зарчмаар ажиллах бөгөөд 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Тэдгээрийн 3 нь орон тооны, 4 нь орон тооны бус байна.

4. Зөвлөлийн орон тооны 3 гишүүнд Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөл тус бүр нэг хүний нэр дэвшүүлдэг. Нэр дэвшигч нь төрийн албан тушаалд 10-аас доошгүй жил ажилласан, ял шийтгэлгүй, Монгол Улсын 35 нас хүрсэн иргэн байна.

5. Улсын Их Хурал Зөвлөлийн орон тооны гишүүнийг 6 жилийн хугацаагаар томилно.

6. Зөвлөлийн орон тооны гишүүнээр нэг удаа улируулан томилж болно.

7. Зөвлөлийн даргыг орон тооны гишүүдийн дотроос Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Ерөнхий сайдын санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилно.

8. Зөвлөлийн орон тооны бус гишүүн нь дор дурдсан албан тушаалтан байна:

1/ Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга;

2/ Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;

3/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;

4/ Шүүхийн ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн дарга.

9. Зөвлөлийн орон тооны гишүүнээр томилогдсон хүний намын

гишүүнийг түдгэлзүүлнэ. Зөвлөлийн орон тооны 3 гишүүний дотор нэг намын хоёр, эсхүл нэг нутгийн бодон нэг анги хамт төгссөн хоёр хүн байж болохгүй.

10. Зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийг Улсын Их Хурал батална.

11. Зөвлөлийн орон тооны гишүүн нь гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон, эсхүл хууль ноцтой зөрчсөн бол түүнийг уг албан тушаалаас нь эгүүлэн татах тухай асуудлыг Зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

12. Зөвлөлийн орон тооны гишүүнээр нөхөн томилогдсон хүн нь орон гарсан өмнөх хүнийхээ бүрэн эрхийн үлдсэн хугацаанд уг албыг хашина.

13. Зөвлөлийн дарга, орон тооны гишүүний цалин хөлс, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад хангамжийг Улсын Их Хурал тогтооно.

14. Зөвлөлийн ажлын албаны үүргийг Засгийн газрын ажлын алба гүйцэтгэнэ.

35 дугаар зүйл. Зөвлөлийн чиг үүрэг

Зөвлөл нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1/ удирдлагын үндэсний чадавхийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

2/ төрийн албаны тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, төрийн захиргааны албанд шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, энэ хуулийн 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан маргааныг хянан шийдвэрлэх;

3/ хууль тогтоомжийн актад нийцүүлэн эрх хэмжээний хээ асуудлаар шийдвэр гаргах, түүнийг өөрчлөх, биелэлтийг нь хангах;

4/ төрийн албан хаагчийн хувийн хэрэг, теобүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох, төрийн алба, төрийн албан хаагчтай холбогдолтой шаардлагатай мэдээллээр Улсын Их Хурал, Ерөнхий дөгч, Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийг хангах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх;

5/ төрийн байгууллагын ажлын албаны төрийн захиргааны албан хаагчийн удирдлагатай холбогдсон үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

6/ төрийн захиргааны удирдах албан тушаалд томилогдох ажилтны талаарх дүгнэлтээ уг ажилтныг томилох эрх бүхий бай-

гууллагад өгөх;

7/ төрийн захиргааны албан хаагчийн хэрэгцээг төлөвлөх, хангалтыг зохион байгуулах;

8/ мэргэшлийн шалгалтаар иргэнийг төрийн захиргааны албанд авах болон төрийн захиргааны албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах;

9/ төрийн албаны ажилтны сургалт болон төрийн албатай холбогдсон судалгаа, шинжилгээний ажлыг зохицуулах;

10/ төрийн байгууллагын бүтэц, албан тушаалын орон тоо, төсөв, цалингийн сан, төрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, тэрэг дэв, төрийн албан хаагчийн цалин хөлс, албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээ, жишиг тогтооход санал өгөх;

11/ төрийн захиргааны албаны үйл ажиллагаанд шинжилгээ хийж, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал боловсруулах, улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн удирдлагын зардлыг төслийг зохиох, хянаж батлахад зохих журмын дагуу санал, хүсэлт гаргах;

12/ төрийн байгууллагаас төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хангахад чиглэсэн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах.

36 дугаар зүйл. Төрийн албаны стандарт

1. Төрийн албаны стандарт нь төрийн албыг үр дүнтэй удирдах, хэрэгжүүлэх, төрийн байгууллага, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахад чиглэнэ.

2. Төрийн албаны стандарт нь төрийн албан хаагчаас албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, санхүү, статистикийн болон төрийн албатай холбогдсон бусад мэдээ, тайлан гаргах, төрийн байгууллага, төрийн албан хаагчаас албан хэрэг хөтлөх, ангилал, архивын баримт бичиг, нэгж бүрдүүлэх, хяналт шалгалт хийх, мэдээллээр хангах зэрэг бусад үйл ажиллагааны журмыг тогтооно.

3. Төрийн албаны стандарт боловсруулж батлах, мөрдөх журмыг Засгийн газар тогтооно.

37 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг,
тоо бүртгэл

1. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг /цаашид "хувийн хэрэг" гэх/ нь төрийн албан хаагчийн тухай болон түүний төрийн албан тушаал эрхэлсэн тухай мэдээлэл агуулна.

2. Төрийн албан хаагчид зөвхөн нэг хувийн хэрэг хөтөлнө.

3. Төрийн албаны төв байгууллага нь төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх бөгөөд уг бүртгэлд төрийн албан тушаал эрхэлж байгаа болон нөөцөд байгаа төрийн бүх албан хаагчийн тухай мэдээ агуулсан байна.

4. Хувийн хэрэг, тоо бүртгэл хөтлөх журмыг төрийн албаны төв байгууллага тогтооно.

38 дугаар зүйл. Төрийн албаны санхүүжилт

1. Төрийн албаны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

2. Төрийн байгууллага нь хуулийн этгээдийн эрх бүхий аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхэлж үл болно.

3. Төрийн үйлчилгээний салбарт хамаарах төрийн байгууллага хууль тогтоомжид заасан журмын дагуу аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхэлж болно.

4. Төрийн албаны зардлыг бууруулах арга хэмжээ авч төсвийн санхүүжүүлэлтийг хорогдуулах нь төрөөс олгож байгаа төрийн албан хаагчид олгох төлбөрийг түр буюу бүрмөсөн зогсоох, тэдний цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг бууруулах үндэслэл болохгүй.

5. Төрийн албаны санхүүжүүлэлт болон төрийн байгууллагын төсөвт хөрөнгийн ашиглалтад тавих хяналтыг хууль тогтоомжид заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.

39 дүгээр зүйл. Төрийн захиргааны албан хаагчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх

1. Төрийн байгууллага болон төрийн захиргааны албан хаагч, түүнд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан дараахь маргааныг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн албаны төв байгууллага хянан шийдвэрлэнэ:

1/ энэ хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 23, 26 дугаар зүйлд заасан асуудлаар төрийн захиргааны албан хаагч, түүнд нэр дэвшигчийн өөрийнх нь гаргасан маргаан;

2/ төрийн захиргааны албан хаагчаас цалин хөлс, ажиллах нөхцөл, баталгааны талаар гаргасан бусад маргаан.

2. Төрийн захиргааны албан хаагч, түүнд нэр дэвшигч нь төрийн албатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэсэн тухай төрийн албаны төв байгууллагын шийдвэрийн талаар шүүхэд гомдол гаргаж болно.

3.Төрийн байгууллага болон төрийн захиргааны албан хаагч, түүнд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журмыг Улсын Их Хурал тогтооно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл.

40 дүгээр зүйл. Хориглох зүйл.

1. Төрийн албан хаагч, иргэнээс мэргэшлийн шалгалт авах, төрийн, албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх, түүнийг томилох, чөлөөлөх, албан тушаалд дэвшүүлэх, албан тушаалаас бууруулах зэрэг асуудалтай холбогдсон бичиг баримт хуурамчаар үйлдэх, шударга бус тодорхойлолт, гэрчилгээ, баталгаа гаргахыг хориглоно.

2. Төрийн албан хаагч албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглахыг хориглоно.

41 дүгээр зүйл. Хууль тогтоомж зорчигчдод
хүлээлгэх хариуцлага

Энэ хуулийг зорчсон этгээд, төрийн албан хаагчид, түүний гэм буруу, зорчлийн шинж байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

42 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 1 дүгээр
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"2. Улсын Их Хурал Байнгын хороог үйл ажиллагааныхаа салбар чиглэлээр байгуулах бөгөөд дараахь Байнгын хороотой байна:

- 1/ Нийгмийн бодлогын;
- 2/ Төрийн байгуулалтын;
- 3/ Төсөв, санхүү, мөнгө, тээлийн бодлогын;
- 4/ Хөдөөгийн бодлого, байгаль орчин;
- 5/ Хууль зүйн;
- 6/ Эдийн засгийн бодлогын"

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 4, 20 дугаар зүйлийн 5, 21 дүгээр зүйлийн 6, 56 дугаар зүйлийн 2, 3, 44 дүгээр зүйлийн 1, 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Дотоод асуудлын байнгын хороо" гэснийг болон 45 дугаар зүйлийн 2, 3, 45³ дугаар зүйлийн 2, 3, 4, 5, 6, 45⁴ дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн "Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо" гэснийг тус тус "Төрийн байгуулалтын байнгын хороо" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 1 дүгээр сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 1 дүгээр
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1994 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Улаанбаатар хотноо байгуулсан "Хилийн усыг хамгаалах бодон ашиглах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 1 дүгээр
сарын 10-нөмдөр

Улаанбаатар
хот

ХҮНСНИЙ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь хүнсний аюулгүй байдлыг хангах болон хүнсний зүйлийн үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбогдон төр, аж ахуйн нэгж, байгууллага иргэний хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хүнсний тухай хууль тогтоомж

1. Хүнсний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг мөрднө.

3 дугаар зүйл. Хуульд хэрэглэсэн нэр томьёо

Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

1/ "хүнсний аюулгүй байдал" гэж хүнсний зүйлийн хангамж, бүтцийн болон чанар, эрүүлэхүйн зохистой хэм хэмжээ хангагдсан байдлыг хэлнэ;

2/ "хүнсний зүйл" гэж хүний хүнсний зориулалтаар бэлтгэсэн түүхий эд, хүнсний нэмэлт, тэдгээрийг боловсруулан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, түүнчлэн хүний хоол унданд болон хүнсний үйлдвэрлэлд хэрэглэдэг усыг хэлнэ;

3/ "хүнсний нэмэлт" гэж хүнсний зүйлд амт, үнэр, өнгө оруулах, хадгалалтын хугацааг нь уртасгах, хүнсний зүйлийг биежүүлэх, сийрэгжүүлэх, өвөрмөц чанартай болгох зэрэг зориулалтаар хэрэглэж байгаа байгалийн болон хими биологийн гаралтай бодис, махбодь, тэдгээрийн хольцыг хэлнэ;

4/ "зориулалтын хүнсний зүйл" гэж хөдөлмөрийн хүнд, хортой, халуун нөхцөлд болон газрын дор ажиллагч, 4 нас хүрээгүй

хүүхэд, жирэмсэн эмэгтэй ба хөхүүд хүүхэдтэй эх, өвчтөнд зориулсан бөгөөд тэдний эрхэлж буй ажил, бие махбодийн онцлогт тохирсон хүнсний зүйлийг хэлнэ;

5/ "хүнсний зүйлийн үйлдвэрлэлийн хэрэгсэл" гэж хүнсний зүйлийн үйлдвэрлэл үйлчилгээнд хэрэглэх багаж, тоног төхөөрөмж, сам, баглаа боодол, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, мал, амьтан, газар, ургамал, ус, мөн эрүүл ахуйн ноцлолыг хангах зориулалтын хувцас, ариутгал цэвэрлэгээний бодисыг хэлнэ;

6/ "үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч" гэж борлуулахад зориулан хүнсний зүйлийг үйлдвэрлэх, бэлтгэх, хадгалах, тээвэрлэх болон хүнсний зүйлийг худалдах ажил байнга буюу түр эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага иргэнийг хэлнэ.

4 дүгээр зүйл. Хоол хүнстэй байх эрх

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт амьдарч байгаа хүн бүр эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, бие махбодийнхоо хэвийн үйл ажиллагаа, өсөлт төлжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөх хоол, хүнс хэрэглэх эрхтэй.

2. Хөдөлмөрийн хүнд, хортой, халуун ноцлолд болон газрын дор ажиллагч, 4 нас хүрээгүй хүүхэд, жирэмсэн эмэгтэй ба хөхүүд хүүхэдтэй эх, өвчтөн /цаашид "зориулалтын хүнс хэрэглэгч" гэх/ зориулалтын хүнсний зүйлээр хангагдах эрхтэй.

3 дугаар зүйл. Хүнсний зүйлээр хангагдах үндсэн зарчим
Иргэн, орх болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүр хүнсний зүйлээр өөрийгөө хангах ийнхүү хангахтай холбогдсон эрх зүйн үндэс, эдийн засгийн ноцлолыг төрөөс бүрдүүлэх нь хүнсний зүйлээр хангагдах үндсэн зарчим мөн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хүнсний асуудлаархи төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, аж ахуйн нэгж, байгууллага иргэний үүрэг

6 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

Улсын Их Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ хүн амын хүнсний аюулгүй байдлыг талаар төрөөс барамтлах бодлогыг тодорхойлж, хэрэгжилтэд нь хяналт тавих;

2/ хүнсний зүйл, түүний үйлдвэрлэлийн хэрэгсэл үйлдвэрлэгчдийг татвар, монго тээлийн бодлогоор хөхүүлэн дэмжих.

7 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

1. Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний зүйлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг дэмжих, хүн амын хүнсний зүйлийн хэрэглээний зохистой хэм хэмжээг хангах, өлсгөлөн, өлөн эзлмүүн байдал, хоол тэжээлээс шалтгаалах өвчнөөс сэргийлэх бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх;

2/ монгол хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт төлжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах хүнсний зүйлийн хангамж, бүтцийн зохистой хэм хэмжээг тогтоож, бодот гүйцэтгэлийг жил бүр Улсын Их Хуралд танилцуулж, нийтэд мэдээлэх;

3/ амьжиргааны баталгаажих түвшингээс бага орлоготой, нэн ядуугаас болж өлсгөлөн, өлөн эзлмүүн байдалд хүрсэн иргэдийн судалгааг гаргаж, өөрийгөө хүнсний зүйлээр хангахад нь тусламж, дэмжлэг үзүүлэх;

4/ амьжиргааны баталгаажих түвшингээс бага орлоготой өрхийн 4 нас хүрээгүй хүүхэд, жирэмсэн эмэгтэй болон хөхүүл хүүхэдтэй эх, хөдөлмөрийн чадваргүй, тахир дутуу иргэд, өндөр настай хүмүүсийг хүнсний хувьд эмзэг хэсэгт тооцож тэдэнд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлнэ;

5/ хүнсний зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх, түүнд эрүүл ахуйн аюулгүй байдлын баталгаажуулалт хийх журам тогтоох;

6/ хүн амын ундим төвлөрсөн усан хангамжийн сан, өргөх байгууламжийг тусгай хамгаалалтад байлгах журмыг тогтоох.

2. Засгийн газар нь хүнсний зүйлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дараахь байдлаар хөхүүлэн дэмжинэ:

1/ сүү, мах, гуриал, тэдгээрээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болон хүүхдийн хоол тэжээлийг чанар сайтай, байнга тогтвортой үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжийн худалдааны албан татварыг хөнгөлөх, чөлөөлөх;

2/ хүнсний зүйлийн үйлдвэрлэл, үйлчилгээний тэргүүний технологи эзэмших, импортыг орлох хүнсний зүйлийг үйлдвэрлэх зориулалтаар импортлосон үйлдвэрлэлийн хэрэгсэл болон хүүхдийн хоол тэжээл, жимс жимсгэний гааль, худалдааны татварыг хөнгөлөх;

3/ хүүхдийн хоол тэжээл үйлдвэрлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

4/ мал аж ахуй, газар тариалангийн нэгжээс авах хүнсний бүтээгдэхүүнийг тогтвортой нэмэгдүүлэх болон эрчимтэй технологи нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг урамшуулах журам тогтоож хэрэгжүүлэх.

3. Засгийн газар нь хүнсний зүйлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хөхүүлэн дэмжих, хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор хүнсний зүйлийн улсын сан байгуулж, түүний дүрмийг батална.

4. Засгийн газар нь хүнсний зүйлийн дотоодын тэнцлийг харгалзан тухайн жилд экспортлох хүнсний зарим зүйлийн хэмжээг тогтоож болно.

5. Засгийн газар нь хүнсний дотоодын тах тээлийг хамгаалах зорилгоор олон улсын худалдааны хэлэлцээрийн нийтлэг зарчимд нийцүүлэн тухайн жилд импортлох хүнсний зарим зүйлийн хэмжээг зохицуулж болно.

8 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

1. Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ хүнсний зүйлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, үндэсний уламжлалт болон дэвшилт технологи нэвтрүүлэх, хүнсний зүйлийн бүтэц, тэжээллэг чанарыг нь сайжруулах, нэр төрлийг олшруулах бодлогыг хэрэгжүүлэх;

2/ аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, сургаал зохион байгуулах;

3/ хүнсний зүйл, түүний үйлдвэрлэлийн хэрэгсэлийг үйлдвэрлэхэд мөрдөх технологийн нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг тогтоож, биелэлтийг нь хянан шалгах;

4/ тусгай зөвшөөрөлтэйгээр үйлдвэрлэх хүнсний зүйлийн үйлдвэрлэл эрхлэх хүсэлтийг зохих журмын дагуу хянаж, саналыг Засгийн газарт оруулах;

5/ хүн амин ундны усны хангамжийг сайжруулах, усны нооц, уст цэгийг нэмэгдүүлэх, усыг цэнгэгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх.

2. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах талаар хүнсний зүйл, түүний үйлдвэрлэлийн хэрэгслийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн нийтлэг мөрдөх журам, зааврыг батлах, биелэлтийг нь хянан шалгах;

2/ хүнсний зүйлийг ариутгах, хадгалах хугацааг нь уртасгах, мал, амьтныг эмчлэх, өсөлт бойжилтыг нь түргэтгэх, ургацыг нэмэгдүүлэх, хог ургамал, хортон шавьж, мэрэгч устгах зориулалттай цацраг идэвхт үүсгүүр, эм, даавар, бордоо, пестицид болон химийн бусад бодис, хүнсний үйлдвэрлэлд ашиглаж буй бичил биотэн, био бэлдмэлийн үлдэгдэл тухайн хүнсний зүйлд эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхэд хяналт тавих журам тогтоож мөрдүүлэх, биелэлтэд хяналт тавих;

3/ зориулалтын хүнс хэрэглэгчдийн хэрэглэх хүнсний зүйлийн зохистой хэм хэмжээг тогтоох;

4/ хүн амын хэрэглэсэн хүнсний зүйлийн бүтэц, чанар, илчлэг нь зохистой хэм хэмжээ болон эрүүл ахуйн шаардлагыг хэрхэн хангаж байгаад судалгаа хийж, дүгнэлт гаргах.

9 дүгээр зүйл. Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, улсын тэрэглэлтэй хотын захирагч нутаг дэвсгэрийнхээ хүн амын хүнсний аюулгүй байдлын талаарх бодлого, хөтөлбөр боловсруулж тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж хэрэгжүүлнэ. Энэ нь хүн амын хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогын салшгүй хэсэг байна.

2. Аймаг, нийслэлийн Засаг дарга, улсын тэрэглэлтэй хотын захирагч мэдэлдээ хүнсний зүйлийн тодорхой хэмжээний нөөцтэй байж болно. Нөөц бүрдүүлэх, зарцуулах, сөнхүүжүүлэх журмыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

3. Бүх шатны Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ хүнсний зүйлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдээс үйлдвэрлэл, үйлчилгээ шинээр зохион байгуулах, өргөтгөх, шинэчлэх, инженерийн байгууламж, шугам сүлжээгээр үйлчлүүлэх, газар ашиглах, эзэмших зөвшөөрөл авахад нь тэргүүн ээлжинд дэмжлэг тусалцаа үзүүлэх;

2/ аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс хүнсний бүтээгдэхүүн борлуулах нөхцөлийг нь бүрдүүлж, хяналт тавих;

3/ хүн амын хүнсний аюулгүй байдлын талаарх бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, нутаг дэвсгэрийнхээ хүн амын хэрэглэний бодит гүйцэтгэлийг жил бүр тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан дээд шатны Засаг дарга буюу Засгийн газарт мэдээлж, шаардлагатай арга хэмжээ авах;

4/ хүнсний зүйлээр өөрийгөө хангах боломжийг бүрдүүлэхэд нь нутаг дэвсгэрийнхээ өрх, иргэдэд тусламж дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

5/ хүн амыг ундны усаар хангах ажлыг зохион байгуулж, ундны усны эх булаг, сан, ус түгээх шугам сүлжээ, тоног төхөөрөмж, бусад байгууламжийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих.

10 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын
үүрэг

1. Аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа хөдөлмөрийн хамтын гэрээ байгуулахдаа ажиллагчдынхаа хүнсний хангамжид дэмжлэг үзүүлэх, тэднийг ажлын үед нь хоол ундаар үйлчлэх асуудлыг түүнд тусгана.

2. Хөдөлмөрийн хүнд, хөртэй, халуун нөхцөлд болон газрын дор ажиллагсдыг ажлын үед нь зориулалтын хүнсний зүйлээр үйлчилнэ.

11 дүгээр зүйл. Иргэний журамт үүрэг

Хөдөлмөрийн чадвартай иргэн бүр эзэмшиж буй газар, мал, тэжээвэр амьтдын ашиг шинг, байгалийн өгөөжийг зохистой ашиглах, хүнсний зүйлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх замаар өөрийн болон гэр бүлийнхээ хүнсний хэрэгцээг хангах, хүнсний зүйлийг зохистой хэрэглэх соёл, мэдлэг, арга барил эзэмших журамт үүрэг хүлээнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Стратегийн болон улсын нөөцийн хүнсний зүйл

12 дугаар зүйл. Стратегийн хүнсний зүйл

1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын стратегийн хүнсний зүйл /цаашид "стратегийн хүнсний зүйл" гэх/ нь мах, буудай, тариаг үр байна.

2. Стратегийн хүнсний зүйлийн үйлдвэрлэлийг улсын захиалга өгөх, татварыг хөнгөлөх, хөнгөдөлттэй тээл олгох зэргээр төрөөс хөхүүлэн дэмжинэ.

3. Стратегийн хүнсний зүйлийн үйлдвэрлэлийг хөхүүлэн дэмжиж банкнаас хөнгөдөлттэй нөхцөлөөр олгосон тээлийн хүүгийн зөрүүтэй тэнцэх хэмжээний орлогыг тухайн банкны орлогын албан татвараас чөлөөлж болно.

13 дугаар зүйл. Улсын нөөцийн хүнсний зүйл,
түүний нэр төрөл, тоо хэмжээ

1. Байгалийн гамшиг, үйлдвэрийн томоохон осол, гэнэтийн бусад аюул учирч хүнсний хангамжийн ноцтой бэрхшээл тохиолдсон нөхцөлд болон зэвсэгт хүчний дайчилгаанд хэрэглэх зорилгоор хүнсний зүйлийн улсын нөөцийг бүрдүүлнэ.

2. Улсын нөөцийн хүнсний зүйлд тураг мах, нөөш, амьтны болон ургамлын гаралтай тос, буудай, түүний үр, гурил, төрөл бүрийн будаа, элсэн чихэр, ётон, цай, хатаамаа сүү, давс, этилийн спиртгүйг тооцно.

3. Улсын нөөцийн хүнсний зүйлийн нэр төрлийг өөрчлөх шаардлага гарвал Засгийн газар Улсын Их Хуралд саналаа оруулж шийдвэрлүүлнэ.

4. Үндэсний аюулгүй байдлыг хангах шаардлагад нийцүүлэн улсын нөөцөд хуримтлуулах хүнсний зүйлийн тоо, хэмжээг Засгийн газар жил бүр тогтооно.

14 дүгээр зүйл. Улсын нөөцийн хүнсний зүйлийг бүр-
дүүлэх, хадгалах, шинэчлэх, зарцуулах,
нөхөн сэлбэх, хяналт тавих

1. Улсын нөөцийн хүнсний зүйлийг нэр төрөл, тоо хэмжээний дагуу бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, зарцуулах, нөхөн сэлбэх, хяналт тавих журмыг Засгийн газар тогтооно.

2. Улсын нөөцийн хүнсний зүйлийг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, зарцуулах, нөхөн сэлбэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

3. Улсын нөөцөөс зарцуулах хүнсний зүйлийн үнэ төлбөрийн асуудлыг Засгийн газар тухайн нөхцөл байдалд зохицуулж шийдвэрлэнэ.

4. Улсын нөөцийн хүнсний зүйлийн хөдөлгөөн, чанарын байдлын талаар Засгийн газар жил бүр Улсын Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд мэдээлж байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хүнсний зүйлийн чанар, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах, түүнд тавих хяналт

15 дугаар зүйл. Хүнсний зүйлийн эрүүл ахуйн аюулгүй байдал

1. Эрүүл ахуйн үзүүлэлт нь зөвшөөрөгдсөн хэмжээнд байгаа хүнсний зүйлийг аюулгүй гэж үзнэ.

2. Хүнсний зүйлийн эрүүл ахуйн үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээг Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуульд заасан журмын дагуу тогтооно.

16 дугаар зүйл. Хүнсний зүйлийн чанар, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах талаар үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн хүлээх үүрэг

1. Хүнсний зүйлийн үйлдвэрлэл, үйлчилгээг технологи, стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангасан нөхцөлд эрхэлж, бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, эрүүл ахуйн аюулгүй байдлыг сариуцна.

2. Хүнсний зүйлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх аж ахуйн эгжийг үүсгэн байгуулагч нь улсын бүртгэлд бүртгүүлэхийн өмнө энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан тухай үгнээлтийг эрүүл ахуйн хяналтын эрх бүхий байгууллагаар гаргуулна.

3. Шинээр үйлдвэрлэж эхэлж байгаа хүнсний зүйлийг стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангасан тухай эрх бүхий байгууллагаар үгнээлт гаргуулсны дараа худалдана.

4. Хүнсний зүйл, түүний үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, эрүүл ахуйн байдлыг эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанд шалгуулна.

5. Хүнсний зүйлийн үйлдвэрлэл, үйлчилгээнд шинээр ашиглах ижил биетэн, химийн бодис нэгдэл, хүнсний нэмэлт, эм, даавар, бордоо, шавьж мэрэгчийн устгалын хор, цацраг идэвхт үүсгүүрийг эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын эрх бүхий байгууллагад бүртгүүлнэ.

6. Хүнсний зүйлийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, зориулалттай машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сав, баглаа

боодол, ариутгал цэвэрлэгээний бодис нь стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан байна. Хүнсний зүйлийг стандарт, эрүүл ахуйн шаардлагын дагуу савлаж бооно.

7. Хүнсний зүйлийн үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, зайлшгүй хяналтад байвал зохих тоног төхөөрөмжийг шинээр суурилуулах ажлыг хяналтын эрх бүхий байгууллагуудтай зөвшилцсөн зураг төслийн дагуу гүйцэтгэнэ.

8. Хүнсний зүйлийн сав, баглаа боодол буюу шонгонд үйлдвэрлэсэн огноо, хадганах нөхцөл, хэрэглэх хугацаа, үйлдвэрлэгчийн хягийг тэмдэглэх бөгөөд хэрэв стандартад заасан бол тохирлын тэмдэг, найрлага, хэрэглэх аргыг заана.

9. Монгол Улсад мөрдөж байгаа стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангасан хүнсний зүйл, түүний үйлдвэрлэлийн хэрэгслийг импортлоно.

10. Импортлогч нь хүнсний экспортлогч улсын эрх бүхий байгууллагын чанар, эрүүл ахуйн баталгаатайгаар эсхүл дээж загварыг нь Монгол Улсын чанар, эрүүл ахуйн хяналтын байгууллагаар урьдчилан шинжлүүлж, дүгнэлт гаргуулсны дараа импортлоно.

11. Хүнсний зүйлийг хүнсний зах, түүнчлэн эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад цэгт худалдана.

12. Хүнсний зүйлийн үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллагсдыг тогтоосон журмын дагуу эрүүл мэндийн үзлэгт хамруулна.

13. Иргэн, албан тушаалтан нь хүнсний зүйлийн чанар, эрүүл ахуйн аюулгүй байдлын талаар төрийн хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомжид нийцүүлэн тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

17 дугаар зүйл. Хүнсний зүйлийн чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд тавих төрийн хяналт

1. Хүнсний зүйлийн чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд тавих төрийн хяналтыг эрүүл ахуй, хялдар судлал, стандартчилал, чанарын баталгаажуулалт, мөлэмнэлэг, ургамал хамгаалал, хорио цээрийн зэрэг хууль тогтоомжоор эрх олгогдсон байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ.

2. Хүнсний зүйлийн чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд төрийн хяналт тавих төв, орон нутгийн эрх бүхий байгууллага тэдгээрийн улсын байцаагчид дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ хүнсний зүйлийн чанар, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомж түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэрийн биелэлтийг хянан шалгах, гарсан зөрчлийг таслан зогсоох, арилгуулах, зөрчил гаргагчдад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүдээлгэх;

2/ хүний эрүүл мэндэд хортой болох нь тогтоогдсон хүнсний зүйлийг акт үйлдэж устгуулах;

3/ хүнсний зүйлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн үйлдвэрлэж, тээвэрлэж, хадгалж, худалдаж байгаа хүнсний зүйлийн чанар, эрүүл ахуйн байдал, түүнийг баталгаажуулсан баримт бичигтэй танилцах, шаардлагатай гэж үзвэл шинжилгээ хийх зорилгоор хүнсний зүйлийн дээж, загварыг зохих баримт бүрдүүлж үнэ төлбөргүй авах;

4/ хүнсний зүйлийн чанар, эрүүл ахуйн аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийг судалж дүгнэлт гаргах, авах арга хэмжээний талаар санал боловсруулж холбогдох байгууллагад оруулах, хүнсний аюулгүй байдлын талаар мэдээллийн сан бүрдүүлэх;

5/ хоол хүнсний гаралтай хөрдлөг, хөрдлөгөт халдварын шалтгааныг тогтоох, таслан зогсоох, мэдээлэх;

6/ энэ хуулийн 16 дугаар зүйлийн 2, 3, 10 дахь хэсэгт заасан дүгнэлтийг ажлын 7 хоногт, харин ноошилсон хүнсний зүйлийн шинжилгээ дүгнэлтийг 30 хоногт багтаан гаргана.

3. Хүнсний зүйлийн чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд тавих төрийн хяналтыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ аймаг, нийслэлийн хяналтын албандыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд сургалт зохион байгуулах;

2/ мэргэжлийн хяналтын боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүдэх ажлыг зохион байгуулах;

3/ хүнсний зүйлийн стандарт, эрүүл ахуйн үзүүлэлтийг боловсруулж батлуулах;

4/ стандарт, эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний зүйл түүний үйлдвэрлэлийн хэрэгслийг гадаадаас оруулахыг зогсоох;

5/ энэ хуулийн 16 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан зүйлийг ашиглаж буй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг улсын бүртгэлд бүртгэж хяналт тавих;

6/ хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудлаар гадаад улсын болон олон улсын холбогдох байгууллагатай зохих журмын дагуу хамтран ажиллах.

18 дугаар зүйл. Хүнсний зүйлийн чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд тавих дотоод хяналт

Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид нь эрх бүхий байгууллагаас тогтоосон нийтлэг шаардлагад нийцүүлэн технологийн горим, ариун цэврийн дүрмээ баталж, тэдгээрийн болон стандарт, эрүүл ахуйн шаардлагын хэрэгжилтэд дотоод хяналт тавих журам тогтоож, биелэлтийг нь хангана.

19 дүгээр зүйл. Хүнсний аюулгүй байдалд тавих олон нийтийн хяналт

Иргэн, олон нийтийн байгууллага хүнсний аюулгүй байдалд хяналт тавьж илэрсэн зөрчлийг төрийн захиргааны болон хяналтын эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтийг сэрэмжлүүлж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

20 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Хүнсний тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд түүний гэм буруу, зөрчлийн шинж байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

2. Хүнсний тухай хууль тогтоомж дараахь байдлаар зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, эрх бүхий улсын байцаагч дор дурдсан шийтгэл ногдуулна:

1/ эрх бүхий байгууллагаас зөвшөөрөгдөөгүй цэгт хүнсний зүйлийг нийтэд худалдсан, хүнсний зүйлээр нийтэд үйлчилсэн бол иргэнийг 10000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж байгууллагыг 50000 төгрөгөөр торгох;

2/ энэ хуулийн 16 дугаар зүйлийн 2, 3, 10 дахь хэсэгт заасан дүгнэлтийг зохих хугацаанд гаргаж өгөөгүй, мөн энэ хуулийн 16 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт заасан эрүүл мэндийн үзлэгт

хамрагдвал зохих этгээд уг үзлэг хийлгэхээс санаатайгаар зайлсхийсэн бол 10000 хүртэл төгрөгөөр торгох;

3/ энэ хуулийн 16 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасан зүйлийг хүнсний зүйлийн сав, баглаа боодол буюу шонгонд тэмдэглээгүй, мөн 16 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан ажлыг эрх бүхий байгууллаагатай зөвшилцөөгүй зураг төслийн дагуу гүйцэтгэсэн, батлагдсан зураг төслийг зөрчсөн бол иргэнийг 15000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 75000 хүртэл төгрөгөөр торгох;

4/ хүнсний зүйлийн үйлдвэрлэл, үйлчилгээг технологи, стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангаагүй нөхцөлд эрхэлсэн, мөн хүнсний зүйл, түүний үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, эрүүл ахуйн байдалыг зохих хугацаанд нь шалгуулаагүй бол иргэнийг 20000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000 хүртэл төгрөгөөр торгох;

5/ үүрэг бүхий албан тушаалтан хүнсний зүйлийн үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллагсдыг тогтоосон журмын дагуу эрүүл мэндийн үзлэгт хамруулаагүй бол 1000-25000 төгрөгөөр торгох;

6/ хүнсний зүйлийн үйлдвэрлэл, үйлчилгээнд стандарт, эрүүл ахуйн шаардлага хангаагүй машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сав, баглаа боодол, ариутгал цэвэрлэгээний бодис хэрэглэсэн, ийнхүү шаардлагыг зөрчиж савлаж боосон, мөн хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээнд энэ хуулийн 16 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан зүйлийг зохих байгууллагад бүртгүүлэхгүйгээр ашигласан, тэдгээрийг хэрэглэх эрүүл ахуйн аюулгүй байдлын шаардлага зөрчсөн бол иргэнийг 2000-25000 төгрөгөөр торгох, аж ахуйн нэгж, байгууллагыг 10000-125000 төгрөгөөр торгох;

7/ энэ хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүртгэлгүйгээр хүнсний зүйлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсэн бол иргэнийг 3000-30000 төгрөгөөр торгох, аж ахуйн нэгж, байгууллагыг 15000-150000 төгрөгөөр торгох;

8/ хүнсний зүйлийн чанар, эрүүл ахуйн аюулгүй байдлын талаар төрийн хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомжид нийцүүлэн тавьсан шаардлагыг биелүүлдээгүй бол иргэнийг 5000-40000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 25000-200000 төгрөгөөр торгох;

9/ шинээр үйлдвэрлэж эхэлж байгаа хүнсний зүйлийг энэ хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан дүгнэлтгүйгээр худалдсан, мөн энэ хуулийн 16 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт

завсан баталгаагүй хүнсний зүйлийг импортлосон, худалдаа үйлчилгээнд гаргасан бол хууль бусаар олсон орлого буюу эд зүйлийг хураах буюу хураахгүйгээр иргэнийг 10000-40000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-200000 төгрөгөөр торгох;

10/ хүнсний зүйлийн сав, баглаа боодол, буюу шошгонд түүнийг үйлдвэрлэсэн огноо, хадгалах нөхцөл, хэрэглэх хугацаа, үйлдвэрлэгчийн хаяг, тохирлын тэмдэг, найрлага, хэрэглэх аргыг хуурамчаар үйлдсэн, тэмдэглэсэн бол хууль бусаар олсон орлого буюу эд зүйлийг хурааж иргэнийг 10000-40000 төгрөгөөр торгох, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-200000 төгрөгөөр торгох.

3. Энэ хуулийн 16 дугаар зүйлийн 1, 5, 6, 7 дахь хэсгийн заалтыг зөрчсөн тохиолдолд хүнсний зүйлийн үйлдвэрлэл, үйлчилгээг тухайн зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар түр зогсооно.

4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ зүйлийн 2 дахь хэсэгт завсан шийтгэлийг үндэслэлгүй оногдуулсан, мөн 3 дахь хэсэгт завсан арга хэмжээг буруу авсан гэж үзвэл гомдлоо захиргааны буюу шүүхийн журмаар гаргаж болно.

5. Хүнсний тухай хууль тогтоомж зөрчсөнөөс бусдад учруулсан хохирлыг гэм буруутай этгээдээр хууль тогтоомжийн дагуу нөхөн төлүүлнэ.

21 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 1 дүгээр
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулиар тогтоосон төрийн захиргааны албан тушаал эрхэлж байгаа, энэ хуульд заасан нөхцөл, болзлыг хангасан төрийн албан хаагчийг Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагчид хамааруулсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан төрийн захиргааны албан хаагчдад Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан нэмэгдэл баталгаа 2000 он дуустаалх хугацаанд үл хамаарна.

3 дугаар зүйл. 2000 он дуустаалх хугацаанд төрийн байгууллага оорчлогдсон, татанбуугдсан, эсхүлөөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо нь хасагдсаны улмаас төрийн албанаас чөлөөлөгдсөн энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан төрийн захиргааны албан хаагчид 6 сарын албан тушаалын цалинтай нь тэнцэх нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.

4 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 3-т заасан албан ажлын онцгой нөхцөл, төрийн алба хаасан хугацааны болон зэрэг дэвийн нэмэгдэл, мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан нохон төлбөрийг 1996 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн үе шаттайгаар олгоно.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 1 дүгээр
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭР БҮЛИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэр бүлийн хуулийн 61 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"Тэжээн тэтгүүлэх эрх бүхий бусад хүн тутмын тэжээн тэтгүүлэх тэтгэврийн хэмжээг шүүх тэтгэлэг төлөгчийн цалин, орлогын байдал эрх бүхий байгууллагаас тогтоосон нэг хүнд ногдох амьжиргааны баталгаажих доод түвшингийн хэмжээ, тэтгэлэг төлөгч болон авагчийн амьдралын байдлыг харгалзан сард ногдох тэтгэлгийг бас төгрөгөөр тогтоож болно."

2 дугаар зүйл. Энэ хуулийг буцаан хэрэглэхгүй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

ЦАХИЛГААН, ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ, НҮҮРСНИЙ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цахилгаан, дулааны эрчим хүч, нүүрсээр хангах гэрээнд хэрэглэсэн цахилгаан болон дулааны эрчим хүч, нүүрсний үнийг хугацаанд нь төлөөгүй бол хангагч байгууллагын нэхэмжилсний дагуу хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллагын харилцах данснаас төлбөрийг шууд хийлгэх тухай нөхцөлийг заана.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан төлбөрийн гүйлгээг цахилгаан, дулааны эрчим хүч, нүүрсээр хангах гэрээнд заасныг үндэслэн банкны байгууллага хийнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тавьсан хоригийг хүлээж авсантай холбогдуулж "Банкны хуулийн зарим заалтыг дагаж мөрдөх хугацааны тухай" 1995 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн Монгол Улсын хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬД ЗАРИМ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөдөлмөрийн хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "3/ олон улсын эмэгтэйчүүдийн өдөр-гуравдугаар сарын 8;" гэснийг "3/ эх, үрсийн өдөр -зургадугаар сарын 1;" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1. Хот, тосгон нь засаг захиргааны хувьд оршин байгаа тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт, харьяалагдана."

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "дагуул хот /алслагдсан дүүрэг, хама хот/" гэсний дараа, тосгонтой" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1995 оны 1 дүгээр
сарын 10-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар
хот

**Хүнсний тухай хуулийг хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай**

Хүнсний тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1/ Хүнсний тухай хуульд Засгийн газрын холбогдох тогтоол, шийдвэрийг нийцүүлэх;

2/ Хүнсний тухай хуульд заасан дүрэм, журам, хэм хэмжээг 1995 оны 1 дүгээр улиралд багтаан боловсруулж батлах;

3/ улсын нооцийн хүнсний зүйлийн тоо, хэмжээг шинэчлэн тогтоож, 1995 оны 3 дугаар улиралд багтаан бүрдүүлэх;

4/ хүнсний зүйлийн үйлдвэрлэл, хангамж, хэрэглээ, бүтэц, чанар, эрүүл ахуй, хоол хүнсний холбоотой хүн амын өвчлөл, хордлого, нэн ядуу болон хүнсний хувьд эмзэг хэсэгт тооцогдох иргэдэд үзүүлсэн туслэмж, дэмжлэгийн талаар салбарын статистик мэдээллийн тогтолцоог бий болгох;

5/ гадаад орнуудын хүнсний туслэмжийн бараа борлуулсны орлого болон зориулалтын зээл, бусад эх үүсвэрийг оновчтой ашиглах замаар хүнсний сэнг бүрдүүлэх;

6/ хүнсний зүйлээр өөрийгөө хангах, хүнсний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, уламжлалт арга ажиллагааг сэргээх, шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэхэд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, өрх, иргэдэд мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, сургаж даяалцагжуулах ажиллагааны нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх;

7/ хүнсний зүйлийн үйлдвэрлэл, үйлчилгээнд чанар, эрүүл ахуйн хяналт тавих байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, дээж загварыг шинэчлэх зөвшөөрөл, дүгнэлт олгох шат дамжлагыг багасгах;

8/ хүнсний зүйлийн чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд хяналт тавих үндэсний нэгдсэн лаборатори байгуулах асуудлыг 1995 оны 3 дугаар улиралд багтаан шийдвэрлэх.

2. Энэ тогтоолыг биелэлтийн талаар 1995 оны 4 дүгээр улиралд Улсын Их Хуралд танилцуулахыг Хөдөөгийн бодлого, байгалиорчин байнгын хороонд даалгасугай.

ДАРГА

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1995 оны 1 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар
хот

**Санал хураах комисс байгуулах
тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Их Хурлын Байнгын хороодын дарга нарыг сонгох ажлыг зохион байгуулж, дүнг илтгэх үүрэг бүхий санал хураах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

- 1/ Ц. Гомбосүрэн
- 2/ С. Гүндэнбал
- 3/ М. Зэнээ
- 4/ Ч. Пүрэвдорж
- 5/ Л. Энэбиш

ДАРГА

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1995 оны 1 дүгээр
сарын 12-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар
хот

**Улсын Их Хурлын Байнгын хороо-
дмн дарга нарыг сонгох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан журмын дагуу Улсын Их Хурлын Байнгын хороодмн даргад нэр дэвшүүлэн хэлэлцэж, нууцаар санал хураасан тухай санал хураах комиссын 1995 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 2, 3 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар Б. Дэмбэрэл;
2. Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Д. Лүндээ-жанцан;
3. Төсөв, санхүү, мөнгө, зээлийн бодлогын байнгын хорооны даргаар А. Базархүү;
4. Хөдөөгийн бодлого, байгаль орчны байнгын хорооны даргаар М. Далайхүү;
5. Хууль зүйн байнгын хорооны даргаар Ц. Шаравдорж;
6. Эдийн засгийн бодлогын байнгын хорооны даргаар Ж. Дэлгэр-цэцэг нарыг тус тус сонгосугай.

ДАРГА

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1995 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар
хот

Цалинг тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Үнэт цаасны хорооны даргын сарын үндсэн цалинг 20500 төгрөгөөр тогтоосугай.

ДАРГА

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1995 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 15

Улаанбаатар
хот

**Улсын Их Хурлын Байнгын хороодын
тусгай чиг үүргийг хуваарилах
тухай**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Шинээр байгуулагдсан Байнгын хороодын тусгай чиг үүргийг Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын Байнгын хорооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах хүртэл дараахь байдлаар хуваарилсугай:

1/ Хурал, захиргааны, Дотоод асуудлын, Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороодын тусгай чиг үүргийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

2/ Боловсрол, шинжлэх ухаан, соёлын болон Хүн ам зүй, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгэм хангамжийн байнгын хороодын тусгай чиг үүргийг Нийгмийн бодлогын байнгын хороонд;

3/ Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн бодлогын байнгын хорооны тусгай чиг үүргийг Эдийн засгийн бодлогын байнгын хороонд;

4/ Хүнс, хөдөө аж ахуйн болон Байгаль орчныг хамгаалах байнгын хороодын тусгай чиг үүргийг Хөдөөгийн бодлого, байгаль орчны байнгын хороонд.

2. Эрх мэдлийн хүрээнд хариуцах тусгай чиг үүрэгт нь өөрчлөлт оргогүй Байнгын хороо Улсын Их Хурлын Байнгын хорооны түрэмд заасан тусгай чиг үүргийг хэвээр хэрэгжүүлсүгэй.

ДАРГА

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1995 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар
хот

Зарим дүүргийг татан буулгах
тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Туул дүүргийг татан буулгаж Хан-Уул дүүрэгт, ачуурт дүүргийг татан буулгаж Баймзүрх дүүрэгт, Жаргалант дүүргийг татан буулгаж Сонгино-Хайрхан дүүрэгт тус тус нэгтгэн арьшлуулсугай.

2. "Улаанбаатар /нийслэл/ хотын район, хороог татан буулгаж, ингээр дүүрэг байгуулах тухай "Монгол Улсын Их Хурлын 1992 ны 8 дугаар сарын 18-ны өдрийн 18 дугаар тогтоолын хоёр дахь эсгийн "8. Туул дүүрэг", "11. Жаргалант дүүрэг", "12. Гачуурт үүрэг" гэснийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээг 1995 оны 4 дүгээр арын 1-ний дотор зохион байгуулахыг Засгийн газарт даалгасугай.

ДАРГА

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1995 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар
хот

**Д. Даваасамбууг үүрэгт ажлаас нь
чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

1. Дээрх Д. Даваасамбууг Монгол Улсын Сангийн сайдын үүрэг ажлаас чөлөөлсүгэй.
2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөхөө тогтоосугай.

ДАРГА

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1995 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар
хот

**Э. Бямбажавыг Сангийн сайдаар
томилдох тухай**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

1. Эрдэнийн Бямбажавыг Монгол Улсын Сангийн сайдаар томилох тухай.
2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөхөө тогтоосугай.

ДАРГА

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1995 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын 1995 оны
хаврын чуулганаар хэлэлцэх
асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын 1995 оны хаврын чуулганаар дор
урьдсан асуудал хэлэлцүүлэхээр тогтоосугай:

- 1/ Төрийн удирдлагын хяналт шалгалтын тухай хууль;
- 2/ Байгаль орчныг хамгаалах тухай багц хууль;
- 3/ Төлбөр хураамжийн тухай багц хууль;
- 4/ Нөхөрлөл, компаний тухай хууль;
- 5/ Хоршооны тухай хууль;
- 6/ Коррупцийн эсрэг тэмцэх тухай хууль;
- 7/ Боловсролын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- 8/ Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмын тухай
ууль;
- 9/ Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
ухай хууль;
- 10/ Улсын Их Хурлын Сонгуулийн хуульд нэмэлт өөрчлөлт
руулах тухай хууль;
- 11/ Улсын аюулгүй байдлыг хангах, нууцын тухай багц хууль;
- 12/ Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хууль;
- 13/ Харьматын тухай хууль;
- 14/ Онц байдлын тухай хууль;
- 15/ Ард нийтийн санал асуулгын тухай хууль;
- 16/ Векселийн хууль;
- 17/ Зээл, хадгаламж, төлбөр тооцооны хууль;
- 18/ Төрийн дээд шагналын тухай хууль;
- 19/ Бусад асуудал.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1994 оны 12 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 164

Улаанбаатар
хот

**Доржийн Дашбалданг Хөдөлмөрийн
гавьяаны улаан тугийн одонгоор
шагнах тухай**

Монголын дүрслэх урлагийн судлалыг хөгжүүлэх, манай зураач, урчуудын уран бүтээлийг дотоод гадаадад болон дээхийн сонгодог дүрслэх урлагийг өөрийн оронд сурталчлах, музейнхээ сан хөмрөгийг судалгаа шинжилгээний чиглэлээр төрөлжүүлэн баяжуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Дүрслэх урлагийн музейн захирал Доржийн Дашбалданг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1994 оны 12 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 165

Улаанбаатар
хот

**Дамбийн Машлайг Хөдөлмөрийн
гавьяаны улаан тугийн одонгоор
шагнах тухай**

Геологийн байгууллаагад үр бүтээлтэй ажиллахын зэрэгцээ олон арван дууг ард түмний сэтгэл зүрхэнд хоногштал чадварлаг дуулж радиогийн урын санг баяжуулан, урлаг соёлоор хөдөлмөрчдөд үйлчлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Шарын гол дахь "Их өвөлжөө" алтны уурхайн геологич инженер, уран сайханыч Дамбийн Машлайг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1994 оны 12 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 166

Улаанбаатар
хот

**Намчингийн Энхмаг "Шударга журам"
медалиар шагнах тухай**

Эр зориг, авхаалж самбаа гарган галын аюулаас хүүхдийн амь
наарч иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Баянхонгор аймгийн
Залцагаан сумын 5 дугаар багийн малчин Намчингийн Энхмаг
"Шударга журам" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1994 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 167

Улаанбаатар
хот

**Д. Чулуундоржийг элчин сайдын үүрэгт
ажлаас чөлөөлөх тухай**

Д. Чулуундоржийг Монгол Улсаас Бүгд Найрамдах Бангладеш
Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын үүрэгт
ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П. ОЧИРБАТ

1/ энэ хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үйл ажиллагаанд хэрэглэж байгаагаас бусад өөрийн хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийх;

2/ өөрийн хэмжих хэрэгслийг загварын туршилт, баталгаа жууллаагд болон шалгалт тохируулгад хугацаанд нь бүрэн хамруулж байгаа эсэхэд хяналт тавих;

3/ хэмжих хэрэгслийн техникийн бэлэн байдал, ашиглалтад болон хэмжил гүйцэтгэх аргачлал, хэмжлийн шаардагдах нарийвчлал, хэмжилзүйн дүрэм, журмын мөрдөлтөд хяналт тавих;

4/ өөрийн үйл ажиллагаанд өлөрсөн хэмжлийн нэгдмэл байдал хангах тухай хууль тогтоомж, хэмжилзүйн дүрэм, журмын зөрчлийг арилгах.

14 дүгээр зүйл. Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга

1. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үйл ажиллагаанд хэрэглэхээс бусад хэмжих хэрэгслийг импорттоор нийлүүлэх, үйлдвэрлэл, засвараас гарсны дараа, мөн худалдах, бусда хэрэглүүлэх болон ашиглалтын мицэд шалгалт тохируулгад хамруулж болно.

2. Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгын ажил, үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага нь Хэмжилзүйн төв буюу иймэг, нийслэлийн хэмжилзүйн байгууллагаас тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авна.

3. Шалгалт тохируулга хийх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллага хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгыг хийхдээ баталгаатай эталоныг ашиглана.

4. Шалгалт тохируулга хийсэн хэмжих хэрэгсэлд шалгасан тэмдэг дарах буюу шалгалт тохируулгын гэрчилгээ олгож, ашиглалтын баримт бичигт тэмдэглэнэ.

5. Зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагын шалгалт тохируулгын ажилд Хэмжилзүйн төв болон аймаг, нийслэлийн хэмжилзүйн байгууллага хяналт тавина.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХЭМЖИЛЗҮЙН БАЙГУУЛЛАГА

15 дугаар зүйл. Хэмжилзүйн байгууллагын тогтолцоо
Хэмжилзүйн байгууллага нь Хэмжилзүйн төв болон аймаг, нийслэл

ийн хэмжилтүйн байгууллагаас бүрдэнэ.

16 дугаар зүйл. Хэмжилтүйн төв байгууллага

1. Хэмжилтүйн төв байгууллага нь улсын хэмжээнд хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, хэмжилтүйн төрийн хяналт шалгалтыг эрэгжүүлэх төрийн захиргааны байгууллага мөн.

2. Хэмжилтүйн төв байгууллага нь дараахь үйл ажиллагааг хөгжүүлнэ:

1/ хэмжлийн нэгдмэл байдлыг хангах талаарх төрийн бодлого, хэмжилтүйн төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх;

2/ хэмжлийн нэгж, нэгжийн эталоныг бий болгох асуудлыг бохирдуулж холбогдох байгууллагад тааьж шийдвэрлүүлэх;

3/ хэмжлийн нэгжийн эталоныг хадгалах, ашиглах, харьцуулан илгэж баталгаажуулах;

4/ энэ хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгсэлд баталгаажуулалт, тохируулхийх тэдгээрт баталгаажуулалт, тохируулга хийх зөвшөөрлийг олбогдох мэргэжлийн байгууллагад олгох;

5/ аймаг, нийслэлийн хэмжилтүйн байгууллага болон мэргэжлийн байгууллагуудын хэмжлийн лабораторийг итгэмжлэх;

6/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хэмжих хэрэгслийн шийдвэрлэл, засвар, худалдаа эрхлэх, бусдад хэрэглүүлэх болон лгаалт тохируулга хийх зөвшөөрөл олгох;

7/ улсын, анхдагч болон ажлын эталон, бодис, материалын бүтэц, шинж чанарын стандартчилсан загварыг зохион бүтээх, эталон болон хэмжлийн нарийвчлалыг дээшлүүлэх асуудлаар шалгаа, шинжилгээ, туршилт, зохион бүтээлтийн ажил хийх;

8/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын захалгаа, гэрээний дагуу төлбөрт ажил, үйлчилгээ явуулах;

9/ хэмжлийн нэгдмэл байдлыг хангахтай холбогдох улсын стандартыг зохих журмын дагуу батлуулах, хэмжилтүйн дүрэм, журам, индартчилсан загварыг баталж мөрдүүлэх;

10/ эрхэлсэн асуудлаараа олон улсын байгууллагад гишүүнээр элэх, олон улс, бүс нутаг, гадаад улсын холбогдох байгууллаалдтай хамтын ажиллагааг хөгжүүлэх;

11/ аймаг, нийслэлийн хэмжилтүйн байгууллагыг мэргэжлийн эрдлагаар хангах, мэдээлэл арга зүйн туслаацаа үзүүлэх.

3. Хэмжилтүйн төв байгууллага нь төр, олон нийт болон шинжт ухааны холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөгчс бүрдсэн орон тооны бус зөвлөлтэй байна.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1995 оны 1 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар
хот

Цэцийн тухай хууль Үндсэн хууль зөрчсөн тухай маргааны талаар

Үндсэн хуулийн Цэцийн энэ дүгнэлтийг 1995 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 12 дэвт Төрийн ордны 251 дүгээр тасалгаанд үйлдэн, Цэцийн хуралдааныг Цэцийн гишүүн Д. Баасан даргалж, гишүүдэд Г. Нямдоо /илтгэгч/, Ц. Цолмон, Ж. Бямбаа, Ч. Энхбаатар нар оролцов. Цэцийн хуралдааны нарийн бичгийн даргаар Цэцийн нарийн бичгийн дарга Б. Цэндээхүүг оролцуулан хийн.

Хуралдаанд маргагч талыг төлөөлж иргэн Д. Ламжав, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн Д. Дашцэдэн нар оролцов.

Иргэн Д. Ламжав 1994 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Үндсэн хуулийн Цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

"1. Цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Иргэд энэ хуулийн 8 дугаар зүйлийн 3-т заасан албан тушаалаар Үндсэн хуулийг зөрчсөн тухай асуудлаар Цэцэд өргөдөл мэдээлэл ирүүлнэ гэсэн заалт Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1, Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар ... хэвн шийдвэрлэнэ гэсэн заалтыг зөрчиж байна.

Учир нь цэцийн тухай хуулийн дээрх заалт ёсоор иргэн Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4 дүгээр заалтын дагуу л өргөдөл мэдээлэл ирүүлэх болсон байна. Хэрэв энэ заалтыг баримталбал хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэхгүй байгаа тухай иргэнээс ирүүлсэн өргөдөл, мэдээллийг Цэц авч хэлэлцэх ёсгүй болж байна.

Гэтэл Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 Үндсэн хуулийн Цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараахь маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна гэснээс ч ийм эрх иргэнд олгогдсон нь ойлгомжтой байна.

2. Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2, Улсын Их Хурал . . . хүсэлтээ чуулган буюу хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналд үндэслэж гаргана гэсэн заалт Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1, Үндсэн хуулийн Цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг Улсын Их Хурлын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ гэсэн заалтыг зөрчиж байна.

Учир нь Улсын Их Хурал шийдвэрээ олонхиор гаргадаг бөгөөд гаргасан шийдвэрээ хамгаалах зүй ёсны сонирхол тухайн шийдвэрийг гаргасан олонхид бай. Гэтэл Үндсэн хууль зөрчсөн шийдвэр гарч болох ба энэхүү зөрчлийг шийдвэр гаргасан олонхи ямар нэг шалтгаанаар /хуулийн сүлжээг дутуу ашиглах, тухайн үеийн улс төрийнхөө сонирхолд хөтлөгдөх зэргээр/ олж харахгүй, нэгэнт гаргасан шийдвэрээ Цэцээр хянуулахад олох юмгүй тул Цэцэд хүсэлт гаргах сонирхол төрөхгүй. Ийнхүү хуулийн энэ заалт нь Үндсэн хуулийн тухайн заалтын үйлчилгээг хаасан байна. Энэ нь Үндсэн хуулийг дээдлэх хэвийн үйл ажиллагаанд ч муугаар нөлөөлж болно. Төрийн ардчилсан тогтолцоотой улсуудад харьцангуй ноон тооны гишүүн хамтран эсвэл намын бүлэг Үндсэн хууль зөрчигдсөн тухай маргаан үүсгэж Үндсэн хуулийн нүүхдээ хандах эрхийг хуулиар урьдчилан олгосон байдаг нь парламент алдаагаа өөрөө засах, хууль тогтоох үйл ажиллагаанд ямбай хандах, төрийн тогтвортой байдлыг хангах хөшүүрэг болж өгдөг байна.

Цэцийн тухай хуулийн энэ заалт нь тарим үед парламент дахь улс төрийн тэмцэлийг гудамжинд гүдгэн гаргах одоон хатгалгийн сүрэг гүйцэтгэж ч мэдэх юм" гэжээ. Д. Ламжав 1995 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Цэцэд өгсөн нэмэлт тайлбартаа:

"... 10 дугаар зүйлийн 2 дахь заалтыг намын бүлэг, эль эсвэл Улсын Их Хурлын тодорхой тооны гишүүн хамтран Улсын Их Хурлын хүсэлтийг гаргаж болдог байхаар өргөтгөвөл Үндсэн хуулийн тодорхой заалтын үйлчилгээг хавь байгаа дээрх зөрчил ирнэ. Ийм боломж нээгдсэнээр Улсын Их Хурлын үйл ажиллагаанд хууль дээдлэх хамтран ажиллах явдалд ахиц гарах, төрийн эрхийн төлөө намуудын хоорондох улс төрийн тэмцэл илүү облатой болох нь дамжиггүй. Миний өргөдөлд бичигдсэн Үндсэн хууль зөрчигдөж байгаа тухай маргааныг анхааралтай хянан шийдвэрлэж өгнө гэдэгт гүнээ найдаж байна" гэжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д. Дамсцэдэн Цэцийн хуралдаанд оролцож тайлбарлахдаа

Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалт Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалттай зөрчилдсөн юм байхгүй. Цаана нь иргэдээс Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандах эрх нээлттэй байгаа гэж үзэж байна. Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт ч мөн Үндсэн хуулийг зөрчөөгүй Улсын Их Хурал бол хамтын хариуцлагын байгууллага учраас шийдвэрээ олонхийн санаалд үндэслэн гаргадаг ёстой гэв.

Д. Ламжав Цэцийн хуралдаанд оролцож тайлбарлахдаа нэмж хэлээд байх зүйл байхгүй байна. Өргөдөл, нэмэлт тайлбартаа тодорхой тайлбарлаад хэлчихсэн байгаа гэв.

Хянавал:

Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай аль ч асуудлаар Үндсэн хуулийн Цэцэд хандах тухай иргэдэд Үндсэн хуулиар нэгэнт олгогдсон эрхийг хэт хязгаарлаж, зөвхөн Цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан албан тушаалтанд хамруулж уг эрхийг эдлүүлэх болгосноор Үндсэн хуулийг илэрхий зөрчихөд хүргэсэн байна.

Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөвхөн Улсын Их Хурлын баталсан хуулиуд хийгээд түүний бусад шийдвэрүүдтэй холбон явцууруулж ойлгох нь учир дутагдалтай тул энэ хэсгийн заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна. Иймээс энэ талаархи иргэн Д. Ламжавын гомдлыг хангах боломжгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон гаргах дүгнэлт:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

3. Энэхүү дүгнэлтийг хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг Улсын Их Хурлын хаврын чуулган эхэлснээс хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилж байна.

ДАРГА

Л. БААСАН

ГИШҮҮД:

Г. НЯМДОО

Ц. ЦОЛМОН

Ж. БЯМБАА

Ч. ЭНХБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 222

Улаанбаатар
хот

Комисс байгуулах тухай

Зах зээлийн эдийн засгийн харилцааны нөхцөлд хүн амын амьжиргааны нийгмийн баталгааг алдигдуулахгүй байх үүднээс "Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай" Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлд заасан шаардлагыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, нийтийн хэрэглээний бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, тарифын үндэслэлд хяналт тавьж зохицуулах механизм бий болгох зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Үнийн төвшлийн комисс"-ийг ажиллах журмыг хавсралтын ёсоор баталж 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдүүлсүгэй.

2. Энэ журмын дагуу үнийн төвшлийн комиссыг Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгтэй төвшилцөн байгуулж ажиллуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1991 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 187 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл, "Үнийн комисс байгуулах тухай" 1991 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 224 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Худалдаа, үйлдвэрийн сайд

Ц. ЦОГТ

Монгол Улсын сайд богоод

Үндэсний хөгжлийн газрын дарга

Ч. УДААН

Засгийн газрын 1994 оны 222
дугаар тогтоолын хавсралт

“ҮНИЙН ЗӨВШЛИЙН КОМИСС”-ЫН А ЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1. Энэхүү журмын зорилго нь тухайн зах тээлд аж ахуйн нэгж, үйлдвэр, үйлчилгээний газрын дангаар ноёрхох явдлыг хязгаарлах, хүн амын амьжиргааны нийгмийн баталгааг алдагдуулахгүй байх үүднээс “Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай” Монгол Улсын хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөт үнийн тогтолцооны хүрээнд нийтийн хэрэглээний бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ тарифын үндэслэлийг хянан зөвшилцөж, тохицуулахад оршино.

2. Үнийн зөвшлийн комиссыг Засгийн газар болон аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд ажиллуулна.

3. Засгийн газрын дэргэдэх комиссыг Монгол Улсын Шадар сайдаар ахлуулан байгуулна. Комиссын бүрэлдэхүүнийг Засгийн газрын тогтоолоор батална.

4. Нийслэл, аймгийн комиссыг нийслэл, аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулан холбогдох аж ахуйн нэгжүүд эзэд, хоршоологчдын байгууллага, үйлдвэрчний болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах байгууллага, Иргэдийн төлөөлөгчид, нийслэл, аймгийн Засаг даргын Тамгын газрын төлөөлөгчдийн тэнцүү төлөөллийн бүрэлдэхүүнтэйгээр Засаг даргын дэргэд байгуулж ажиллуулна.

5. Засгийн газрын дэргэдэх комисс нь нийтийн хэрэглээний бүтээгдэхүүн, үйлчилгээ болох төвийн эрчим хүчний системээр гүгээж буй цахилгаан, дулаан, автобензин, онгоцны түлш, дизелийн түлш, мазут, тосолгооны материалын үнэ, төмөр зам, иргэний гаармын тээвэр, харилцаа, холбооны үйлчилгээний тарифын үндэслэлийг хянаж, үнийн түвшинг зөвшилцөн нийтлэг жишиг, тохих ювлөмж, чиглэл гаргана.

6. Нийслэл, аймгийн Засаг даргын дэргэдэх комисс нь хотын доторхи тээврийн үйлчилгээний тариф, нэгдсэн системд холбогдоогүй эрчим хүчний үйлдвэрүүдийн цахилгаан, дулааны үнэ, эрөн сууцны талбайн болон халаалтын хөлсний тариф, бусад үйлчилгээний тариф, цэвэр, бохир ус, нүүрсний үнийн үндэс-

дэлийг хянаж, үнийн туйшинг зөвшилцөн тохиролцон нийтлэг жишгийг тогтоож, нийслэл болон тухайн аймгийн нутаг дэвсгэрт мөрдүүлэх талаар зөвлөмж, чиглэл гаргаж нийтэд мэдээлнэ.

7. Комисс нь Монгол Улсад мөрдөгдөж буй хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

8. Комисс нь зах зээлд давамгайлах болон монополь байдалтай аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүний үнэ, үйлчилгээний тарифыг бүртгэж хяналт тавих бөгөөд аймаг, нийслэлийн комисс нь хүнсний зүйлийн үйлдвэрлэлийг дэмжих, эрээлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангах бодлогыг хэрэгжүүлэх, хүн ам, ялангуяа малчид, тариаланчдийн орлогыг нэмэгдүүлэх зорилт, түүнчлэн хэрэглэгчдийн зүй ёсны эрх ашгийг харгалзан мах, гурил, талх, томс, хүнсний ногоог худалдах үнийн талаар санал боловсруулан зөвшилцөж жишгийг тогтоох арга хэмжээ авч болно.

Хоёр. "Үнийн зөвшлийн комисс"-ийн ажлалах журам

9. Комисс нь дээр дурдсан бүтээгдэхүүний үнэ, үйлчилгээний тарифын үндэслэлийг тухайн зах зээлийн эрээлт, нийлүүлэлттэй уялдуулан хянаж, зөвшилцөн тохиролцсон тухай шийдвэр гаргана.

10. Комиссын шийдвэрийг комиссын бүрэлдэхүүнд орсон талууд санал зөвшилцөн тохиролцсон нөхцөлд гаргана.

11. Аж ахуйн нэгжүүд бүтээгдэхүүний үнэ, ажил, үйлчилгээний тарифын талаархь саналаа комисст ирүүлэхдээ үнэ тарифын үндэслэл болох зардлыг мөрдөгдөж буй тохих нормативаар тооцон, нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу тусгасан байх шаардлагатай бөгөөд үнийн үндэслэлийг төрөл зүйл бүрээр тодорхой тооцон ирүүлсэн байна. Шаардлагатай бол холбогдох газрууд гол хэрэглэгчдийн саналыг авсан байна.

12. Аж ахуйн нэгжүүдээс үнэ оорчлох талаар ирүүлсэн үндэслэл, саналыг комисс нягтлан үзээд ажлын 5 хоногийн дотор зөвшилцөн тохиролцож шийдвэрлэн олон нийтэд мэдээлнэ.

13. Комиссын шийдвэрт тухайн үнэ, тарифын үндэслэл, туйшинг хянаж, зөвшилцөн тохиролцсон талаар болон үнийг мөрдөх хугацаа, бусад холбогдох заалтыг тодорхой тусгана. Энэхүү шийдвэрийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэд үнэ тохиролцохдоо харгалзан үзнэ.

14. Комисс түүнчлэн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Үйлдвэрчний эвлэл, нутгийн захиргааны байгууллага, иргэд нь комиссын шийдвэрээр тогтоосон үнийн жишгээс үндэс-

дээгүйгээр зөрүүтэй үнэ тогтоон монополизм байдлаа яшиглан хэрэглэгчдийг хохироож байгааж ахуйн нэгжийн талаар "Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай" хуулийн дагуу Үндэсний хөгжлийн газарт мэдэгдэж шийдвэрлүүлнэ.

15. Комисс нь шаардлагатай гэж үзвэл комиссын ажилд холбогдох байгууллагатай тохиролцон мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж болно.

16. Комисс нь үйлдвэрлэгч, хэрэглэгчдийг нийтийн хэрэглээний бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбогдол бүхий үнийн мэдээллээр хангах ажлыг зохион байгуулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН-ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 223

Улаанбаатар
хот.

Эрүүл мэндийн даатгалын хураамж, даатгалтай иргэний эмчилгээний зард- лын хувь хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, "Иргэний эрүүл мэндийн даатгалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлд заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-г заасан иргэний 1995 онд төлөх эрүүл мэндийн даатгалын сар тутмын хураамжийг тэдний цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 6 хувиар, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 3-8-д заасан даатгуулагч болон хувиараа хөдөлмөр эрхлэгч малчны хураамжийг сар тутам 200 төгрөг байхаар тогтоосугай.

2. Төвлөрсөн төсвөөс 1995 онд эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлэх хөрөнгийн хэмжээг 1200,0 сая төгрөгөөр тогтоож, түүнийг хуульд заасан хугацаанд нь шилжүүлж байхыг Сангийн яам /Д. ДАВААСАМБУУ/-д даалгасугай.

3. Даатгалтай иргэний эмчилгээний зардалд эрүүл мэндийн даатгалын сангаас нохон төлөх төлбөрийн 1995 онд баримтлах дээд хязгаарыг 300000 төгрөгөөр тогтоосугай.

4. Эрүүл мэндийн даатгалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад "Монгол даатгал" компани, түүний салбаруудад 1995 онд шаардагдах хөрөнгийн нормативыг уг даатгалын орлогын 2,5 хувиар тогтоосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Эрүүл мэндийн даатгалын хураамжийн хувь хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 1993 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 185 дугаар тогтоолын 1, 5, 6 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцугай.

Монгол Улсын Ерөнхий сайд
Эрүүл мэндийн сайд
Сангийн сайд

П. ЖАСРАЙ
П. НЯМДАВАА
Д. ДАВААСАМБУУ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1994 оны 12 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 225

Улаанбаатар
хот

**Хувьчлалын санг байгуулах, зарцуу-
лах журамд нэмэлт өөрчлөлт
оруулах тухай**

Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, нийгмийн мээг хэсгийг ядуурааас хамгаалах тогтолцоог бүрдүүлэх шаардлагыг харгалзан Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "БНМАУ-ын Өмч хувьчлах тухай хуулийг хэрэгжүүлэхтэй олбогдсон зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1991 ны 6 дугаар сарын 7-ны өдрийн 169 дүгээр тогтоолоор баталсан 3 дугаар хавсралт) "Хувьчлалын санг байгуулах, зарцуулах журам"-ын 9 дүгээр зүйлд:

- хөрөнгө оруулалтын эх үүсвэр болгох;
- хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн эмзэг хэсгийн хөдөл-
өрийн чадвартай иргэдийг ажлаар хангах, иргэдийн орон сууцны
арилга барих арга хэмжээг санхүүжүүлэх" гэсэн нэмэлт оруул-
угай.

Монгол Улсын Ерөнхий сайд
Монгол Улсын Шадар сайд
Сангийн сайд

П. ЖАСРАЙ
Д. ЭНЭБИШ
Д. ДАВААСАМБУУ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1994 оны 12 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 226

Улаанбаатар
хот

**Тогтоолын зарим заалтад өөрчлөлт
оруулах тухай**

"Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай" Монгол Улсын Их Хурлын 1994 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 89 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "БНМАУ-ын Өмч хувьчлах тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1991 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 169 дүгээр тогтоолоор баталсан (2 дугаар хавсралт) "Үйлдвэрийн газрын хувьчлах эд хөрөнгийн үнэлгээний журам"-ын "Дөрөв", 12 дугаар зүйл, мөн тогтоолоор баталсан (5 дугаар хавсралт) "Дуудлагын худалдааг зохион байгуулж явуулах нийтлэг журам"-ын 17 дугаар зүйлд тус тус "маргааныг" гэснийг "гомдлыг" гэж өөрчилсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 1991 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 169 дүгээр тогтоолоор баталсан (2 дугаар хавсралт) "Үйлдвэрийн газрын хувьчлах эд хөрөнгийн үнэлгээний журам"-ын 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, мөн тогтоолоор баталсан (5 дугаар хавсралт) "Дуудлагын худалдааг зохион байгуулж явуулах нийтлэг журам"-ын 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Монгол Улсын Шадар сайд

Л. ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 12 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 228

Улаанбаатар
хот

**"Улсын сайн малчин", "Улсын
тэргүүний тариаланч" шалга-
руулж байх тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Мал сүргээ өсгөн, малын үүддэр чанар, ашиг шимийг нь айжруулж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан малчныг "Улсын сайн малчин", газар тариалангийн үйлдвэрлэлийг үр дүнтэй эрхлэн, ургац нэмэгдүүлэх, газрын ашиглалтыг сайжруулах, тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаалалтыг нэмэгдүүлэх талаар өндөр амжилт гаргасан тариаланчийг "Улсын тэргүүний тариаланч"-аар тус тус шалгаруулан шагнаж байхаар тогтоосугай.

2. "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч"-ийг шалгаруулан шагнаж байх журмыг энэ тогтоолын 1, 2 дугаар ансралтын ёсоор "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч"-ийн үнэмлэх, энгэрийн тэмдгийн тодорхойлолтыг 3 дугаар ансралтын ёсоор тус тус баталсугай.

3. "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч"-ийн нэмлэх, энгэрийн тэмдэг, мөнгөн азарганы дүрс болон ангыг 1995 оны 1 дүгээр сард багтаан шинэ загвараар хийлгэхийг Хүнс, одоо аж ахуйн яам /Ц.ӨӨЛД/-д даалгасугай.

4. "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч"-ийн тагналд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган гаргаж айхыг Сангийн яам /Д. ДАВААСАМБУУ/-д даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд
Монгол Улсын Шадар сайд
Хүнс, хөдөө аж ахуйн сайд

П. ЖАСРАЙ
Л. ЭНЭБИШ
Ц. ӨӨЛД

Засгийн газрын 1994 оны 228 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

"УЛСЫН САЙН МАЛЧИН"-ААР ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Мал сүргээ өсгөн үржүүлж ашиг шим, чанарыг нь дээшлүүлэн мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан 10 хүртэлх малчныг жил бүр шалгаруулан "Улсын сайн малчин" шагнал олгож байна.

2. "Улсын сайн малчин" шагнал олгох асуудлыг Хүнс, хөдөө аж ахуйн сайдмн саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

Хоёр. "Улсын сайн малчин"-аар шалгаруулахад харгалзах үзүүлэлт

3. Улсын сайн малчныг шалгаруулахад дараахь үзүүлэлтийг харгалзана:

- а) нэг малгаас ашигласан ашиг шим;
- б) цөм, торгон сүрэг болон нутгийн шилмэл малын тоо, нийт сүрэгт тэдгээрийн эзлэх хувийн жин;
- в) үржилд зориулан бойжуулж, бусад өрх, аж ахуйд нийлүүлсэн үржлийн хээлтэгч, хээлтүүлэгч малын тоо, чанар;
- г) малга үр төлөөр нь жил дараалан өсгөсөн байдал;
- д) малын арчилгаа, маллагаа, ардын эмчилгээ, үржүүлгийн уламжлалт аргыг эзэмшсэн байдал.

Гурав. "Улсын сайн малчин"-аар малчдыг тодорхойлоход баримтлах үндэслэл

4. Хөдөө аж ахуйн чиглэлийн аж ахуйн нэгжийн мал шилладаг малчин нь сүүлийн 3 жил дараалан аж ахуйн болон амины мал сүргээ үр төлөөр нь өсгөж хонин толгойд шилжүүлснээр 1000 буюу бөхөд шилжүүлснээр 150-иас доошгүй мал тоолуулсан, төл бойжуулалт, ашиг шим ашиглалтаар дээд амжилт гаргасан, аж ахуйтайгаа хийсэн гэрээ хэлцэл, даалгавар, захиалгыг бүрэн биелүүлсэн байна.

5. Хувийн аж ахуйтан буюу мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг хувиараа эрхлэх аж ахуйн эзэд нь мал сүргээ үр төлөөр нь 3 жил дараалан өсгөж оны эхний зуун хээлтэгч тутмаас бойжуулсан төл, нэг малгаас ашигласан ашиг шимийн үзүүлэлтээр дээд амжилт

гаргасан, хонь толгойд шилжүүлснээр 1000 буюу бодод шилжүүлснээр 150-иас доошгүй малтай байна.

6. Малыг бодод шилжүүлэхдээ Монгол Улсын хүн амын орлогын албан татварын хуулийн 6 дугаар зүйлд заасан итгэлцүүрийг баримтлах бөгөөд шалгаруулж байгаа малчин маа сүрэгт тавиул малыг оруулж тооцохгүй.

7. Хуц, ухна малладаг малчин нь сүүлийн 3 жилд малдаа дундаас дээш тарга хүч авахуулж, зүй бусаар мал хорогдуулаагүй, гэрээ, хэлцлээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлдсэн байхын дээр хариуцан малладаг хуц, ухны тоо 300-гаас доошгүй байвал зохино.

8. Саалийн чиглэлийн аж ахуйн нэгж, фермерийн малчин сүүлийн 3 жил дараалан 25-аас доошгүй үнээ хариуцан зүй бусын хорогдолгүй маллаж, үнээ бүрээсээ жил тутам тугал бойжуулан хариуцсан үнээнийхээ 80 хувийг байнга сааж жилийн турш сүү үйлдвэрлэсэн байхын дээр нэг үнээнээс сааж ашигласан сүүгээр гухайн үүлдрийн үнээний хувьд дээд амжилт тогтоосон байна.

9. "Улсын сайн малчин"-аар тодорхойлогдож байгаа малчин нь гухайн үүлдрийн жишигт тэнцсэн шилмэл хээлтүүлэгч ашиглаж сүүнийгээ жил тутам үржлийн албаар баталгаажуулсан байх бөгөөд малыг удам гарвал, ашиг шим, бие бялдраар нь шилэн сонгох арга барилыг сайн эзэмшсэн байна.

10. Уг малчин нь өөрийн тохижуулсан өвөлжөө, хаваржаа, судог устай, бэлчээр нутгаа хуваарьтай хамгаалж ашигладаг, зэрэгцээт хадлан, гар тэжээлээ хүрэлцээтэй бэлтгэж авдаг, тайгаль, цаг уур, улирлын аливаа нөхцөл байдалд малын хариулага, идлэлгээг тааруулж тохицуулах, малын халдваргүй өвчин эмгэгийг эмчлэх арга барилыг эзэмшсэн, малч ажиллагаагаараа шаларсан байна.

11. Мал өсөлт, сүргийн хөдөлгөөн, төл бойжуулалт зэргийг аг, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн мал тооллогын үндсэн баримт материалгаар ашиг шим ашиглалтыг борлуулалт хийсэн баримт, ржлийн албанаас хийсэн хяналтын жиллэлт, хиргалт, самналт, үүнчлэн сааманд хийсэн судалгаа дүгнэлтийг үндэслэн тогтооно.

12. Мал сүргийн эрүүл мэнд, үржлийн ажил, мал маллагаа, мчилгээний арга туршлага, цом, торгон сүргийн хувийн жин, ржилд бойжуулсан малын тоо, чанар, бэлтгэсэн тэжээл, хашаа айрм хангамж зэргийн тодорхойлолтыг сумын мал эмнэлэг, ржлийн алба гаргана.

13. "Улсын сайн малчин" шагналыг малчинд нэг л удаа олгоно.

14. Улсын сайн малчинг улсын аварга малчинтай адилтган үзэх тул урьд нь "Улсын аварга" болсон малчинг "Улсын сайн малчин"-аар шалгаруулахгүй.

15. Тууварын мал хариуцан малдаж тарга хүч сайн авахуулсан малчинг тухайн гэрээ, хэлцэл байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагаас урамшуулан шагнана.

16. "Улсын сайн малчин"-аар тодорхойлогдож байгаа малчин нь хууль тогтоомжийн дагуу аливаа татвар хураамжийг цаг тухайд нь төлсөн, малаа хууль тогтоомжийн дагуу даатгуулсан байх бөгөөд энэ тухай тодорхойлолт магадалгааг сум, дүүргийн татварын байцаагч, даатгалын албанаас гаргасан байна.

17. "Улсын сайн малчин"-д тодорхойлогдох малчин тухайн орон нутагтаа нэр хүндтэй, бусдаддаа тусалж, талуу малчдыг дэмждэг, тэдэнд мал маллагааны арга барилыг зааж эзэмшүүлдэг, хамт олонхоо итгэл хүлээсэн хүн байна.

**Дөрөв. "Улсын сайн малчин"-д тодорхойлох,
шалгаруулах зарчим**

18. Баг хорооны Засаг даргаас санаачлан "Улсын сайн малчин"-ы шаардлага хангасан гэж үзэж байгаа малчин тодорхойлолтыг бүрдүүлж, багийн иргэдийн хурлаар хэлэлцүүлэн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

19. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар баг, хорооноос ирүүлсэн малчдын тодорхойлолт, материалыг хинан үзэж хамгийн ондорамжилт гаргасан нэг хүнийг шалгаруулна аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тодорхойлож хүргүүлнэ.

20. Сум, дүүргээс ирүүлсэн материалыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хинан үзээд шаардлагатай үзүүлэлтийг газар дээр нь шалган тодруулж аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн шийдвэрээр ажлын хамгийн өндөр үзүүлэлттэй 1-3 малчин материалыг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор Хүнс, хөдөө аж ахуйн яаманд ирүүлнэ.

21. Хүнс, хөдөө аж ахуйн яам аймаг, нийслэлээс ирүүлсэн хүмүүсийн материалыг үзүүлэлт бүрээр цуваагаар байр эзлүүлж нь өндөр үзүүлэлттэй малчинг шалгаруулна.

22. "Улсын сайн малчин"-аар тодорхойлохдоо дараахь материалыг бүрдүүлнэ. Үүнд:

а) малчин анкет (1 дүгээр хүснэгтээр);

б) ажлын үзүүлэлт (2 дугаар хүснэгтээр);

в) баг, хорооны иргэдийн Хурлын тэмдэглэл;

г) аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, ажлын үзүүлэлтийг баталгаажуулж шалгасан акт.

23. Аймаг, нийслэл, сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн болон татвар, давтгалын болон цагдаагийн албаны төдөрхойлолт.

Тав. Улсын сайн малчинд олгох шагнал

24. "Улсын сайн малчин"-ээр шалгарсан малчинд "Улсын сайн малчин"-ы үнэмлэх, энгэрийн тэмдэг олгож 10 лагчийн цалин цагаан мөнгөөр урласан азарганы дүрс, 150 мянган төгрөгөөр шагнана.

25. "Улсын сайн малчин"-ы шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгийг тохноздуулан гардуулна.

"УДСЫН САЙН МАЛЧИН"-ААР ШАЛГАРУУЛАХ
МАЛЧНЫ АНКЕТ

199 оны сарын өдөр

Аймаг

- 1 Сум, баг, аж ахуйн нэр
- 2 Малчны овог, нэр
- 3 Нас, хүйс
- 4 Ам бүл
- 5 Боловсрол
- 6 Гавьна, шагнал
- 7 Аймаг, нийслэлийн (хотын)
аварга (сайн малчин) болсон
он, үнэмлэхийн дугаар
- 8 Хийж байсан ажил, малчнаар
ажилласан хугацаа

Анкет бичсэн хүний гарим үсэг

УДСМН САЙН МАЛЧИН-ААР ТОДОРХОЙЛОГДОН
 БАЙГАА АЙМГИЙН
 СУМЫН МАЛЧИН -НИ
 АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

Ажлын үзүүлэлт	Малын төрөл	Онгууд		
		199	199	199
1	2	3	4	5
Оны эхний бүх мал /толгой/ Үүнээс:	Бүгд Тэмээ Адуу Үхэр Хонь Ямаа			
Хээлтэгч /толгой/ Үүнээс	Бүгд Ингэ Гүү Эм хонь Эм ямаа			
Хээлтүүлэгч /толгой/ Үүнээс:	Бүгд Буур Азарга Бух Хуц Ухна			
Бойжсон төл /толгой/ Үүнээс	Бүгд Ботго Унага Тугал Хурга Ингэ			
Шалж ирсэн мал /толгой/ Үүнээс	Бүгд Тэмээ Адуу Үхэр Хонь Ямаа			
Зүй бусаар хорогдсон мал /толгой/ Үүнээс:	Бүгд Тэмээ Адуу Үхэр Хонь Ямаа			

	1	2	3	4	5
7. Төл, Үүнээс		Бүгд Ботго Унага Тугал Хурга Ишиг			
8. Амьндаа хэрэглэсэн бо- лон бусдад өгсөн мал а/бүгд		Бүгд Тэмээ Адуу Үхэр Хонь Ямаа			
б/өөрийн хэрэгцээнд хэрэглэсэн мал /толгой/ Үүнээс:		Бүгд Тэмээ Адуу Үхэр Хонь Ямаа			
в/аймаг, хот болон бу- сад газарт нийлүүл- сэн/толгой/ Үүнээс:		Бүгд Тэмээ Адуу Үхэр Хонь Ямаа			
г/үржид үүнээс		Бүгд Тэмээ Адуу Үхэр Хонь Ямаа			
9. Оны эцэст бэлэн байгаа мал /толгой/ Үүнээс		Бүгд Тэмээ Адуу Үхэр Хонь Ямаа			
10. Ашиг шим ашигласан байдал а/нийт үйлдвэрлэл /ашиг шимийг нэр төрлөөр бичнэ/		Тэмээний ноос, кг Хонины ноос, кг Ямааны ноо- луур, кг Сүү, л			

1	2	3	4	5
6/1 малаас янгалсан /ашиг шимийг нэр төрлөөр бичнэ/	Тэмээний моос, гр Хонины моос, гр Ямааны моолуур, гр			
в/сүү /л/	Ингэнээс Гүүнээс Үнэнээс Эм хониноос Эм ямаанаас			
1 Цөм, торгом сүрэг, нутгийн шилмэл мал /толгой/	Тэмээ Адуу Үхэр Холь Ямаа			
2 Төлбөл зохих албан татвар /мян. төг./	Үүнээс: төлсөн /мян. төг./			
3 Өөрийн хүчээр бэлтгэсэн тэмээл	Өвс /тн/ Гар ба сү- виллийн тэ- мээл /тн/ Бусад /тн/			

- Тайлбар - Аж ахуйн нэгжийн мал сүрэг хариуцаж маллаа байгаа бол тэдгээрийг энэ хүснэгтээр тусад нь гаргана.
- Аж ахуйн нэгжтэй хийсэн гэрээ хэлцлийн бөөлөлтийг тодорхойлолт болон тусгай хүснэгтээр гаргаж хөвсөргөнө.
- Цөм, торгом сүрэг, нутгийн шилмэл мал гэсэн 11 дүгээр зүйл тодорхой тайлбартай байна. /Ямар үүлдэр, үүлдрийн хэсэг, нутгийн шилмэл малд хамаарах нь тодорхой байна/.

Засгийн газрын 1994 оны 228 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

"УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ"-ААР ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Газар тариалангийн үйлдвэрлэлийг үр дүнтэй эрхэлж, ургац нэмэгдүүлэх, газрын ашиглалтыг сайжруулах, тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаалалтыг нэмэгдүүлэхэд өндөр амжилт гаргасан 5 хүртэл тариаланчийг жил бүр шалгаруулах "Улсын тэргүүний тариаланч" шагнал олгож байна.

2. "Улсын тэргүүний тариаланч" шагнал олгох асуудлыг Засгийн газрын баталсан журмын дагуу Хүнс, хөдөө аж ахуйн сайдмы саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

Хоёр. "Улсын тэргүүний тариаланч"-аар шалгаруулах, тодорхойлох зарчим

3. "Улсын тэргүүний тариаланч"-аар сум, дүүрэг, аймаг, нийслэл улс гэсэн дарааллаар хамгийн өндөр амжилт гаргасан тариаланч дийг шалгаруулна.

4. "Улсын тэргүүний тариаланч"-аар тракторчин, комбайнчин ногоочин, тариаланч, жимсчин, хадланчийг ажлынх нь үр дүнгээр шалгаруулна.

5. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар санаачлан сум дүүргийн хэмжээнд тухайн жилд нэгж талбайгаас хураан авсан дундаж ургацаас 10-аас дээш хувиар илүү ургац авч улс, аймаг орон нутгийн захиралга, гэрээний үүрэг, өөрийн хэрэгцээг 50-иа дээш хувиар давуулсан тариаланчдыг цуваагаар байр эзлүүлж мэргэжлийн төрөл бүр дээр хамгийн дээд амжилт гаргасан ту бүр 1 хүнийг шалгаруулж тодорхойлолтыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тухайн жилийн 11 дүгээр сарын 05-ны дотор ирүүлнэ.

6. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар аймаг, нийслэлийнхээ хэмжээнд тухайн жилд нэгж талбайгаас хураан авсан ургамын дундаж хэмжээнээс 10-аас дээш хувиар илүү ургац авсан тариаланчдыг цуваагаар байр эзлүүлэн мэргэжлийн төрөл бүр дээр хамгийн дээд амжилт гаргасан 1-2 хүний материалыг Хүнс, хөдөө аж ахуйн яаманд 12 дугаар сарын 25-ны дотоо ирүүлнэ.

7. Хүнс, хөдөө аж ахуйн яам нь аймаг, нийслэлээс шалгарсан тариаланчдаас тухайн бүс нутгийн дунджаас 10 хувиас дээш гац авсныг нь цуваагаар байр эзлүүлэн хамгийн дээд амжилт гаргасан 5 хүнийг шалгаруулан Засгийн газарт оруулана.

8. "Улсын тэргүүний тариаланч" шагналыг нэг хүнд давтан гохгүй. Урьд нь "Ургэцмн аварга"-аар шалгарсан иргэд үүнд мварна.

9. Шагналд тухайн хувь хүний өөрийн нь тариалж ургуулан раан авсан ургацын үзүүлэлтийг оруулах бөгөөд бусдаас худалн авсан, ажлын хөлс, өр төлбөрт авсан бүтээгдэхүүн энд маарагдахгүй.

Гурав. Бүрдүүлэх материал

10. "Улсын тэргүүний тариаланч"-аар шалгаруулах хүний тодорлолт, материалыг сүүлийн 3 жилийн үзүүлэлтээр эрхэлсэн лаас нь хамааруулан хансралт хүснэгт, анхтын дагуу бүрүлнэ.

11. Шагналд тодорхойлогдсон тариаланчдын материал нь санүгийн бодит баримт магадалгаагаар баталгаажсан байхын гадна иваа зөрчил, осол гаргаагүй ажилласан тухай орон нутгийн гдаагийн байгууллагын тодорхойлолтыг мөн оруулсан байна.

Дөрөв. Харгалзах үзүүлэлтүүд

12. Улсын тэргүүний тариаланчийг шалгаруулахад дараахь үүлэлтийг харгалзана:

а/ эзэмшсэн тариалангийн талбайгаа атаршуулж ханагүй, эсийг, элэгдэл эвдэрлээс хамгаалах арга, техник, технологи ивж боловсруулах, зурваслан тарих, шин болон эрдэс бордоо ээглэх, сүрэл цацах, ногоон бордуурт хагас болон хөшигт ишт хийх гэх мэт/-ийг зөв хэрэглэсэн байх;

б/ нутгийн онцлогт тохирсон хөдөө аж ахуйн шинэ таримал, ит тариалах талаар идэнх санаачилга гарган тодорхой үр дүнд эсэн, тариалж буй таримлынхаа үрийг өөрөө болон хоршсон ахуйдаа үйлдвэрлэдэг байх;

в/ бусад байгууллагатай байгуулсан аж ахуйн гэрээний эгээ бүрэн биелүүдсэн байх;

г/ хураан авч нийтийн хэрэгцээнд нийлүүдсэн ургацын чанар цмн стандартын шаардлагыг хангасан нь хүлээн авагч, хэрэгчийн буюу улсын төв лабораторийн тодорхойлолтоор баталжсан байх;

д/ урианшлах талбайгаа бүрэн элдэншүүлж онц ба сайн чанартай боловсруулсан урианш нийт талбайн 80 хувиас багагүй хувийг эзэлсэн байхын зэрэгцээ дарва онд тарих үрээ бэлтгэсэн байх;

е/ санхүүгийн хувьд үр ашигтай ажиллаж хугацаа хэтэрсэн баталгаа алдсан өр зээлгүй, бие даан үйлдвэрлэлээ явуулах чадвартай болсон байх.

Тав. Шагнал

13. "Улсын тэргүүний тариаланч"-аар шалгарсан хүмүүст "Улсын тэргүүний тариаланч" үнэмлэх, элгэрийн тэмдэг, 5 лапгийн хос мөнгөн ажга, 100 мянган төгрөгийн мөнгөн шагнал олгоно.

14. "Улсын тэргүүний тариаланч"-ийн шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгийг тохиолдуулан гардуулна.

-----оОо-----

КОМБАЙНЧИ
АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ, АНКЕТ

-ийн

Овог, нэр

Нас, хүйс

Хаана, ямар ажилтай

Ажилласан жил бүгд, үүнээс
тракторчин-комбайнчлаар

Гавьяа, шагнал

Сүүлийн 3 жилийн ажлын
үзүүлэлт

Комбайны марк

Гүйцэтгэсэн ажил

Үүнээс	ангилсан талбай
	цайруулсан тал-
	бай
	жууд хураасан
	талбай

Нэгжээс хурзан авсан
ургац /ин/Осол зөрчилгүй ажилласан
байдал

Трактороор гүй-	жишээл
цэтгэсэн ажил	га

Бусад гүйцэтгэсэн ажил

Материал бүрдүүлж тодорхойлсон
Химж баталсан

/Нэр, албан тушаал,
гарын үсэг, тамга,
тэмдэг/

ТРАКТОРЧ - ИЙН
АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ, АНЖЕТ

Овог, нэр

Нас, хүйс

Хаана, ямар ажилтай

Ажилласан бүгд
жил үүнээс тракторч-
ноор

Гавьяа, шагнал

Сүүлийн 3 жилийн ажлын
үзүүлэлт (он)

Тракторын марк

Гүйцэтгэсэн бүх ажил жинсэм
га үүнээс тээврийн ажил
ийн тн/км

Осол зөрчилгүй ажилласан
байдал

Зарим	тариалсан талбай /га/
ажлын	хураасан талбай /га/
үзүү-	_____
лэлт	хөрс боловсруулсан
/сүү-	талбай жинсэн га
лийн	_____
3 жилд/	хураасан дөрвөн тал-
	бай /га/

	хадсан талбай/га/
	өвс тармаасан талбай
	боосон өвс /тонн/

Материал бүрдүүлж тодорхойлсон:
Уйнаж баталсан

/нэр, албан тушаал
гарын үсэг, тэмдэг/

..... АРСАН СУМЫ
 БОХИЯН, ДОРГО ХАА-Н БОЛООМЫ,
 ТАВГАДАЙ, ЭНХ-УМ, ХАЛДАН ОЮУТОН
 БИЭ АЖИЙН ҮҮҮГЭМТ

..... УРСЫН ЯСЛА АЖИЛЛАХ ИМЭ: ГҮБЭЭ УРСЫН
 ДАГАА ИМЭ МАГНА АНДГА
 АЖИЙН ҮҮГЭМТ: ТЭРИМЭН НЭР: ТАМДАН ОУМ : УН/ГМ : УРСЫН УН/ГМ : УН/ГМ : /ОЮУТОН/ АЖИЙН
 СУВААН 3 ИМ ОУМ : ГМ) ХААН МЭР
 УРСЫН ГЭМЭЭЭЭ

19.
 19.
 19.

Арсан

Матримаа Оюунгалаа Тодорхойлсон!
 Хөдөл Баталсан!

/УРХ. АНДАН СУВААН, ГЭМЭЭ
 УН/ГМ, ТАМГА, ГЭМЭЭЭ/

Засгийн газрын 1994 оны 228 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

**"УЛСЫН САЙН МАЛЧИН", "УЛСЫН ТЭГ, ҮҮНИЙ
ТАРИАЛАНЧ"-ИЙН ҮНЭМЛЭХ, ЭНГЭР, ИЙН
ТЭМДГИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

**Нэг. "Улсын сайн малчин"-д олгох үнэмлэх, тэмдэг,
биет шагналын тодорхойлолт**

а) "Улсын сайн малчин"-ы үнэмлэх

"Улсын сайн малчин"-ы үнэмлэх нь цэнхэр өнгийн хавтастай байх бөгөөд хавтасны нүүрэн талд Монгол Улсын төрийн сүлдийг дүрсэлж, түүний доод хэсэгт "Улсын сайн малчны үнэмлэх" гэж бичиж хэвлэсэн байна. Үнэмлэхийн доторхи хуудас нь монголог өнгийн түмэн насан хээ бүхий бор шаргал дэвсгэртэй байх бөгөөд зүүн гар талын хэсэгт төрийн соёмбо, монгол орны байгаль, 5 хошуу малын зураг, баруун гар талын хэсэгт төрийн соёмбо, "Улсын сайн малчны үнэмлэх, түүний дугаар, шагнагдсан тухай шийдвэрийн товч утгыг бичиж Монгол Улсын Ерөнхий сайд гарин үсэг зурахаар хэвлэсэн байна.

б) "Улсын сайн малчин" тэмдэг

Уг тэмдэг хоёр хэсгээс бүрдэнэ. Эх биеийн хэсэг нь 40 мм-ийн голч бүхий хэмжээтэй тойрог байх бөгөөд түүний дотор талын бага тойрог нь цэнхэр ногоондуу дэвсгэр дээр соёмбыг товгордуу байдалаар шар өнгөөр дүрсэлсэн байна. Соёмбоны хоёр талаар "Улсын сайн малчин" гэж монгол бичгээр шар өнгөөр бичнэ. Их тойрогт 5 хошуу малын толгойн дүрсийг хүрэн улаан дэвсгэр дээр шар өнгөөр гаргасан, бусад хэсэг нь цагаан өнгөтэй байна.

Зүүлтийн хэсэг нь 30 мм урт, 15 мм өргөн, доод талдаа гурвалжилсан хэсэгтэй, үүний голын их өргөн 5 мм хэмжээтэй бөгөөд дундаа хөх, 2 тал нь улаан өнгө (төрийн далбааны)-тэй байна. Тэмдгийн зузаан нь 2 мм байна. Зүүлт нь сүлдүүр зүү мэт байна.

**в) "Улсын сайн малчин"-д олгох мөнгөн
азарганы тодорхойлолт**

"Улсын сайн малчин"-д дурсгал болгон 10 лангийн цалин цагаан мөнгөөр урласан азарганы дүрс олгох бөгөөд азарганы суурь хэсэгт "Улсын сайн малчин" 199 . . . он гэж бичнэ.

г) "Улсын тэргүүний тариаланч" -ийн үнэмлэх

"Улсын тэргүүний тариаланч"-д өгөгч үнэмлэх нь бор шаргал өнгийн материалаар бүрсэн зөөлөвч бүхий хавтастай, хавтасны вүүрэн талд Монгол Улсын Төрийн сүлд, "Улсын тэргүүний тариаланч" гэж алтан үсгээр товойлгож бичсэн байна.

Үнэмлэхийн дотор тал нь монголог өнгийн түмэн насан хээ бүхий шар дэвсгэртэй байх бөгөөд түүн гар талын хэсэгт төрийн соёмбо, монгол орны байгаль, газар тариаланг харуулсан зураг, баруун гар талын хэсэгт төрийн соёмбо, "Улсын тэргүүний тариаланч"-ийн үнэмлэх, түүний дугаар, шагнагдсан тухай шийдвэрийн товч утгыг бичиж, Монгол Улсын Ерөнхий сайд гарми үсэг зурахаар хөвлөсөн байна.

д) "Улсын тэргүүний тариаланч"-ийн энгэрийн тэмдэг

"Улсын тэргүүний тариаланч" энгэрийн тэмдэг нь 50,35 мм-ийн тойрогт багтах төрсөн 2 алтан шармал таван хошууны голд "Алтан соёмбо"-ыг товойлгон урласан байна.

Алтан соёмбыг тойрсон дээд хэсэг нь цэнхэр (тэнгэр), доод хэсэг нь ногоон (газар) дэвсгэр бүхий зайд алтан шаргал өнгөөр товойлгон дээд ховоогоор "Тариаланч" гэж бичиж, доод хэсэгт хүрд дүрсэлэн 2 тийш тариан түүрүү салбарлуулсан байна.

Том таван хошууны үзүүрүүдийг жижиг таван хошуутай дүй-хүйцээр тайрч богиносгосон бийхэн дээр дунд нь улаан, цэнхэр, удаан өнгөөр төрийн далбааг дүрсэлсэн байна.

Жижиг (наад талын) таван хошуу нь дунд хэсгээр наашаа бага зэрэг товойсон дээд хошууны үзүүрт 3 мм-ийн цагираг суулгаж өгсөн байна.

Тэмдгийн дээд хэсэг 30х13х1,2 мм-ийн хэмжээтэй ба дунд хэсгээс доошоо 3 мм орчим сунасан үзүүрт нь 3 мм голчтой цагираг суулгаж өгнө.

Уг цагирагийн дээр сунгасан хэсэгт төрийн далбаа дүрсэлж 2 тийш тариан түүрүүг дээш нь харуулан шаргал өнгөөр товойлгон дүрсэлсэн байна. Цаад дэвсгэр нь цайвардуу бор, шар өнгө хосолсон туривсалсан талбай маягтай байх ба дээр нь шаргал өнгөөр товойлгож "Улсын тэргүүний" гэж бичсэн байна.

Тэмдгийн дээд, доод 2 хэсгийг гуравдагч шармал цагирагаар холбож ард нь зүүх бэхэлгээ хийнэ.

е) "Улсын тэргүүний тариаланч"-д олгох мөнгөн
аяганы тодорхойлолт

Дунд гарын хар ба хүрэн хуванцар аягыг 5 дангийн мөнгөөр
мөнгөлж, аяганы суурь хэсгийг түмэн наст алхан хээгээр чимэг
дэнэ.

Аяганы амсар ба суурь хэсгийн дундахь эвйд "Улсын тэргүүний
тариаланч", "199 . . он" гэж бичнэ.

Аяганы голч 10-12, өндөр 5-6 см орчим байна.

-----оОо-----

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД
ШҮҮХИЙН ТОГТООЛ

1995 оны 1 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар
хот

ДЭЭД ШҮҮХИЙН БҮГД ХУРЛЫН 1993
ОНЫ 25 ДУГААР ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 169 дүгээр тогтоолын 2 дугаар хэсрэлтээр баталсан Илдвэрийн газрын хувьчлах эд хоронгийн үнэлгээний журмын 3-р бүлгийн 12 дахь хэсгийн "... БНМАУ-ын Засгийн газрын мч хувьчлалын комиссын шийдвэр эцсийнх болно", мөн тогтоолын 4 дугаар хэсрэлтээр баталсан Дуудлагын худалдааг зохион байгуулж явуулах нийтлэг журмын 6 дугаар бүлгийн 17 дахь хэсгийн "... Засгийн газрын өмч хувьчлалын комиссын шийдвэр эцсийнх болно" гэсэн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дугаар зүйлийн 14 дэх хэсэг, 47-р зүйлийн 1,2 дахь хэсгийн заалтуудыг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн эцсийн 1994 оны 8 дугаар сарын 29-ний 8 дугаар дүгнээтийг онгол Улсын Их Хурлын 1994 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор хүлээн зөвшөөрч Монгол Улсын Засгийн газрын 1994 оны 12 дугаар сарын 28-ны 226 дугаар тогтоолоор гэрх тогтоолын заалтуудыг хүчингүй болгосон тул Дээд шүүхийн 1993 оны 2 дугаар сарын 11-ний 25-р тогтоолд өөрчлөлт оруулах аардлагатай байгааг тэмдэглэн Монгол Улсын Дээд шүүхээс ЭГТООХ нь:

1. Өмч хувьчлах тухай хуулийн зарим зүйл, хэсгийг тайлбарлах тухай Монгол Улсын Дээд шүүхийн Бүгд хурлын 1993 оны 3 дугаар сарын 11-ний 25 дугаар тогтоолын 3-р заалтыг "3. Шүүх, Илдвэрийн газрын эд хоронгийг хувьчлах талаар холбогдох байгууллагаас гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн тухай гомдлыг мч хувьчлах тухай хуулийн 10-р зүйлд заасны дагуу уул шийдвэрийг гаргасан байгууллагыг харьяалах дээд байгууллага нь шийдвэрлэсний дараа, эд хоронгийг дуудлагын худалдаагаар худалдах элэн хувьчлагдах эд хоронгийн үнэлгээний талаар гарсан гомдлыг Засгийн газрын 1991 оны 6 дугаар сарын 7-ны 169-р тогтоолын

2 дугаар хавсралтаар баталсан "Үйлдвэрийн газрын хувьчлах э; хоронгийн үнэлгээ журам"-ын 4-р бүлгийн 12-р зүйл, мөн тогтоолын 5-р хавсралтаар баталсан "Дуудлагын худалдааг зохион байгуулж явуулах нийтлэг журам"-ын 6-р бүлгийн 17-д заасна дагуу Засгийн газрын Өмч хувьчлалын комисс тогтоол гаргаж шийдвэрлэсний дараа, хувьчлалтай холбогдон үүссэн эд хоронгийн маргааныг шууд хүлээн авч шийдвэрлэнэ" гэж оорчлон найруулсугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан маргаан нь Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 161-р зүйлийн 1-дэ; хэсэгт заасан төрийн захиргааны байгууллагын гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн тухай гомдол тул эдгээр гомдлыг хувьчлах тухай шийдвэр гаргасан, үнэлгээ зохиосон, дуудлагын худалдаа зохион явуулсан байгууллагын шийдвэрийг хянаж шийдвэрлэсэн байгууллагын оршин байгаа, хувьчлалтай холбогдон үүссэн э; хоронгийн маргааныг тухайн эд хоронгийг хувьчлах шийдвэр гаргасан байгууллагын оршин байгаа газрын харьяалах сумыг буюу сум дундын, дүүргийн шүүх тус тус хянан шийдвэрлэх байхаар харьяалал тогтоосугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН

ШҮҮГЧ

Ж. ДАШДОРЖ

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ:

Ерөнхий эрхлэгч	Н.Ринчиндорж
Нарийн бичгийн дарга	Сан. Жаргалсайхан
Гишүүд	Т.Баасансүрэн Ч.Бануу Б.Ганбат Б.Янжинлхам
Техник редактор	Т.Сарантуяа
Уншиж хянасан	Сан. Жаргалсайхан Б.Янжинлхам

Үйлдвэрт шилжүүлсэн 1995 оны 3-р сарын 6-нд, Өрөлтөд 1995 оны 3-р сарын 6-нд, Хэвлэлтэд 1995 оны 4-р сарын 3-нд. Цаасны хэмжээ 60х90/16. Хэвлэлийн хуудас 8,0, хэвлэсэн тоо 4800 ширхэг.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр